

НИЙГМИЙН САЛБАРЫН ХУВЬЧЛАЛЫН ТУРШИЛТ: “СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ, ХУВЬЧЛАЛЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ ХӨДӨӨ ОРОН НУТАГТ”

Судалгааны зорилго:

Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын хүрээнд соёл, урлагийн байгууллагуудын хууль эрх зүйн орчинг судалж, энэ нь бусад хууль тогтоомжуудтай хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийх нь энэхүү кейс судалгааны зорилго юм. Мөн хөдөө орон нутагт соёл, урлагийн байгууллагуудад өөрчлөлт, шинэчлэлт, хувьчлал хэрхэн хийж, ямар үр дүнд хүрч байгааг тодорхой аймаг, орон нутгийн жишээн дээр судлах нь судалгааны дэд зорилго мөн.

Судалгааны арга зүй ба судлах зүйл.

Кейс судалгааны нэг үндсэн арга болох нягтлах буюу хайгуул шинжилгээ хийх аргыг ашиглан соёл, урлагийн байгууллагуудад шинэчлэл, өөрчлөлт, хувьчлал хийх эрх зүйн орчин ямар байдалтай байгааг нягтлан, түүний цаана ямар асуудлууд оршиж байгааг тодруулах, түүнийгээ хөдөө орон нутгийн байгууллагуудын өнөөгийн байдлаар баталгаажуулж, сонирхлын бүлгүүдийн санаа бодол ба баримтанд тулгуурлан асуудал дэвшүүлэх үүднээс үе шат, дэс дараалалтайгаар уг судалгааны ажлыг хийлээ.

Холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүдийг харьцуулан шинжлэх, төв, орон нутгийн гүйцэтгэх засаглалын шийдвэр, түүнийг хэрэгжүүлсэн байдалтай танилцах, шийдвэрийг хэрэгжүүлэгчидтэй ярилцлага хийх, олон нийтийн санаа бодлыг тандах, бодит байдалтай танилцах, хөдөө орон нутгийн соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийх, соёл, урлагийн талаарх онолын ном зохиолыг судлах, мэргэжилнүүдтэй ярилцлага хийх зэрэг аргыг ашиглав.

Сэлэнгэ, Төв, Дархан – Уул, Дорнод, Багануур зэрэг аймаг хотын соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаа, түүний чанар хүртээмж, аймаг орон нутгийн соёлын бодлого шийдвэрийн хэрэгжилт ямар байгаа, хуримтлагдсан асуудлууд нь юу байгааг тодруулах, тэр нь үндэсний бодлоготойгоо хэрхэн уялдан зохицож байгааг харуулах гэж оролдсон болно.

Соёлын тухай орчин үеийн үзэл онолын тойм ба Монголын соёлын өнөөгийн байдал.

Соёл урлагийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхэд юуны урьд соёлыг өөрийг нь гүн ухаан, соёл судлалын талаас зөв тодорхойлох явдал чухал билээ. Энэ бол хэрэг дээрээ боловсруулж хэрэгжүүлэх гэж байгаа бодлогынхоо объект буюу оногдохуун, үйлчлэх хүрээг олж тогтооно гэсэн үг. Манай оронд “соёл” гэдгийг их төлөв урлаг уран сайхан, соёл – гэгээрлийн байгууллагаар төлөөлүүлэн ойлгож ирсэн бөгөөд ийм өрөөсгөл төсөөллийн ул мөр одоо хүртэл бүрэн арилаагүй байна.

/"Соёл урлагийн бодлогын шинжлэх ухааны үндэс", Ж.Долгорсүрэн, Н.Сарантуяа, Б.Сумъяа, Улаанбаатар -2003 он, 5 дахь тал./

ЮНЕСКО-гийн “Соёлын бодлогын асуудал эрхэлсэн дэлхий дахины бага хурал”-ын 1982 оны тунхаглалд:

Соёл гэдэг нь нийгмийн материаллаг зүйл болон оюун бодол, мэдлэг ухаан, сэтгэлийн хөдөлгөөний нийтлэг шинжүүдийн цогцлол мөн бөгөөд зөвхөн төрөл бүрийн урлагийг төдийгүй, аж төрөх ёс, хүмүүний оршин амьдрахуйн үндсэн ёс журам, үнэт зүйлс, уламжлал, итгэл бишрэлийн тогтолцоог өөртөө багтаадаг” гэж тодорхойлжээ.

Нийгмийн хөгжилд соёлын гүйцэтгэх үүргийг өндөр үнэлж, түүнд онцгой анхаарал тавих болж байгаа нь орчин үеийн нийгэм, улс төр, онолын сэтгэлгээний нэгэн онцлог шинж болж байна. ЮНЕСКО, түүний хүрээнд ажилладаг олон улсын байгууллагууд нийгмийн хөгжлийг тодорхойлогч гол хэмжүүр нь соёл мөн гэдэг нэгдсэн ойлголтод хэдийнээ хүрчээ.

Орчин үеийн соёл судлалд нийтийн зөвшөөрөн хүлээж байгаагаар соёл нь:

1. нийгмийн ой санамжийн,
2. нийгмийн туршлагыг дамжуулагчийн,
3. хүмүүсийг иргэншүүлэн хөгжүүлэгчийн үүргийг гүйцэтгэдэг билээ. ...

Оршин буй тухайн нийгмийн харилцаа, улс төр, хууль цааз, үзэл суртлын тогтолцоо нь соёлын хөгжилд түлхэц өгөх юм уу, эсвэл түүнийг боож саатуулах үүрэг гүйцэтгэдэг байна. Үүнд:

1. Нийгмийн тогтолцоо нь соёлоос эрч хөдөлгөөнөөр дутуу байгаа тохиолдолд соёлын дэвшил хөгжлийг саатуулж, чөдөрлөн боох, өмнөх үеийнхний бүтээсэн үнэт зүйлсийг бусниулан сүйтгэх, үгүйдээ л түүнийг нийгмийн эрэлт шаардлагад нийцүүлэн бүрэн дүүрэн ашиглах бололцоог хязгаарлахад хүрдэг.
2. Нийгмийн тогтолцоо дэвшилт чиглэлээр огцом өөрчлөгдөж буй үед соёл нь уламжлалдаа хэт баригдан шинэчлэлийг огоорч, хэсэг хугацаанд нийгмийн хөгжил дэвшлийн хүчин зүйл байх үүргээ гүйцэд биелүүлж чадахгүй байж болно.
3. нийгэм, соёл хоёр зохицон тэнцвэртэй хөгжиж байгаа тохиолдолд бие хүн зөрчилгүй, зохирол нийцэлтэй хөгжиж, нийгэм нь соёл бүх талаар цэцэглэн хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлж, соёл нь нийгмийн хөгжлийг түргэтгэгч хүчирхэг дотоод хөдөлгүүр болдог байна.

*“Соёл урлагийн бодлогын шинжлэх ухааны үндэс”, Ж.Долгорсүрэн, Н.Сарантуяа, Б.Сумьяа.
Улаанбаатар – 2003 он. 38 – 39 дэх тал.*

Сүүлийн жилүүдэд тус орны соёлын харилцааны нийгмийн орчин хэрхэн өөрчлөгдөж байгааг дараах хэдэн чиглэлээр авч үзэж болох юм. Үүнд:

- Оюун санааны амьдрал хуучин суртлаасаа ангижирч, либералчлагдсан, сэтгэлгээний чөлөөт, олон ургальч байдал эрх зүйн талаар баталгаажсан,
- Соёл урлагийн гадаад орчин түргэн өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор хүн амын, ялангуяа өсвөр залуу үеийнхний оюун санааны шинэ шинэ хэрэгцээ үүсэж, төлөвшиж байгаа,
- Монголчуудын үндэсний мэдрэмж сэргэж, уламжлалт шашин шүтлэгээ сэргээн хэрэглэх эрмэлзэл хүчтэй болж, богино хугацааны дотор олон тооны сүм хийд, хурал номын газар байгуулагдан хүн амын янз бүрийн хэсгийн амьдралд шашны гүйцэтгэх үүрэг эрс нэмэгдэж байгаа хийгээд сүүлийн хэдэн зуунд манайд байгаагүй харийн шашин, түүний янз бүрийн урсгалууд чөлөөтэй нэвтэрч, хүн амын тодорхой хэсгийн дунд чөлөөтэй болж байгаа,

- Соёл урлагийн удирлагад хэт төвлөрлийг сааруулж, орон нутаг, үндсэн байгууллага, хувь хүмүүс, уран бүтээлчдийн бие даасан байдлыг дэмжих болсон,
- Соёл урлагийн гадаад харилцаа нээлттэй болж, бусад улс орон, ард түмнүүдийн соёл чөлөөтэй нэвтэрч байгаа,
- Нийгмийн амьдралын бүх хүрээ зах зээлийн харилцаанд шилжиж байгаа нөхцөлд соёлын удирдлага, менежмент гүйцэд шинэчлэгдээгүй, удирдлагын хуучин хэлбэрээс бүрэн ангижирч чадаагүй байгаа,
- Зах зээлийн нөхцөлд соёл, урлагийн байгууллагыг хэрхэн ажиллуулах үндэсний үзэл баримтлал, стратегийн чиг шугам тодорхой бус байгаагийн улмаас тэдгээр байгууллагын бие дааж оршин амьдрах чадвар сул, хөрөнгө санхүүгийн бэрхшээлтэй байнга учирч байгаа,
- Монгол орон нийгмийн огт өөр харилцаанд шилжиж байгаа учраас хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, амьдралын гүн ухаан, үйл ажиллагааны зорилго чиглэл, аж төрөх ёс, зан суртахууны тулгуур үнэт зүйлс богино хугацаанд үндсээрээ өөрчлөгдөж байгаа боловч шинэ үзэл баримтлал, үнэт зүйлсийн тогтолцоо гүйцэд төлөвшиж чадаагүй байгаа.

Эдгээр өөрчлөлтийн дийлэнхи хэсэг нь шинэ нийгмийн зорилго, шинж чанарт нийцэн тохирсон эерэг шинжийг агуулсан байх хэдий ч түүний зэрэгцээгээр сөрөг талын үр дагавар ч багагүй гарч байгааг үгүйсгэх аргагүй юм. Тийм сөрөг үр дагаваруудын дотроос хүний оршихуй хийгээд нийгмийн амьдралд учруулах **хор хохирлоороо хамгийн их нь ёс суртахууны уналт юм**. Энэ нь юуны урьд хүн амын нилээд хэсгийн амьдралын гүн ухаан сөрөг чиглэлээр өөрчлөгдөж, монголчуудын олон мянган жилийн уламжлалтай хамтач, нөхөрсөг тусч зан алдагдаж нүүдэлчдийн хүмүүн оршихуйн үзэл санааны гүнзгий үндэс бүхий хамтран амьдарч аж төрөх ёсны суурь баримтлал нийгэм эдийн засгийн хямралт байдал ужгирч удаашран, ядуурал газар авснаас эрс өөрчлөгдөж, зөвхөн хар амиа бодож, хувиа хичээсэн “бийсэг” хувьч үзэл ердийн ухамсрын түвшинд амьдралын гол “философи” нь болж хувирч байна.¹

Сүүлийн жилүүдэд манай нийгэмд ихээхэн газар авч байгаа сөрөг үзэгдлийн нэг бол нийгмийн дотоод задралын үйл явц хүчтэй болж байгаа явдал мөн. Тус оронд ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжиж байгаа эерэг үзэгдлийн зэрэгцээгээр үндэсний дотоод задралын үйл явц гүнзгийрэн хүмүүс нас хүйс, шашин шүтлэг, яс угсаа, үзэл бодол, нам улс төрийн байгууллагын харьяаллаараа ялгаран талцаж, сөргөлдөх уур амьсгал нийгмийн бүтцийн эс ширхэг бүрд нэвтрэн газар авч байгаа аюултай үзэгдэл ажиглагдах болж байна. Энэ учраас урлаг, уран сайхан, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн зугаацуулах цэнгээх, сүр дуулиантай сенсаци, адал явдал мэтээр хөөцөлдөхөөсөө илүүтэйгээр нийгмийг эерэг байдлаар зохион байгуулах, хүмүүсийг нэгтгэн зангидах үүргийг нь хүчтэй болгох, соёлын үнэт зүйлс, байгууллагуудыг хүний эрч хүч, чадамж бүтээлч үйл ажиллагаанд чиглүүлэх хэрэгтэй байна.²

Судлаачдын үзэж байгаагаар өнөө эрин үеийн соёлын бодлогын олон улсын нийтлэг чиглэл нь дараах байдалтай байна. Үүнд:

- *Соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцох бололцоог аль болох бүрэн дүүрэн хангах,*

¹ Монголын Урлагийн зөвлөл, СУИС, “Соёлын бодлого, соёл, урлагийн байгууллагын санхүүжилт”. Улаанбаатар – 2003, 7 – 8 дахь тал.

² Мөн тэнд, 10 дахь тал.

- *үндэстэн ястны соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах,*
- *үндэсний хэлний цэвэр ариун байдлыг сахин хамгаалах,*
- *соёлын удирдлагын тогтолцоон дахь хэт төвлөрлийг саармагжуулан аль болохоор орон нутаг, үндсэн байгууллагын бие даасан байлыг хангах,*
- *соёлын санхүүжилтэнд төрийн болон хувийн хэвшлүүдийг өргөн татан оролцуулж, соёл урлагт хувийн хэвшлийнхээс хөрөнгө оруулах явдлыг улсын зээл, татварын бодлогоор дэмжих,*
- *соёлын харилцааг аль болохоор нээлттэй байлгах*

Дэлхий нийтийн нийтлэг чиг хандлагаар баримжаа авахын зэрэгцээ шинжлэх ухааны үндэс бүхий соёлын зөв бодлогыг тодорхойлоход үндэснийхээ соёлын онцлогийг харгалзан үзэх явдал зайлшгүй чухал билээ. Соёл судлалын үүднээс манай орны түүхэн онцлог нь дараах хэдэн зүйлд юуны урьд оршино. Үүнд:

1. *Монгол бол эртний соёлт орон*
2. *Монгол бол дэлхийн соёлын хэд хэдэн хэв маягийн дотроос Дорнын соёлын хүрээнд хамрагддаг орон.*
3. *Манай орон бол буддын соёлт орон.*
4. *Монгол улс нь олон овогтны улс.*
5. *Манай орны өнөөгийн соёлын харилцааны нэгэн онцлог бол нүүдлийн болон суурьшмал иргэдийн соёл зэрэгцэн оршиж байгаад оршино.*

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн Хуульд “Түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байх”, “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийн өөрийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн” болох хийгээд тус улсын ард иргэд хүн бүр “Соёл урлаг шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг хүртэх эрхээр” адил тэгш хангагдсан байх эрхийг батлан тунхагласан билээ. 1996 онд Улсын Их хурлаас батлан гаргасан “Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого” хэмээх баримт бичиг, “Зохиогчийн эрхийн тухай” /1993/, “Патентын тухай” /1993/, “Соёлын тухай” /1996/, “Соёлын өвийг хамгаалах тухай” /2001/ зэрэг Монгол Улсын хуулиудад төрөөс баримтлах соёлын бодлогын үндсэн чиглэл, зарчмуудыг тодорхойлжээ. Соёл, урлагийн байгууллагууд нь 2003 оноос эхлэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

Судлаачдын үзэж байгаагаар соёл урлагийн эрх зүйн орчинг “нэг талаас соёл урлагийн байгууллага, уран бүтээлчид, нөгөө талаас олон түмэн, нийгмээс соёл урлагийн үйл ажиллагааг явуулах хүсэл зориг, түүнийг хэрэгжүүлэхэд баримталж буй хэм хэмжээ, удирдлага зохион байгуулалтын нэгдмэл тогтолцоо мөн” гэж тодорхойлжээ.³ Тэр нь ерөөс “эрх зүй гэдгийг нийгмийн харилцаанд оролцогчдын харилцан зөвшөөрөлцсөн хүсэл зориг, бие хүн, тэдгээрийн хамт олны эрх, эрх чөлөөний хэмжүүр, нийгмийн янз бүрийн ашиг сонирхол, хэрэгцээг хангах хэрэглүүр, төрийн албадлагаар хангагдаж хамгаалагдаж байгаа хэм хэмжээний тогтолцоо мөн” /Ч.Нямсүрэн 2001, 75./ гэсэн тодорхойлолтод үндэслэн соёл урлагийн үйл ажиллагааны эрх зүй нь нийгмийн янз бүрийн давхрагын ашиг сонирхол дээр үндэслэгдсэн соёлын үнэт зүйлсийг бүтээх, хадгалж, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, ашиглах, өвлүүлэх, судлах, сурталчлах зэрэг соёлын харилцааны хэм хэмжээний зохицуулалтын тогтолцоо мөн. Энэ тогтолцоо нь аль ч улс орны тухайд эрх зүйн орчны дотоод, гадаад хоёр талт шинжийг агуулан оршдог

³ Ж.Долгорсүрэн, Н.Сарантуяа, Б.Сумъяа, Соёл урлагийн бодлогын шинжлэх ухааны үндэс, Улаанбаатар, 2003 он, 96 дахь тал

байна. Иймд монголын соёл урлагийн эрх зүйн орчныг дотоод гадаад хоёр талт шинж бүхий үндсэн дөрвөн түвшинт бүтэцтэй нийгэм, улс төр, эдийн засаг, ёс суртахууны болон олон улсын харилцааны хэм хэмжээгээр нөхцөлдөн бүрэлдсэн систем хэмээн үзэж болмоор байна.⁴

Соёл урлагийн байгууллагуудын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын холбогдолтой хууль эрх зүйн актууд бүхэлдээ соёл, урлагийн бодлого, зарчим, чиг үүргийг тогтоосон хууль, эрх зүйн акт, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ЗГ-ийн хөтөлбөр, тогтоол шийдвэр, соёл урлагийн төрийн захиргааны төв байгууллагын тушаал, шийдвэр, аймаг, орон нутагт соёлын бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бүх шатны Засаг даргын захирамж, тогтоол, шийдвэр, соёл урлагийн анхан шатны байгууллагуудын даргын тушаал, дүрэм журам гэсэн үндсэн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэхтэй

холбогдсон шат шатны хууль эрх зүйн акт, нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагуудын жагсаалт батлах тухай ЗГ-ийн тогтоол, БСШУЯ, ТӨХ-ы холбогдох заалт болон соёл урлагийн олон улсын конвенци, гэрээ, хэлцэл, санамж бичиг зэргээс бүрдэнэ.

Эдгээр эрх зүйн баримт бичгүүдээс соёл, урлагийн бодлого, түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, зарчим, удирдлага, санхүүжилтийн тогтолцоог тодорхойлсон эрх зүйн орчин хир бүрдсэн, тэр нь хөдөө орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаад үнэлгээ өгч, бусад хууль тогтоомжтой уялдуулах хэрэгцээ шаардлага ямар байгааг тодорхойлох зорилгыг тавьсан билээ. Энэ хүрээнд эхний ээлжинд соёл урлагийн эрх зүйн орчинд шинжилгээ хийж үнэлгээ өгье.

Эдгээр бодлогын баримт бичиг, хуулинд соёл нь өөрийн мөн чанар, нийгэмд гүйцэтгэх үүрэг талаасаа хэрхэн тусгагдсаныг түүхэн дарааллын хувьд авч үзье.

⁴ Мөн тэнд, 97 дахь тал.

Монгол Улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1994 оны 9 дүгээр сарын 10 –ны өдрийн 20 тоот тогтоол. “Соёл, урлагийн байгууллагуудыг хувьчлах тухай”					
Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт	Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт	Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл	Соёл, урлагийн байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд	Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагыг бэхжүүлэх үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар
“үндэсний оюуны үнэт зүйлсийг хадгалан хөгжүүлэх, хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлсийг баримжаа болгосон үзэл санааг ард иргэдийн оюуны цөм болгон төлөвшүүлэхэд урлаг, уран сайхны арга хэрэгслүүдийг дээд зэргийн үр өгөөжтэй ашиглах”	<p>“гол зорилго нь зах зээлийн нөхцөлд зохицсон соёлын тогтолцоо бүрдүүлж, эдийн засгийн үндэс суурийг тавихад оршино.”</p> <p>“соёл, урлагийн салбарт төрийн, олон нийтийн, хувийн өмчийн байгууллагуудын зүй зохистой хослолыг бий болгоход өмч хувьчлалын болон удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааг чиглүүлэх болно”</p> <p>“хувь хүн өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломж олгох”</p>	<p>“дор дурьдсан соёл, урлагийн байгууллагуудыг төрийн өмчид үлдээн ажиллуулна... Соёлын төв өргөө ..., улсын музей, үзмэрийн газрууд, орон нутгийг судлах музейнүүд, музейн үзмэр сэргээн засварлах газар, уран зургийн галерей ..., төв, хот, орон нутгийн ... номын сангууд ..., баримтат кино, архивын байгууллагууд, ... Монгол кино нэгтгэл, төв орон нутгийн кино зургийн фондууд, ... УАДБЧ, УФ, СУАТ, ҮЖАТ, УХЗТ, киноны хүрээлэн, ... Соёмбо хэвлэлийн газар, Үнэт цаас Компани ...”</p> <p>Өмч хувьчлалын комисс нь СЯ, орон нутгийн ЗДТГ-тай хамтран ... гэрээ байгуулж ... тухайн байгууллагын үйл ажиллагааны агуулга, чиглэлийг өөрчлөхгүй байна. Үйл ажиллагааны үндсэн чиглэл давамгайлж, дагалдах бусад үйлчилгээ явуулахыг зөвшөөрнө. .. Уран бүтээл, үйлчилгээний чанарын төлөө</p>	“Төрийн болон төрийн өмч давамгайлсан соёл, урлагийн байгууллагуудад хууль тогтоомжоор хориглоогүй нөхцөлд нэмэгдэл орлого олох зориулалтаар ажил үйлчилгээ явуулахыг зөвшөөрнө...”	<p>“Сумдын болон нийслэлийн дүүргүүдийн соёлын төв, клуб, нүүдлийн кино цэгүүдийг хувьчлах асуудлыг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газартай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.</p> <p>Аймгуудын хөгжимт драмын театр, чуулгуудыг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан газар байлгаж, цаашид төрөлжүүлэх, бүсчлэх, үйл ажиллагааны хүрээг өргөтгөх, зохион байгуулалтын хэлбэрийг нь оновчтой болгох</p>	<p>“Олон нийтийн үүсгэл санаачилгын соёл, урлагийн байгууллагуудын өмчийн асуудлыг төрийн зохих хууль тогтоомжийн дагуу авч үзэж шийдвэрлэнэ. ...</p> <p>Соёл, урлагийн байгууллагуудыг хувьчлалд хамруулснаар бий болох орлогыг хувьчлалын санд төвлөрүүлж, соёл урлагийн төслүүдийг санхүүжүүлэхэд түүний зохих хэсгийг зарцуулна.</p> <p>Хувьчлагдсан соёл урлагийн байгууллагуудад нийт ард түмний болон үндэсний эрх ашгийн үүднээс төрөөс зохих санхүүгийн болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу авч үзэж шийдвэрлэж байна.</p>

		<p>өрсөлдөөнийг өрнүүлж соёл, урлагийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэх, ... хэрэв эдгээр нөхцөл болзлыг хүлээн зөвшөөрөхгүй буюу зөрчих тохиолдолд өмчлөгчтэй хийх гэрээг цуцалж, гарсан хохирлыг арилгуулах арга хэмжээг авна ... гэсэн заалтыг тодорхой тусгана.</p>		<p>арга хэмжээ авна...”</p>	
<p><i>Энэ нь соёл, урлагийн салбарт бүтцийн өөрчлөлт хийхийг оролдсон анхны оролдлого юм. Үндэсний болон хүн төрөлхтөний нийтлэг оюуны үнэт зүйлсийг ард иргэдийн оюуны цөм болгон төлөвлүүлэхийг зааж өгсөнөөрөө ач холбогдолтой боловч соёл, урлагийн нийгэмд үзүүлэх үр нөлөө, гүйцэтгэх үүргийн талаар тодорхой заагаагүйгээрээ учир дутагдалтай. Уг тогтоолыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн хангалттай орчин бүрдээгүй байсны улмаас хэрэгжиж чадаагүй. Гэхдээ уг тогтоол нь соёл, урлагийн салбар нь “төрийн, олон нийтийн, хувийн байгууллагуудын” зохистой хослолоос бүрдэх ба “соёл, урлагийн төслүүдийг санхүүжүүлэх” “санг” байгуулах, соёл урлагийн байгууллагуудыг өмчийн хэлбэр харгалзалгүйгээр “төрөөс зохих санхүүгийн болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ажлыг мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу авч үзэж шийдвэрлэж байх” тухай чухал санааг анхлан гаргаснаараа чухал ач холбогдолтой болсон юм.</i></p>					
<p>Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого.</p>					
<p>Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт</p>	<p>Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт</p>	<p>Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл</p>	<p>Соёл, урлагийн байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд</p>	<p>Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагыг бэхжүүлэх үндсэн чиглэл</p>	<p>Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар</p>
<p>- улс орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг эрхэмд үзэж, - монголын соёл нь тус улсын</p>	<p>- нийгмийн хямрал, элдэв нөхцөл шалтгааны улмаас монголын соёл устах, бусад үндэстний соёлд уусан замхрах, өв уламжлал, ёс заншил алдрах, оюун санааны амьдрал ядууран доройтохоос бүх талаар сэрэмжлэх, -үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулан хөгжүүлэх</p>	<p>3.1. иргэнийг багаас нь үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжилтэй болгох эрэмбэ дараатай ажлыг бүх шатны боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгох 3.7. дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан бүтээл дэлгэрүүлэхэд төрөөс хяналт тавьж,</p>	<p>3.5. урлагийн бүх төрөл зүйлийг анхааран хөгжүүлж, үндэсний уламжлалт, сонгодог болон хүүхдэд зориулсан урлаг, баримтат</p>	<p>3.16 хөдөөгийн хүн амд соёл, урлагаар үйлчлэх, тэдний ерөнхий соёлын түвшинг дээшлүүлэх,</p>	<p>3.2. байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс соёлын үнэт зүйлсийг бүтээх, түүх соёлын дурсгалт зүйлийг судалж, сурталчлах, хадгалж хамгаа-лах үйл ажиллагааг <u>бүх талаар дэмжих</u> 3.3. үйлдвэрлэл, үйлчилгээнд үндэсний</p>

<p>тусгаар тогтнол, аюулгүй байдлын нэгэн баталгаа, монголчуудын үндэсний бахархал, эв нэгдлийн уг сурвалж, хөгжил дэвшлийн чухал хөшүүрэг мөн болохыг онцлон анхаарч, - хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээг өргөтгөх, урлагийн бүх төрлийг хөгжүүлэх, үндэсний соёлоо үр удамдаа өвлүүлэх, соёлыг өргөн утгаар ойлгож, түүнийг нийгэм, эдийн засгийн бусад салбартай нягт холбох зорилгоор төрөөс тогтвортой баримтлах соёлын бодлогыг тодорхойлж байна.</p>	<p>- монголын эрт эдүүгээгийн түүх, соёлын дурсгалт зүйлс, сан хөмрөгийг үндэсний эрхэм баялаг гэж үзэж төрийн хамгаалалтад байлгах, - монголын олон овогтны өв соёл, түүх, ёс заншлыг адил тэгш, хүндэтгэн үзэж хадгалан хамгаалах, харилцан баяжуулж хөгжүүлэх нөхцөл бололцоог хангах - иргэдийн сэтгэлгээний болон бүтээн туурвих, үр шимийг нь хүртэх эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, авъяас чадвараа илрүүлж, хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх - соёлын үнэт зүйлийг бүтээн туурвигч, өвлөн хадгалагчийг төрийн ивээл, халамжид байлгах - Уран бүтээлчид үзэл бодол, арга барил, урсгал чиглэл, дэг сургуулиа чөлөөтэй сонгож хэрэглэхийг дэмжих, - Уран бүтээлчид сайн дураараа мэргэжлийн эвлэл, холбоо, нийгэмлэг байгуулж, үр өгөөжтэй соёлын үйл ажиллагаа явуулахыг дэмжих -Соёлын салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгон үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлэх</p>	<p>тодорхой үйл ажиллагааг хориглох хүртэл арга хэмжээг авах 3.8. хүн амын соёлын хэрэгцээг хангахад <u>хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүргийг өндөржүүлж</u>, хэвлэлийн чөлөөт байдлыг хангах, ном, кино, хэвлэлийн үйлдвэрлэлийн техник технологийг боловсронгуй болгох, хөгжүүлэх талаар <u>цогцолбор арга хэмжээ</u> авч хэрэгжүүлэх 3.9. хүүхдэд зориулсан ном, хэвлэл, уран бүтээлийг олшруулж, чанарыг нь сайжруулах 3.11. соёлын суурь болон хавсарга судалгааг эрчимтэй хөгжүүлж, түүний үр дүнг нийтийн болон мэргэжлийн сургалтад өргөн ашиглах 3.15. соёл урлагийн байгууллагын сүлжээг боловсронгуй болгож, дэлхийн жишиг, монгол орны онцлогийг харгалзан <u>соёлын үйлчилгээний чанарын үзүүлэлтийг тогтоож мөрдүүлэх</u> 3.17. соёлын хүрээнд <u>менежмент, маркетингийг хөгжүүлэхэд анхаарах</u> 3.18. соёлын мэргэжлийн боловсон хүчин, багш, судлаач бэлтгэх сургалтын</p>	<p>киног <u>төрийн ивээлд</u> байлгах 3.6. ард түмний оюуны эрэлт хэрэгцээг хангахад зайлшгүй шаардлагатай шилдэг уран бүтээл болон <u>төслийг шалгаруулж санхүүжүүлэх</u> 3.22. соёлын үнэт зүйлийг хамтран бүтээх, оюуны ололтыг харилцан дэлгэрүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, соёлын үйл ажиллагааны туршлага солилцох, соёлын салбарт <u>хамтарсан төсөл, хөтөлбөр</u> боловсруулж хэрэгжүүлэхийг соёлын гадаад харилцааны <u>чухал чиглэл болгох</u></p>	<p>ахуй нөхцөлийг <u>сайжруулах ажлыг дэс дараатай шийдвэрлэх</u> 3.19. соёлын ажилтны нийгмийн хамгаалалтыг хуулиар баталгаажуулж, <u>нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь бодитой туслалцаа</u> дэмжлэг үзүүлэх 3.28. соёлын үйл ажиллагааг санхүүжүүлэх <u>баталгаатай эх үүсвэрийг</u> бүрдүүлэх зорилгоор улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн <u>зохих хэсгийг жил бүр</u></p>	<p>уламжлалт болон орчин үеийн технологи нэвтрүүлж, үйлдвэрлэлийн гоо зүй, бизнесийн болон аж байд -лын соёл, дизайныг хөгжүү-лэхэд <u>байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх</u> 3.4. уламжлалт аж төрөх ёсны хөгжлийн өвөрмөц зүй тогтлыг хадгалж, үндэсний уламжлал, онцлогийг шингээсэн <u>уран барилга, хот байгуулалтын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх</u> 3.12. соёлыг түгээн дэлгэрүү-лэхэд чиглэсэн иргэдийн аливаа <u>санаачлага, бүтээлч үйл ажиллагааг дэмжих</u> 3.13. соёлын байгууллагын <u>эрх зүйн байдлыг хуульчлан</u> баталгаажуулах 3.26. соёлын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө, оруулалт, гааль, санхүү, зээл, татварын таатай бодлого явуулж, соёлын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдүүлэх</p>
---	---	---	--	---	--

		бүх хэлбэр, түүний дотор <u>гэрийн болон шавь сургалтыг дэмжих</u> 3.21. соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг сонирхогч бүх улс орон, олон улсын байгууллагатай чөлөөтэй хөгжүүлж, энэ харилцаанд ЗГ-ын бус байгууллага, иргэд бие даан оролцох бололцоог өргөтгөх.	3.25. төрөөс соёлын үйл ажиллагааг <u>дэмжих зориулалтын сан байгуулж, ажиллуулах</u>	<u>хувиарлан зарцуулах</u>	3.29. төрийн соёлын бодлогын зарчим, чиглэл, хэрэгжүүлэх арга замыг холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулах 4.2. төрөөс баримтлах соёлын бодлогыг Монгол улсын ЗГ, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудалд хамааруулж тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлнэ.
<p><i>Монгол улсын үндсэн хуулиар соёлын талаар тунхаглан зарласан эрх, эрх чөлөө, нийтлэг зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн иж бүрэн баримт бичиг болсон. Монгол үндсэтэн, ястнуудын соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах, соёлын харилцааг аль болох нээлттэй байлгах, соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцох бололцоог аль болох бүрэн дүүрэн хангах, соёлын санхүүжилтэд төрийн болон хувийн хэвшлүүдийг өргөн татан оролцуулах, соёлын удирдлагын тогтолцоон дахь хэт төвлөрлийг саармагжуулах, эдгээрийг хэрэгжүүлэх хяналт, харууцлагын тогтолцоог бүрдүүлэх зэрэг орчин үеийн соёлын бодлогын олон улсын нийтлэг жишигт нийцсэн баримт бичиг болсон юм. Чухам уг баримт бичигт анх удаагаа Монголын соёл нь тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа, үндэсний бахархал, эв нэгдлийг уг сурвалж, хөгжил дэвшлийн чухал хөшүүрэг мөн болохыг тогтвортой баримтлахаа Монгол улсын хууль тогтоох дээд байгууллага УИХ зарлан тунхагласнаараа ач холбогдолтой болсон билээ.</i></p>					
<p>Соёлын тухай Монгол улсын хууль. 1996 оны 6-р сарын 15. Улаанбаатар хот.</p>					
Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт	Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт	Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл	Соёл, урлагийн байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд	Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагийг бэхжүүлэх үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар
1. “Соёлын үйл ажиллагаа” гэдэгт соёлын үнэт зүйлийг бүтээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах түгээн дэлгэрүүлэхтэй	4 дүгээр зүйл. Соёлын талаарх иргэний эрх, - үндэсний болон дэлхий нийтийн соёлын үнэт зүйлстэй танилцах, соёлын үйл ажиллагаа явуулах,	7 –р зүйл. Соёлын байгууллагыг үүсгэн байгуулах, 8-р зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, 9-р зүйл. Улсын бүртгэлд бүртгэх,	21 –р зүйл. Соёлын байгууллагын /СБ/ санхүүжилт. 1. СБ нь <u>санхүүжилтийн зөвшөөрөгдсөн</u>	6-р зүйл. 6.3. Хэд хэдэн аймгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үүрэг бүхий бүс нутгийн соёлын	

<p>холбоотой дараах үйл ажил-лагаа хамаарна. А/ уран зохиол, хөгжим, дүрслэх урлаг, театр, цирк, киноны урлаг, уран барилга, дизайн зэрэг урлагийн бүх төрлийн бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох Б/ соёлын үнэт зүйлийг бүтээх, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгоход чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх В/ монгол үндэстэн болон угсаатан, ястны хэл, аялгуу, аман болон бичгийн соёлыг хадгалж хамгаалах, сэргээн хөгжүүлэх Г/ иргэдийн соёлын ерөнхий төвшинг дээшлүүлэх, уран сайхан – гоо зүйн боловсрол, хүмүүжил олгох Д/ Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулах, Е/ Соёл судлалыг хөгжүүлэх Ё/ соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх,</p>	<p>тэдгээрийн үр шимийг нь хүртэх - уран бүтээлийн ... чөлөөтэй сонгон авах, үүдэл санаа, ур чадварынхаа нууцыг хамгаалуулах - ... хориглосноос бусад соёлын үйл ажиллагааг гадаадад явуулах - ... соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх - ... уран бүтээлийн эвлэл, холбоо, нийгэмлэг байгуулах, тэдгээрт эвлэлдэн нэгдэх <i>5 дугаар зүйл. Соёлын талаарх журамт үүрэг</i> - ... соёлын уламжлалыг хамгаалан хөгжүүлэх - эх хэл, бичиг үсгээ судлах, өвлөх, өвлүүлэх -гэр бүлийн соёл, хүмүүж-лийн уламжлалыг дээдлэн хөгжүүлж, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх - соёлын үнэт зүйлийг элдэв халдлагаас сэрэмжлэн хамгаалах <i>Гуравдугаар бүлэг. Соёлын байгууллага</i></p>	<p>10-р зүйл, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 11-р зүйл, Соёлын байгууллага татан буугдах харилцааг хуульчилсан. 12 –р зүйл. Соёлын удирдлагын тогтолцоо. Соёлын удирдлагын тогтолцоо нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн болон соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ. 13-р зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, 14-р зүйл. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын бүрэн эрх, 15-р зүйл. Соёлын байгууллагын удирдлага, 16 –р зүйл. Төрийн захиргааны төв байгууллагуудын үүрэг, 17-р зүйл. Соёлын байгууллагын нийтлэг үүрэг, 18 –р зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг -г хуульчилсан. 23-р зүйл. <i>Соёлын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.</i> 1. Соёлын хууль тогтоомж зөрчигчдөд эрүүгийн</p>	<p><i>бүх эх үүсвэртэй байхаар заасан.</i> 2. <i>Ашгийн төлөө бус төрийн өмчийн соёлын тэргүүлэх, төв болон орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлнэ.</i> 3. <i>Төрийн өмчийнхөөс бусад ашгийн төлөө бус СБ-д тодорхой төслийг үндэслэн төрөөс санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлж болно. Төсөл шалгаруулах журмыг ЗГ тогтооно.</i> 4. <i>Соёлын зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт бие даасан зүйл болгож батална</i> 5. <i>Соёлыг хөгжүүлэх</i></p>	<p>байгууллага байгуулж болно. 6.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий байгууллага нь орон нутгийн соёлын байгууллагад хамаарна. 22-р зүйл. 22. Соёлын ажилтан нь дараахь нийгмийн баталгаа -гаар хангагдана. А/ тэтгэвэрт гарах үед ажиллаж байсан байгууллага нь тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нэг жилийн дундажтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг тэтгэвэрт гарахад нь нэг удаа олгоно. Б/ хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн</p>
---	---	---	--	--

<p>2/ “Соёлын үнэт зүйл” гэдэгт гоо сайхны үзэл баримтлал, эх хэл, бичиг үсэг, аман аялгуу, уламжлалт технологи, газар усны нэр, зан заншил, бэлгэ тэмдэг, ардын аман зохиол, ном, судар, шашдир, угийн бичиг, им, тамга, хадны зураг, бичээс, гар урлал, урлагийн бүх төрлийн болон соёл судлалын бүтээл, судалгааны арга барил хамаарна</p>	<p>6.1. Соёлын байгууллага нь өмчийн хэлбэрээс үл хамааран, улс болон орон нутгийн чанартай гэсэн ангилалтай байна. ... 7.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хууль тогтоомжийн дагуу ашгийн төлөө болон ашгийн төлөө бус соёлын байгууллага байгуулан ажиллуулж болно.</p>	<p>хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурьдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ. А/ зөвшөөрөлгүйгээр соёлын үйл ажиллагаа эрхэлсэн гэм буруутай иргэнийг 10 000 – 50 000 төгрөгөөр, байгууллагыг 80 000 – 250 000 төгрөгөөр торгох, Б/ дайн хүчирхийллийг сурталчилсан бүтээлийг түгээн дэлгэрүүлэх соёлын үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай иргэнийг 25 000 – 50 000 төгрөгөөр, байгууллагыг 70 000 – 250 000 төгрөгөөр торгох</p>	<p><i>зорилгоор тусгай зориулалт бүхий санг байгуулан ажиллуулж болно. /журмыг ЗГ тогтооно/ 6. Соёлыг хөгжүүлэх, ... төрийн санд байгууллага, иргэнээс оруулсан хандив, хөрөнгө оруулалтад ... татварын хөнгөлөлт үзүүлэх журмыг хуулиар тогтооно. 7. ...Үндэсний хонжворт сугалаа гаргаж болно. /ЗГ/ 8. Соёлын үйл ажиллагаанд зориулсан ... хөрөнгийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.</i></p>	<p>онцлогийг харгалзан нэмэгдэл цалин, урам-шил, эрдмийн зэрэг цолны болон ур чадварын нэмэгдэл хөлс олгоно. В/ Нийгмийн даатгалын тухай хуулийн 20-р зүйлд заасан соёлын ажилтан ажлын онцлогоос хамаарч мэргэжлийн хөдөл-мөрийн чадвараа эрт алдсан тохиолдолд түүний хүсэлтийг нь үндэслэн дотоодын сургууль курсээр тусгай мэргэжил эзэмших сургалтын зардлыг төр хариуцна.</p>	
<p>Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль. 2002 оны 6-р сарын 20-ны өдөр. Улаанбаатар хот.</p>					
		<p>22 /1/ дугаар зүйл. 1. Соёлын хяналтыг соёлын улсын хяналтын алба, улсын байцаагч, бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ. 2. Соёлын улсын хяналтын алба нь соёлын тухай хууль тогтоомж, түүнтэй</p>	<p>21 дүгээр зүйл. “9. Хөгжмийн том хэлбэрийн болон дүрслэх урлаг, кино, ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авч байна. Шилдэг бүтээл шалгаруулан худалдан авах журмыг Засгийн газар тогтооно. “10. Монгол улсын түүхэнд холбогдох онцлог үйл явдал, он дарааллын түүхийн талаархи баримтат кино бүтээх зардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ.</p>		

		<p>холбогдсон норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилт, болон соёлын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.</p> <p>20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.</p> <p>“2. Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар бүхэлд нь ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.</p>	<p>“11. Үндэсний уламжлалт, сонгодог болон хүүхдэд зориулсан урлагийн бүтээл, улсын захиалгаар бүтээх уран сайхны болон баримтат кинонд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар тогтооно.</p> <p>“12. Соёлын байгууллагын улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг өөрийн үйл ажиллагааны орлого болон байгууллага, иргэдийн хандивын хэмжээгээр багасгаж төлөвлөхийг хориглоно.</p> <p>22 дугаар зүйл.</p> <p>17. Монгол улсад шинээр хэвлэгдэн гарч байгаа ном, хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс хоёроос доошгүйг шалгаруулалт хийсний үндсэн дээр улс аймаг, нийслэлийн төв номын санд худалдан авна. ...журмыг ЗГ тогтооно.</p>		
Өнөөгийн байдлаар үйлчилж буй соёлын тухай Монгол улсын хуулийн харьцуулсан үнэлгээ.					
Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт	Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт	Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл	Соёл, урлагийн байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд	Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагийг бэхжүүлэх үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар
“Соёл”, “Соёлын үнэт зүйлс”, “Соёлын үйл ажиллагаа” – г төрөөс тогтвортой баримтлах соёлын бодлогод нийцүүлэн нарийвчлан тодорхойлсон.	<p>Соёл, соёлын харилцаанд оролцогч үндсэн субъект болох иргэн, соёлын болон бусад байгууллагын эрх үүргийг тодорхойлон зааж өгсөн.</p> <p>Соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцох бололцоог аль болох бүрэн дүүрэн хангах эрхийг нээж өгсөн.</p> <p>Гэхдээ үүргийн талаар</p>	<p>Соёлын тогтолцоо, харилцааны хэм хэмжээг нарийвчлан тогтоож өгсөн.</p> <p>Соёл, соёлын үйл ажиллагааны талаарх төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, соёлын болон аж ахуйн байгууллагын эрх, үүргийг тодорхойлон зааж өгсөн. Гэвч <u>хариуцлагын тогтолцоог бүрдүүлж чадаагүй гэж үзэж болохоор</u> байна. Нэн ялангуяа соёлыг хөгжүүлэх нь төрийн эрхэм</p>	Соёл, урлагын байгууллагуудын санхүүжилтийн үндсэн хэлбэрүүдийг бүхэлд нь хуульчлан батаалгаажуулсан . Гэхдээ энд гааль татварын бодлогоор дэмжих явдал хангалтгүй болон төсөвт байгууллагуудын удирдлага санхүүжилтийн	Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагуудын эрх зүй, бүтэц зохион байгуулалтын ерөнхий зарчмыг тодорхойлсон боловч тэдгээрийг бэхжүүлэхэд түлхэц болохуйц дорвитой хөшүүрэг, арга хэрэгслийг тодорхойлоогүй	Уг хууль нь бүхэлдээ соёл, соёлын харилцааг зохицуулах үндсэн хууль болсон бөгөөд энэ үүргээ ч амжилттай биелүүлж, хэрэгжиж байгаа.
					Соёл, соёлын үйл ажиллагааны талаархи хариуцлагын тогтолцоо, санхүүгийн дэмжлэг

	<u>журамт үүрэг гэх мэт тунхаг шинжтэй хандсан нь түүний хэрэгжих чадварыг сулруулсан байж бозошгүй.</u>	үүргийн нэг гэдэг үүднээс нь хандаж, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын дарга, ажилтнуудын чиг үүрэг, эрхлэх асуудалд хамааруулж тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэх тухай төрөөс баримтлах соёлын бодлогын заалт хэрэгжихүйцээр бодитой тусгагдаж чадаагүй гэж үзэхээр байна. Энэ нь уг хуулийн хүч, амьдрах чадварыг бууруулжээ.	хулиудтай уялдаагүй, энэ талаар зохих заалтыг тусгаагүйгээс өнөө хир санхүүжилтийн арга хэлбэрүүдийн гол чухал хэсэг нь хэрэгжихгүй байна.	байна. Харин соёл урлагийн ажилтнуудын нийгмийн хамгааллын холбогдолтой нилээд заалтуудыг хэрэгжихүйц үндэслэлтэйгээр тусгажээ.	туслалцаа нь бусад хуулиуд, тухайлбал, <i>Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Төсөвт байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Татвар, Гаалийн багц хуулиудад бодитойгоор сууж тусгагдаагүй өнөөг хүрчээ. Энэ нь соёл, урлагийг хөгжүүлэх хөшүүрэг, механизм ажиллахгүйд хүргэсэн</i> гэж үзэж болохоор байна.
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 1998 оны 51 дүгээр тогтоолын хавсралт.					
Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт	Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт	Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл	Соёл, урлагын байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд	Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагийг бэхжүүлэх үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар
Монголын ард түмэн өөрийн түүхийн урт хугацаанд нүүдлийн өвөрсөц соёл иргэншил, түүндээ зохицсон соёл, урлагийн болон утга соёлын үнэт зүйлс	Хоёр. <u>Хөтөлбөрийн зорилго</u> Тодорхой бодлого, дэс дараалалтайгаар түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх, түүх,	3.б. <u>Дурсгалыг хамгаалах арга.</u> 1. Бүртгэх - ...улсын нэгдсэн бүртгэл – мэдээллийн санд ... бүртгэн авч ... иж бүрэн баримт материал цуглуулах, - ... “Дэлхийн соёлын болон	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө - 1 880.3 сая₮ Үүнээс: а/ Түүх соёлын дурсгалт зүйлийг	<i>/аймаг, сум бүрээр сэргээн засварлах, консерваци хийж, бэхжүүлж хамгаалах, хашаа саравч, аянга зайлуулагчтай</i>	Дөрөв. <u>Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөлт</u> Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж, хамгаалах, сэргээн

<p>бүтээсэн билээ. Тиймээс олон зуун жилийн туршид уламжлагдан ирсэн түүх, соёлын дурсгалт зүйл, утга соёлын өвийг судлан шинжилж, хадгалж хамгаалан хойч үедээ өвлөн залгамжлуулах дэлхийн соёл иргэншилд зохих байр сууриа олохоос гадна танин мэдэхүй, түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой юм.</p>	<p>соёлын дурсгалын өнөөгийн байдал, хэтийн төлөвийг тодорхойлох, аялал жуулчлалын маршрутад оруулах, түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлахад зарцуулж буй төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламжийг урьдаас төлөвлөсөн бодлого, зорилготой үр бүтээлтэй ашиглахад Үндэсний хөтөлбөрийн зорилго оршино.</p>	<p>байгалын өвийн жагсаалт”-д бүртгүүлэх ажлыг зохион байгуулах 2. Хамгаалалтад авах 3. Сурталчлах 4. Консерваци хийх 5. Сэргээн засварлах</p>	<p>сэргээн засварлахад - 1 624.0 сая ₮ б/ Түүх, соёлын дурс-галт зүйлд консерваци хийж бэхжүүлэн хамгаалахад - 171.8 сая ₮ в/ Түүх, соёлын дурс-галт зүйлийг хашаа саравч, аянга зайлуулагчтай болгоход - 57.5 сая ₮ г/ Хуулбар болон хэв авч ТСДЗ-ийн Улсын нэгдсэн бүртгэл – мэдээллийн санд хад-галахад – 23.2 сая ₮ д/ Түүх, соёлын дурс-галт зүйлийн хуулбар-рыг хийхэд – 11.0 сая ₮</p>	<p><i>болгох, анхны байранд нь байрлуулах ба байршил нь тодорхойгүй тохиолдолд улс, аймгийн музейд татан авах, хуулбар болон хэв авч ТСДЗ-ын улсын НБМС-д хадгалах, хуулбарыг нь хийж унаган газарт нь босгоод, эх дурсгалыг улс, орон нутгийн музейн хамгаалалтад авах болон хамгаалалтад авах түүх, соёлын дурсгалуудын жагсаалтыг хугацаа, хөрөнгө, хариуцах байгууллагын хамт баталсан/</i></p>	<p>засварлах хөтөлбөрийг 7 хэсэгт хуваан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Ингэж төлөвлөхдөө захиалагч байгууллага, хэрэгжүүлэгч хугацааг тодорхойлон шаардагдах хөрөнгийн хэмжээг урьдчилан тогтоож байна. Тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч энэхүү төлөвлөгөөнд тодотгол хийж байх болно.</p>
<p>Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 1999 оны 68 дугаар тогтоолын хавсралт 1.</p>					
<p>Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт</p>	<p>Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт</p>	<p>Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл</p>	<p>Соёл, урлагийн байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд</p>	<p>Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагийг бэхжүүлэх үндсэн чиглэл</p>	<p>Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар</p>
<p>Аливаа улс орны үндэсний уламжлалт урлаг нь үндэстэн</p>	<p>2.1. Монгол улсын төрөөс соёлын талаар баримтлах соёлын</p>	<p>3.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны 1-р зорилтын хүрээнд дараах арга хэмжээг</p>	<p>6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны</p>	<p>4.3. Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөв-</p>

<p>ястны амьдралын өвөрмөц төрх, зан үйл, хөгжил дэвшлийн нэгэн илэрхийлэл болдог бөгөөд өргөн утгаараа тухайн улс, үндэстний үндэстний аюулгүй байдалд ч нөлөөлж байдаг учраас дэлхийн олон орон үндэсний уламжлалт урлагаа өвөлөн уламжлуулах, дэмжихэд ихээхэн анхаарч байна.</p>	<p>бодлогод ... тусгагд - сан асуудлууд, Монголын төрт ёс, зан заншлын дэвшилттэй бүхнийг өвлөн авч, хүн төрөлхтний соёлын дээжистэй хослуулан хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. 2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна: - үндэсний уламжлалт урлагийг өвлөсөн билиг авъяастны үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн авъяас билиг, арга барил, дэг сургуулийг хамгаалах, өвлүүлэх. - үндэсний урлагийн төрөл, зүйлийн ангилал, шинж чанарын талаар судалгаа, сурталчилгааг эрчимжүүлэх, уламжлалт урлагийг өвлүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн хэмжээнд болох уралдаан, наадмын зохион байгуулалтыг боловсронгуй болгох,</p>	<p>авч хэрэгжүүлнэ. - ... судалгааг хийж, мэдээллийн санд төвлөрүүлэн ... боловсронгуй болгох - ... нийтэд сурталчлах, өвлүүлэх - ... мэргэжлийн болон зохион байгуулалтын туслалцаа, дэмжлэг үзүүлэх - ... бүтээлүүдийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулж хадгалах, сурталчлах -авъяастан, урчуудын хөдөлмөр зүтгэл, авъяас чадварыг бодитой үнэлэх, тэдгээрийг төрийн болон бусад шагнал урамшуулалд хамруулах, алдаршуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах 3.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны 2-р зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. - ... судалгааг өргөжүүлэх, - ... уралдаан, наадам, үзэсгэлэнг зохион байгуулах, тэдгээрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг төсөвт тусгах, -үндэсний уламжлалт урлагийг сурталчилахад шаардагдах ... /Бүхий л ажлуудыг хийнэ/ -үндэсний уламжлалт урлагийг өвлүүлэх зорилгоор ... бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах,</p>	<p>төлөвлөлт. Олон ястны уламж-лалт урлагийн голлох төрлүүдийг хамруулах, нутаг дэвсгэрийн байршил, дэд бүтцийн онцлог, уламжлалт урлагийн зарим уламжлагдах чанар нь алдагдахад хүрч буй төрлийг сэргээн, сурталчлах, өвлүүлэх асуудалд дүгнэлт хийж, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, захиалгч байгууллага, хэрэгжүүлэх хугацааг тодорхойлон шаардагдах хөрөнгийн хэмжээг урьдчилан тогтоож байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн санхүүжилтийг Соёл, урлагийн сангаар</p>	<p>ажлыг удирдан зохицуулах, хяналт тавих үүрэгтэй аймаг нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөл ажил-лана. Үндэсний хөтөлбөрийн орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, салбар зөв-лөлийн бүрэлдэхүүн, түүний ажлын чиг, үүргийг засаг дарга батална. 4.5. Аймаг, нийслэл, сум дүүрэгт хөтөл-бөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуу-лах үүргийг нийслэлийн соёлын газар, аймгийн боловсрол, соёлын төв, судалгаа, сургалт, сурталчилгаа явуулах үүргийг орон нутгийн соёл урлагийн байгууллагууд эрхлэн гүйцэтгэнэ.</p>	<p>лөлтийг хөтөлбөрийн хүрээнд 1-рт, улс орон нутгийн хэмжээнд, урал-даан наадам, үзэсгэлэн зохион байгуулах, 2-рт, уламжлалт урлагийн төрөл зүйлүүд, тэдгээрийг өвлөсөн сод билиг авъяастны судалгааг, эрчимжүүлэх, 3-рт, сурталчилгааг өргөжүүлэх гэсэн 3 үндсэн хэсэгт хуваан төлөвлөж байна.</p>
--	---	---	--	---	--

	<p>- үндэсний уламжлалт урлагийг өвлүүлэх, язгуур урлагийг дэмжих орчин бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагын шинэ тохиролцоо бүрдүүлэх, - үндэсний уламжлалт урлагийн талаарх бүртгэл – мэдээлэл, сургалт сурталчилгаа, аудио, видео санг бүрдүүлэх ажлыг боловсронгуй болгох</p>	<p>зайны болон шавь сургалт хэрэгжүүлэх - судлаачид, мэргэжилтэнг бэлтгэж, гадаад дотоодод гэрээгээр ажиллуулах, - ... /<i>бүх талаар</i>/ хамтран ажиллах - ... /<i>гадаад сурталчилгааг бүх арга хэлбэрээр хийх</i>/ 3.3. Хөтөлбөрийн үйл ажиллагааны гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэд дараах үүрэг хариуцлага хүлээнэ.</p> <ul style="list-style-type: none"> • МУ-ын Засгийн газар ... • Соёлын асуудал эрхэлсэн ТЗТБ ... • ТЗ-ны ОН-ийн байгууллагууд ... • Хэвлэл мэдээллийн байгуул –д ... • ТББ, ААН ... • Гэр бүл, иргэдийн оролцоо ... <p>3.4. хөтөлбөрийн үйл ажиллагааны 4-р зорилтыг хэрэгжүүлэх талаархи ажлын чиглэл: - ... судалгааг өргөжүүлэн, ... дээшлүүлэх</p>	<p>дамжуулан зарцуулах бөгөөд санхүүжилтийн нөхцөл байдал, үйл ажиллагаанаас хамаарч жил бүр “АУУДҮХ”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөлийн ажлын төлөвлөгөө гаргаж, хөрөнгө, санхүүжилттэй холбогдох тодотгол хийж болно. Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрөнгө нь параах эх үүсвэрээс бүрдэнэ. -Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв. - Соёл урлагийг дэмжих тусгай зориулалт бүхий</p>	<p>Гэгээрлийн Сайдын 1999 оны 120 –р тушаалын хавсралт. “Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр” –ийн хүрээнд улсын хэмжээнд зохион байгуулах уралдаан, наадам, судалгаа, сурталчилгааны арга хэмжээний жагсаалт. <i>/улс орон нутгийн хэмжээнд зохион байгуулах уламжлалт урлагийн наадам, уралдаан, үзэсгэлэнг хугацаа, хөрөнгө, хариуцан гүйцэтгэх байгууллагаар нь тогтоож баталсан байна./</i></p>	
--	--	--	--	--	--

		<p>- ... уялдуулан судлах - ... судалгааг ЭШБ, ИДС-иуд хамтран зохион байгуулах, ... - ... судалгааны экспедиц зохион байгуулах - ... ОУ-ын арга хэмжээнд мэргэжилтнүүдээ оролцуулах - ... судалгааны бүсүүдэд хувааж ... , ... баримтжуулах, судалгааны тодорхойлолтыг хийх, судлаачдыг томилон тогтвортой ажиллуулах -... цуврал баримтат кино бүтээх төслийг ... хэрэгжүүлэх -... утга соёлын өвийн бүртгэл мэдээллийн сүлжээнд оруулж, дуу, дүрс бичлэгийн архив бүрдүүлэх - ... билиг авъяастнуудыг судлан тогтоож, цол өргөмжлөл олгох, ... уламжлуулах ... дэмжлэг ... үзүүлэх. - ЮНЕСКО –оос тусламж ... авъяаснуудын урын сангийн үзлэг шалгаруулалт явуулах, дуу, дүрс бичлэг хийх - ... явцад цуглуулсан материал, хэрэглэгдэхүүнийг түшиглэн ... музей байгуулах, - ... албан бус төрөлжсөн сургалтыг зохион байгуулж ... шавь сургалт, ... семинар зохиох, хөгжмийн зэмсэг ноот хэрэглэгдэхүүнийг нийтэд худалдаалах цэг ажиллуулж, ажил үйлчилгээг явуулах</p> <p>4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>	<p>сан - Гадаад орон болон олон улсын байгууллагын хөрөнгө - Дотоод гадаадын байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгө</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрөнгө: 296,8 сая ₮ - Улс орон нутгийн хэмжээнд зохион байгуулах уламжлалт, урлагийн наадам, уралдаан, үзэсгэлэн зохион байгуулахад 261.9 сая ₮ - ЭШ, онол практикийн хурал, симпозиум, судалгаа, сурталчилгааны арга хэмжээ</p>		
--	--	--	---	--	--

		<p>УЗБ.</p> <p>4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, мэргэжлийн удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих үүргийг Үндэсний зөвлөл эрхлэнэ.</p> <p>4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд мэргэжлийн түвшинд зохион байгуулах үүргийг соёлын асуудал эрхэлсэн ТЗТБ гүйцэтгэнэ.</p> <p>4.5. Үндэсний болон орон нутгийн салбар зөвлөл нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцтай уялдуулан ажлаа жилээр төлөвлөн хэрэгжүүлж, жил бүрийн 4 –р улиралд орон нутгийн зөвлөл үндэсний зөвлөлд, үндэсний зөвлөл засгийн газарт тус тус тайлагнаж байна.</p> <p>4.6. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.</p> <p>...</p> <p>б/ Боловсрол, соёл, хүүхдийн байгууллагын сургалт хүмүүжлийн ажлаар дамжуулан уламжлалт урлагийг өвлөн дамжуулах чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны арга барил, уялдаа холбоог өөрчлөн шинэчлэх,</p>	<p>зохион байгуулахад 34, 9 сая ₮</p>		
--	--	--	---------------------------------------	--	--

Соёлын өвийг хамгаалах тухай Монгол улсын хууль. 2001 оны 6-р сарын 8-ны өдөр. Улаанбаатар хот.					
Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт	Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт	Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл	Соёл, урлагийн байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд	Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагийг бэхжүүлэх үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар
<p>3.1. Түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий ... эд өлгийн зүйлийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын дурсгалт зүйлд хамруулна.</p> <p>4.1. Ард түмний билэг авъяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий ... оюуны соёлын үнэт зүйлийг утга соёлын өвд хамааруулна.</p> <p>5.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдлоор нь хосгүй, үнэт, ердийн</p>	<p>Соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлүүлэн уламжлуулах тогтолцоо</p> <p>17.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтад соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.</p> <p>17.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтлана. ... төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр улсын музейд шилжүүлэн хадгалж болно.</p> <p>17.3” Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн эрх зүйн хамгаалалтыг улсын, орон нутгийн , байгууллагын гэж ангилна. ... жагсаалтыг ... саналыг үндэслэн</p>	<p>1.1. Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>8.1. Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэл – мэдээллийн санд заавал бүртгэнэ.</p> <p>8.2. Хувийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн бүртгэл – мэдээллийн санд бүртгэнэ.</p> <p>9.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олох, судалж шинжлэх ажлыг холбогдох журмын /эрхэлсэн Сайд тогтооно/ дагуу мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага эрхлэн явуулна.</p>	<p>10.6. ... эрх бүхий соёлын байгууллага бүртгэл – мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийг өмчлөгч, эзэмшигчтэй нь гэрээ байгуулсаны үндсэн дээр түр хугацаагаар дотоод, гадаадын үзэсгэлэнд тавьж, тоглолтод хамруулж болно. Гэрээнд ... өмчлөгч буюу эзэмшигчид төлөх хөлс ... тусгана.</p> <p>13.1. Түүх, соёл шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр,</p>	<p>/Түүх, соёлын дурсгалт зүйл, утга соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон бүхий л заалт нь орон нутгийн засаг захиргаа, соёлын байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлэх, бэхжүүлэхэд чиглэсэн байна./</p>	<p>/ соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон оролцогчдын эрх үүргийн харилцааг нарийвчлан зааглаж тогтоосон. Үүргээ биелүүлээгүй эрх бүхий байгууллага, албан тушаалтан, төрийн захиргааны байгууллага, түүний удирдлагад хүлээлгэх харуцлага, хяналтын тогтолцоо сул буюу тодорхой бус байгаа нь хууль хэрэгжих магадлалыг</p>

<p>гэж зэрэглэнэ.</p>	<p>Засгийн газар тогтооно. 17.10. Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар, олгоход түүх, архелогийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл авна. Урьдчилан хайгуул хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг барилга байгууламжийн захиалагч хариуцна. 17.14. Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг өмчлөгч нь уг зүйлийг хадгалж хамгаалах хэвийн нөхцөлийг хангана. Уг нөхцөлийг хангах боломжгүй бол эрднэсийн сан, улсын музейд хадгалуулж болно. Энэ тохиолдолд тэдгээрийг өмчлөгчтэй хийсэн гэрээний дагуу улсын даатгалд авна. 18.1. Соёл шинжлэх</p>	<p>9.2. Утга соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх ажлыг холбогдох, журмын /эрхэлсэн Сайд тогтооно/ дагуу мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага, иргэн эрхлэн явуулна. 10.1. Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. 11.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгааны ажил нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байна. 11.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгааг зөвхөн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага эрхлэн явуулна. 11.5. Газар өмчлөгч, эзэмшигч нь ... заасан зөвшөөрлийг үндэслэн түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгаа хийх байгууллагад зориулалт бүхий газар олгоно. 14.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч иргэн нь дараах үүрэг хүлээнэ: 14.2.1. ... аймаг, нийслэлийн бүртгэл –</p>	<p>газрын хэвлий нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч мөн. 17.9. Соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, нийслэлийн засаг дарга нь устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж төвлөрсөн буюу орон нутгийн төсөв, сан, хандивын хөрөнгийн үндсэн дээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. 21.2. Түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн</p>		<p><i>бууруулсан. Газрын болон, өмчийн харилцаа, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэхтэй холбогдсон хөшүүргийг холбогдох хууль тогтоомжид хангалттай тусгаагүй байна./</i></p>
-----------------------	--	--	---	--	--

	<p>ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн шатны Засаг дарга нь энэ хуулийн 5.5-д заасан жагсаалтад бүртгэгдсэн авъяастны өвлөсөн өвийг тухайн үндэстэн угсаатны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлдтэй нь уялдаатайгаар судалж, сурталчлах, өвлүүлэх, хамгаалах асуудлыг зохицуулна.</p> <p>18.2. Соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь утга соёлын өвийг өвлөн тээгчдийн авъяас билгийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, билиг авъяастныг тодруулах зорилгоор 5 жил тутам улсын хэмжээнд ардын урлагийн их наадмыг зохион байгуулна.</p>	<p>мэдээллийн санд бүртгүүлэх</p> <p>14.2.2. Худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд энэ тухайгаа аймаг, нийслэлийн бүртгэл – мэдээллийн санд мэдэгдэх</p> <p>16.3. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ гадаадын иргэн, харъяалалгүй хүнд шилжүүлэхийг хориглоно.</p> <p>22.1. Соёлын өвийг сурвалжлан олох, хадгалж хамгаалах, музей, архив, номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, алдагдсан, хууль бусаар хил нэвтрүүлсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах, олж илрүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг алдаршуулах, урамшуулах ажлыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.</p>	<p>засварлах ажлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь төвлөрсөн болон орон нутгийн төсөв, сан, байгууллага, иргэдээс оруулсан хандив, хөрөнгө оруулалт, түүх соёлын дурсгалт зүйлийг өмчлөгчийн үйл ажиллагааны орлого байна.</p>		
<p>“Сонгодог урлаг” хөтөлбөр. Засгийн газрын 2001 оны 266 дугаар тогтоолын хавсралт 1. 2001 – 12 – 05. Улаанбаатар хот.</p>					
<p>Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт</p>	<p>Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт</p>	<p>Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл</p>	<p>Соёл, урлагийн байгууллагын санхүүжилтий</p>	<p>Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагийг</p>	<p>Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар</p>

			н үндсэн зарчмууд	бэхжүүлэх үндсэн чиглэл	
<p>Нэг. Хөтөлбөрийн үндэслэл. Аливаа улс орны хөгжил дэвшлийн нэг илэрхийлэл бол тухайн орны урлаг, соёл түүний дотор сонгодог урлагийн хөгжил дэвшил, урын сангийн баяжилт, түүний өвлөн уламжлагдаж байгаа байдал юм. Сонгодог урлагийг дэмжих хүрээнд манай улсад үндэсний соёлын өвийг дэлхийн соёлын ололттой хослуулж, уран бүтээлийн чанар, хүн амын соёлын түвшинг дээшлүүлэх, хүүхэд залуучуудад гоо сайхны хүмүүжил олгох, тэдний гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэх асуудлыг тусгасан хөтөлбөр боловсруулах нь чухал юм.</p>	<p>2.1. Монгол улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулан хөгжүүлэх нөхцөл бололцоог хангах, хүн амын гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, шинэ уран бүтээл туурвиж урын сангаа баяжуулан дэлхийн болон өрнө, дорнын сонгодог урлагийн түвшинд хүргэхэд хөтөлбөрийн зорилго оршино. 2.2.1. сонгодог урлагийг төрийн ивээлд авч, үйл ажиллагааг нь дэмжих, үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулан уран бүтээлийн чанарыг дээшлүүлэн хөгжүүлэх. 2.2.2. Сонгодог урлагийг сурталчлах, мэргэжлийн жүжигчдийн ур чадварыг дээшлүүлэх, гадаад орны мэргэжил нэгт уран бүтээлчдээс суралцах, дэлхийн сонгодог уран бүтээлийг эзэмшиж авъяасаа хөгжүүлэх зорилгоор сонгодог урлагийн</p>	<p>3.1. Хөтөлбөрийн 1-р зорилтын хүрээнд ... дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. -сонгодог урлагийг улсаас санхүүжүүлж, урын санг нь баяжуулах, сонгодог урлагийн уран бүтээлчдийн хөдөлмөр, авъяас чадварыг үнэлэх, - ... нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай уран бүтээлч, мэргэжилтэнг өндөр хөгжилтэй орнуудад ... бэлтгэх, ... сургах - сонгодог урлагийг дэмждэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг алдаршуулах, сурталчлах. 3.2. ... 2-р зорилтын хүрээнд - ... олон улсын уралдаан, тэмцээнийг өөрийн оронд зохион байгуулах, тэдгээрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох, - ... уран бүтээлчдийг ... дэлхийн болон тив, олон улсын уралдаан, тэмцээнд оролцоход ... дэмжлэг үзүүлэх - сонгодог урлагийг сурталчилж хүн амын гоо зүйн хүмүүжлийн түвшинг дээшлүүлэх, ... 3.3.1. бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт</p>	<p>3.1.4. жүжигчдийн сургуулалт, дасгалын тусгай зориулалт бүхий хувцас, каски, хөгжмийн зэмсэг бусад эд зүйлсийг шинэчлэх, сургалтад зориулсан нот бичлэг хийхэд шаардагдах хөрөнгийг төсөвт суулгаж санхүүжүүлэх</p> <p>Долоо. <u>Хөтөлбөрийн санхүүжилт</u></p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн зардлыг Соёл, урлагийн сангаар дамжуулан санхүүжүүлнэ. Сонгодог урлагийг дэмжих хөтөлбөрийг</p>	<p>3.2.3. ... орон нутгийн театр, чуулгыг мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэх, 4.1. Аймаг, нийс-лэл, сум, дүүрэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удир-длагаар хангаж зохион байгуулах үүргийг аймгийн Боловсрол соё-лын төв, нийслэ-лийн соёлын газар, сонгодог урлагийн талаар сургалт, суртал-чилгаа явуулах үүргийг мэргэж-лийн урлагийн байгууллагууд эрхлэн гүйцэтгэнэ.</p>	<p>3.5. ...төрийн болон ТББ, ААН дараах үүрэгтэй <u>Засгийн газар</u>: - ...эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нягт уялдуулах; -... олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хамтран ажиллах дэмжлэг үзүүлэх; -... оролцож буй төрийн болон иргэдийн оролцоо, идэвхи санаачилгыг дэмжих Соёлын асуудал эрхэлсэн ТЗТБ: - ... судлан сурталчлах, өвлөн уламжлуулах, бүтээн туурвих, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх; - ... үйл ажиллагааг эрчимжүүлэх - ... хөгжүүлэх стратегийг тодорхойлж, үе шаттай хэрэгжүүлэх; - ... орчинг бүрдүүлэх асуудлыг зохицуулах ...дэмжих - сонирхогчдын нэгдэл, холбоо, авъяастнуудтай хамтран ажиллах,дэмжих - ... бусад байгууллагуудаас зохиож байгаа ажилд идэвхтэй оролцох, дэмжлэг үзүүлэх;</p>

	<p>уралдаан тэмцээнийг зохион байгуулах, 2.2.3. Сонгодог урлагийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, сонгодог урлагийг иргэдийн хүртээл болгох. 2.2.4. Сонгодог дуурь, бүжгийн жүжиг, хөгжмийн бүтээл, концертийн талаархи бүртгэл – мэдээлэл, аудио, видео санг бүрдүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг боловсронгуй болгох.</p>	<p>сонгодог урлагийн талаар зохих мэдлэгтэй болгоход чиглэгдсэн асуудлуудыг тусгах, 3.3.2. гадаад орны нарийн мэргэжлийн багш, мэргэжилтэнг урьж ... сургалт явуулах 3.3.4. ... их сургууль, коллежийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, ... 3.3.5. мэргэжлийн онцлогоос шалтгаалан эрт тэтгэвэр тогтоолгосон уран бүтээлчдийг ерөнхий боловсролын сургуулиудад дуу хөгжим, урлагийн түүхийн багшаар ажиллуулах талаар арга хэмжээ авах, 3.4.1. сонгодог бүтээлийн хувцас, тайз, бичлэг, дарамж /клавир/, удирдвар /партитура/-ыг хадгалж хамгаалан, тэдгээрийн санг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; 3.4.2 сонгодог бүтээлийг нийтлэх, хэвлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; 3.4.3. радио, телевизийн хөтөлбөр, нэвтрүүлгийн төлөвлөгөөнд дэлхийн сонгодог урлагийн бүтээлийг оруулах, улсын сан хөмрөг, фондод хадгалж үлдээх;</p>	<p>хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ: -улсын төвлөрсөн төсөв - соёл, урлагийг дэмжих тусгай зориулалт бүхий сан; - гадаад орон болон улсын байгууллагын хөрөнгө; - дотоод, гадаа-дын байгууллага, иргэдээс өгсөн хандив, туслам-жийн хөрөнгө.</p>	<p><u>ТЗ-ны орон нутгийн байгууллагууд:</u> - ...хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих; - ...холбогдох байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж удирдлагаар хангаж ажиллах <u>Хэвлэл, мэдээллийн байгууллагууд:</u> - ...нийтлэл, сурталчилгаа, нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлэх, тэдгээрийн чанарыг дээшлүүлж, арга хэлбэрийг боловсронгуй болгох; -уран бүтээлч, авьяастныг дэмжин, тэдний бүтээл, авьяас чадварыг нийтэд сурталчлах <u>Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт</u> - ... хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд мэргэжлийн түвшинд зохион байгуулах үүргийг Соёлын асуудал эрхэлсэн ТЗТБ, харьяа байгуул-лагуудын оролцоотойгоор гүйцэтгэнэ. 4.4. Сонгодог урлаг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион</p>
--	---	---	---	---

		<p>3.4.4. гадаад орнуудад өөрийн орны сонгодог бүтээлийг сурталчлах, айлчлан тоглолт хийх, гадаадын байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллах; 3.4.5. дэлхийн соёлын үнэт өв сонгодог урлагийн талаархи сурталчилгааг өргөжүүлэх, түүнтэй уялдсан арга хэмжээг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах</p>			<p>байгуулах зөвлөл нь ажлаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцтай уялдуулан жилээр төлөв-лөн хэрэгжүүлж, жил бүрийн IV улиралд Засгийн газарт тайлагнаж байна. Зургаа. <u>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт</u> - улсын хэмжээнд сонгодог урлагийн мэргэжлийн байгууллага, уран бүтээлчдийн дунд уралдаан, наадам зохион байгуулах - дэлхийн шилдэг дуурь симфони, бүжгэн жүжгийг найруулан тавих -гадаад орны мэргэжил нэгт уран бүтээлчидтэй хамтран тоглож, олон улсын тэмцээн, уралдаанд оролцож, сонгодог урлагийн сурталчилгааг өргөжүүлэх</p>
<p><i>Эдгээр хөтөлбөрүүд нь төрөөс соёлын талаар тогтвортой баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн цогцолбор, чухал арга хэмжээнүүд болжээ.</i></p>					
<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол улсын хууль. 2002 оны 7-р сарын 04. Улаанбаатар хот.</p>					
<p>Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт</p>	<p>Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт</p>	<p>Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл</p>	<p>Соёл, урлагын байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд</p>	<p>Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагыг бэхжүүлэх</p>	<p>Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон</p>

				үндсэн чиглэл	хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар
65.1.1. Нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдээс үзүүлдэг үйлчилгээ, удирдах үйл ажиллагааг төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр гүйцэтгүүлэх, нийгмийн салбарт тусламж үйлчилгээг үзүүлэхэд ашиглагддаг төрийн өмчийн зориулалтын эд хөрөнгийг бусдад түрээсээр ашиглуулахыг өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын хүрээнд хамруулж ойлгоно.	65.1.4. Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтлана. 1. үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн зориулалтыг өөрчлөхгүй байх 2. үйлчилгээ, үйл ажиллагааны хүрсэн түвшинг буруулахгүй байх 3. үйлчилгээнд хамрах хүрээг өргөтгөх 4. ил тод, нээлттэй байх 5. ажиллагсадад учрах эрсдэлийг бууруулах	65.2.1. нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн удирдах үйл ажиллагааг уралдаант шалгаруулалтаар шалгарсан төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр удирдлагын гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. 65.2.5. Удирдлагын гэрээ байгуулахдаа Иргэний хуулийн үүргийн ажил гүйцэтгэх тухай гэрээний заалтыг баримтлахаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана: 2/ тухайн хуулийн этгээдийн үйлдсэн үйл ажиллагааны чанар, үр ашгийг дээшлүүлэх, төсвөөс үзүүлэх санхүүжилтийг багасгах хэмжээ, үе шат, хугацаа 3/ тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны зардлаас давсан орлогоос түүнд хөрөнгө оруулалтын зориулалтаар буцаан олгох хөрөнгийн хэмжээ 65.3.1. Төрөөс нийгмийн салбарт үзүүлдэг тусламж, үйлчилгээг төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр гүйцэтгэлийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. 65.3.2. Гүйцэтгэлийн гэрээгээр ажиллуулах хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр сонгон шалгаруулна. 65.3.5 Гүйцэтгэлийн гэрээ байгуулахдаа Иргэний хууль болон ажил гүйцэтгэх тухай гэрээний заалтуудыг баримтлахаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана. 2/ тусламж, үйлчилгээнд тавигдах мэргэжлийн стандарт, шаардлага нөхцөлийг ханган гүйцэтгэх 65.3.6 Гүйцэтгэлийн гэрээний явцад төрийн өмчийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг ашиглах шаардлага гарвал Төрийн өмчийн хороо гүйцэтгэгчтэй төрийн өмчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг ашиглах тухай тусгаар гэрээ байгуулна. 65.4.1 Нийгмийн салбарын төрийн өмчийн зориулалтын эд хөрөнгийг төрийн өмчийн оролцоогүй			

		<p>хуулийн этгээд, хувь хүнээр түрээсийн гэрээний үндсэн дээр ашиглуулж болно. 65.4.2 Түрээсийн гэрээний үндсэн дээр төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглах хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулна. 65.5.1. Нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж төсвөөс авах санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг тодорхой хувиар бууруулж хуулийн этгээд, хувь хүнд хувьчилж болно. 65.5.3 ... хувьчлалд оролцох хуулийн этгээд, хувь хүнийг уралдаант шалгаруулалтаар шалгаруулна. 65.5.5 ... төрийн эзэмшлийг хэдэн хувиар бууруулахыг тухайн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулах гэрээнд заавал заана. “ “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх хугацаа, арга хэлбэр, байгууллагын жагсаалтыг Засгийн газар, УИХ-ын Нийгмийн бодлогын болон Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөн жил бүр батална.</p>			
<p>Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл батлах тухай Монгол улсын Их хурлын тогтоол. Дугаар 65. 2002 оны 7-р сарын 10. Улаанбаатар хот.</p>					
<p>Соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх тодорхойлолт</p>	<p>Соёлын бодлогын үндсэн зарчим, түүний хөгжлийн уг сурвалжийн тодорхойлолт</p>	<p>Соёлын удирдлагыг боловсронгуй болгох үндсэн чиглэл</p>	<p>Соёл, урлагийн байгууллагын санхүүжилтийн үндсэн зарчмууд</p>	<p>Хөдөө орон нутаг дахь соёл урлагийн байгууллагыг бэхжүүлэх үндсэн чиглэл</p>	<p>Хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах болон хөрөнгийн эх үүсвэр бий болгох талаар</p>
<p>1.1. Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийн зорилго нь</p>	<p>1.2.1 удирдлагын төвлөрлийг сааруулах, чадамжийг бэхжүүлэх 1.2.2 нийгмийн салбарын үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх 1.2.3 байгууллагуудын бие даасан байдлыг дээшлүүлэх</p>				<p>1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 34 –р зүйлд заасан аргуудын зэрэгцээ удирдлагын гэрээ, гүйцэтгэлийн гэрээ, түрээсийн гэрээ, төсвийн санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг тодорхой хувиар</p>

<p>нийгмийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний чанар, үр ашиг, хүртээмжийг сайжруулахад оршино.</p>	<p>1.2.4 үйлчилгээнд шинжлэх ухааны ололт, тэргүүний техник, технологи, дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх 1.2.5 зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжихийн зэрэгцээ төрийн зохицуулалтыг оновчтой болгох 1.2.6 өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын оновчтой арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх</p> <p>1.3.1 ил тод нээлттэй, шударга байх 1.3.2 үйлчилгээ, үйл ажиллагааны хүрсэн түвшинг бууруулахгүй байх, сайжруулах 1.3.3 үйл ажиллагааны чиглэл, зориулалтыг өөрчлөхгүй байх 1.3.4 үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх 1.3.5 ажиллагчдад учрах эрсдэлийг бууруулах</p>				<p>бууруулж хувьчлах зэрэг арга хэлбэрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын онцлогт тохируулан дангаар буюу хослуулан хэрэглэнэ. Удирдлагын, гүйцэтгэлийн, түрээсийн гэрээгээр ажиллуулах журмыг Төрийн өмчийн хороо холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн баталж хэрэгжилтэд хамтран хяналт тавина. 1.5 Өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын хамрах хүрээ 1.5.1. 3/ соёл урлагийн бүх байгууллагууд 2.1.1. 5/ үндэсний хэмжээнд үйлчилдэг мэргэжлийн соёл, урлагийн байгууллагын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх 2.1.1. 9/ Дүрслэх урлагийн музей, уран зургийн галерейг нэгтгэн Үндэсний урлагийн музей болгон өргөтгөн зохион байгуулах</p>
<p><i>Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэлт, хувьчлал хийх үндсэн чиглэл нь зорилго, зарчмын хувьд төрөөс тогтвортой баримтлах соёлын бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн гэж үзэж болохоор байгаа боловч түүнийг <u>хэрэгжүүлэх арга хэлбэрийг олон л байвал сайн</u> гэдэг зарчмаар хандсан нь эргээд харин ч <u>“тогтворгүй, тодорхойгүй бодлого баримтлах болоо юу”</u> гэсэн сэтгэгдэлийг төрүүлж байна. Учир нь хэрвээ өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын олон арга хэлбэрийг зөвшөөрч байгаа бол соёл, урлагийн салбарт төрөөс баримтлах бодлогынхоо үүднээс аль аргыг хаана хэзээ ашиглахыг зааж өгөх нь зүйд нийцэх буй за. Өөрөөр хэлбэл соёл урлагийн аль салбар, байгууллага, үйл ажиллагааг ашгийн бус хэлбэрээр бие даалгаж, үйлчилгээнийх нь чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, алийг нь ашиг олох зориулалтаар хөрөнгийг нь худалдах вэ гэдэг бодлогын чухал хэсэг тусгагдаагүй байгаа нь тодорхойгүй, ил тод бус болгожээ. Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын амжилттай хэрэгжиж буй жишээ баримт соёл урлагийн салбарт тааруухан байгаа нь чухам үүнтэй холбоотой байж тун болзошгүй.</i></p>					

Соёл, урлагийн хөгжлийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчин, тулгамдсан асуудлын талаар соёл, урлаг судлаачид, соёл, урлагийн байгууллагын ажилтнууд, судлаачдын санаа бодол ямар байгааг авч үзье.⁵

МУЗ-ийн Тэргүүн Н.Жанцанноров:

...Өнөөдөр бид юуг эрхэмлэн үзэх вэ гэдэг гол асуудлаа мэдэхгүй байна...

Соёл урлагийн байгууллагын бие даан оршин тогтнох чадвар сул байгаа тул энэ үед БСШУЯ-ны Соёл, урлагийн бодлого зохицуулалтын газраас 2010 он хүртэл соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг Монголын соёлыг дэмжих талаар гаргасан маш том санаачлага, баримт бичиг гэж хүлээж авлаа. Монгол Улсын Засгийн Газар соёлын бодлогодоо оновчтой шинжилгээ, судалгаа хийж чадвал түүний хэрэгжилт бодитой байж чадна. Энэ мастер төлөвлөгөөг гаргахад зарим нэгэн чухал зүйлийг нэмж бодох ёстой байсан. Тухайлбал, Санхүүгийн эх үүсвэрийн тухай:

1. Төрөөс санхүүжүүлэх,
2. Үзвэр үйлчилгээг бие даан явуулж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх,
3. Сан бүрдүүлэх,
4. Идэвхитэй төрийн бус байгууллагыг дэмжих гэх мэт олон арга зам байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

Монголын Урлагийн зөвлөлийн удирдах зөвлөл соёлын бодлого ба санхүүжилтийн талаар хэдэн саналуудыг дэвшүүлэн тавьж байгаа юм. Үүнд:

1. Татварын хөнгөлөлт. Энэ нь улсын төсвийг нимгэрүүлэх далд эдийн засгийн аргаар бус, төсвөөс зарцуулах мөнгөний хэмжээг ихэсгэж соёл урлагаа хөгжүүлэх бодлогыг авч явуулах асуудал юм.
2. Засгийн газрын мастер төлөвлөгөөнд хүчтэй тусгагдаж чадаагүй нэг санал байна. Энэ бол соёлын жуулчлалын асуудал юм. Монголын үзэсгэлэнт байгаль орчин, нүүдэлчний онцлогтой үндэсний соёл хоёртой танилцахын тулд жуулчид Монголд хүрэлцэн ирдэг. Миний бодлоор төрийн захиргааны төв байгууллага салбарын бодлого явуулж байгаа боловч үүнийг зохицуулах хүчтэй механизм /хяналт/-ыг бүрдүүлж чадаагүй байна.
3. Урлагийн шинэлэг сан бүрдүүлэх. Сан бүрдүүлэх асуудал өөрөө чухал олзуурхууштай зүйл юм. Урлаг өөрөө show болох, show өөрөө урлаг болох буруу хандлага ноёрхож байна. Цагаан сарын өмнө, сонгуулийн компани ажлын үеэр урлагийг худалдаж байна. Хонжворт сугалааны /lottery/ чиг хандлага холбогдлын талаарх асуудлыг орхигдуулж байна.
4. Хүчтэй шүүмж судлал, мэргэжлийн үнэлгээ, судалгаа зайлшгүй шаардлагатай байгааг анхаарах цаг болсон.
5. Монголын шашин соёлын уялдаат уламжлалыг тухайлан судлах
6. Олон улсын туршлагыг судлан, өөрийн орны онцлогт тохируулан нэвтрүүлэх зэрэг болно.

Л.Эрдэнэчимэг /БСШУЯ-ны Соёл урлагийн бодлого зохицуулалтын газрын дарга/:

Өнөөдөр Монголын соёлын амьдралын бүхий л ачааллыг БСШУЯ-ны Соёл урлагийн бодлого зохицуулалтын газарт 8 хүн үүрч байгаа учир бид хаанаа ч хүрэлцэхгүй тарамдаж байна.

Одоогоор 21 аймагт 21 театр чуулга, 157 орон нутаг судлах музей ажиллаж байна. Судалгаанаас үзэхэд 29 сумын Соёлын төвийг нэн даруй засварлах шаардлагатай байгаа юм. Өнгөрсөн хугацаанд бид 140-өөд сумын соёлын төвийг хөгжмийн техник хэрэгслээр ямар нэг хэмжээгээг хангаад байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн Соёл урлагийн байгууллагын хөгжлийн хэтийн төлөвийг боловсруулж байна.

Сүүлийн жилүүдэд номын хандив төсөл нэлээд орж ирж байгаа. Өнгөрсөн жил номын 4 том сүлжээ оруулж ирсэн. Энэ сүлжээний гол зорилго нь ном хэвлэлийг хэрэглэгчдэд түргэн хүргэх зорилготой бөгөөд номын санг ирээдүйд мэдээллийн төв болгох үйл ажиллагааны бэлтгэлийг хангахад чиглэж байна.

⁵ “Урлагийн бодлого ба санхүүжилт” Олон улсын зөвлөлгөөний тэмдэглэл. Улаанбаатар хот. 2003.06. 10 – 11.

Ч. Дашдаваа /Соёл урлагийн их сургуулийн Соёл урлагийн удирдлагын факультетын декан/:

Соёл, урлагийн салбар дахь төрийн санхүүжилтын үндсэн хэлбэр нь төсвийн шууд санхүүжилт хэвээр байгаа юм. Төвлөрсөн төсвөөс санхүүждэг соёлын болон мэргэжлийн урлагийн байгууллагууд нийт зардлынхаа тодорхой хувийг өөрийн орлогоор нөхөх болсныг тэмдэглэх хэрэгтэй.

Төсвийн шууд биш санхүүжилт нь соёл урлагийн хөгжлийг дэмжих тусгай сан байгуулах, нийгэмд үйлчилдэг ашгийн төлөө бус соёл урлагийн байгууллагуудыг орлогын татвараас чөлөөлөх зэрэг хэлбэрээр үндсэндээ хэрэгжиж байна. Тухайлбал, хөгжмийн болон урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах, олон улсын урлагийн уралдаан тэмцээнд оролцож онцгой амжилт гаргасан уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох, соёлын ажилтан уран бүтээлчдийг мэргэжил дээшлүүлэхэд санхүүгийн тусламж үзүүлэх зэрэг хэлбэрүүдийг дурдаж болно.

Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэний үр дүнд соёл урлагийн салбарын төрийн бус байгууллагууд олноор байгуулагдсаныг тэмдэглэх хэрэгтэй. Гэвч эдгээрийн дотроос тогтмол үйл ажиллагаа явуулдаг байгууллага цөөн байна. Үүний шалтгаан нь тэдэнд санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр байхгүй, зах зээлд тодорхой байр суурь эзэлж чадаагүй, мэргэшсэн менежер, маркетингийн алба дутагдалтай зэрэгт оршиж байна. ... Гэвч соёл урлагийн салбарт хөрөнгө хандивласан аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй нь энэхүү үйл ажиллагааг идэвхижүүлэхэд саад болж байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй.

Монголын соёл урлагийн хөгжилд Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын сан/ ихээхэн тус дэмжлэг үзүүлж ирсэн, үзүүлсээр байгааг онцлон тэмдэглэх учиртай. Чухамхүү Соросын сан, Монголын Урлагийн Зөвлөлийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын соёл урлагийн олон байгууллага уран бүтээлчдийн үйл ажиллагаа идэвхжсэн юм. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийн дагуу Монгол улс 2003 оноос эхлэн удирдлага, санхүүжилтын шинэ тогтолцоонд шилжсэнээр хариуцлагын тухай тогтолцоонд цоо шинэ утга санааг оруулж өгсөн юм. Засаглал хариуцлагатай байна гэдэг нь хэн юуны төлөө, ямар хариуцлага хүлээж буй нь нээлттэй, ил тодорхой байхыг хэлж байгаа билээ. Төсвийн байгууллага бүр ямар үйл ажиллагаа үйлчилгээ /бүтээгдэхүүн/ “үйлдвэрлэж байна вэ гэдэгт голлон анхаарч, үүнийх нь төлөө хариуцлага тооцож байхаар болж байна. Бүтээгдэхүүний гол шалгуур үзүүлэлтүүд нь тоо хэмжээ, чанар, цаг хугацаа, өртөг зардал болно.

Соёл урлагийн байгууллагуудад оршин байгаа нийтлэг дутагдал, сул тал нь үр дүнгийн гэрээг зохих заавар, загварын дагуу боловсруулаагүй, чанарын шалгуур үзүүлэлтийг тэр бүр оновчтой тодорхойлоогүй, бүтээгдэхүүн тус бүрийн нэгжийн өртгийг нарийвчлан тооцож тогтоогүй зэргээр тодорхойлогдож байна. Хэдий тийм боловч энэ шинэчлэл нь соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, бүтээгдэхүүний үнэ өртгийг хямдруулах, үргүй ажиллагааны үр өгөөжийг сайжруулахад тус нэмэр болно гэдэг нь тодорхой байна.

Монголын соёл урлагийн байгууллагуудын яаралтай шийдвэрлэвэл зохих асуудлын нэг нь соёл урлагийн байгууллага дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд оршиж байна.

Соёл урлагийн төрийн болон төрийн бус байгууллага, арилжааны шинжтэй байгууллага, арилжааны шинжтэй байгууллагуудын аль алинд нь **фандрейзингийн арга зүйг эзэмших явдал нэн чухал зорилт болж байна.**

Монголын менежерүүд гол төлөв томоохон компани, пүүс, банкны удирдлагад л хандаж байгаа юм.

Соёл урлагийн байгууллагуудад **хувь хүмүүсээс оруулах хандивыг нэмэгдүүлэх асуудлыг** авч үзэхдээ Монгол орны өвөрмөц онцлогт тохирсон арга хэлбэрүүдийг тогтоон ашиглах шаардлагатай байгааг ч анхаарахгүй байж болохгүй. Тухайлбал, мөнгөн бус хэлбэрээр хандив цуглуулж болох билээ. Малчин түмний сайхан сэтгэлийн өглөг болох нэг хонь, килограмм ноолуур, ганц нэхийг ч гэсэн соёл урлагийг дэмжих аль нэг санд хуримтлууж зах зээлд нийлүүлж чадвал сумын, аймгийн бүс нутгийн соёл, урлагийн хөгжилд ихээхэн тус нэмэр болох нь эргэлзээгүй хэрэг.

... соёл урлагийн байгууллагуудтай харьцуулахад тухайн компани, пүүсийн имижийг дээшлүүлэхэд илүү үр дүнтэй тусламж үзүүлж чадна гэдэгт тэдгээрийн удирдлагыг итгүүлж чаддаг байх ёстой.

... хөрөнгө хандивлагчдыг нэг удаа “ашиглах” бус харин тэдэнтэй байнга харилцаа холбоотой байх, тухайн соёл урлагийн арга хэмжээг санхүүжүүлснээрээ түүнийг бүтээгчийн нэг хэмээн өөрийгөө бүрэн эрхтэй үзэх тийм нөхцөл байдлыг бүрдүүлэх шаардлагатай байдаг.

Соёл урлагийн байгууллагууд маркетингийн стратегийг боловсруулах ажлыг мэргэжлийн түвшинд хийж ажиллах шаардлагатай байгаа юм.

... соёл урлагийн арга хэмжээнд аль болох олон хүнийг хамрахын тулд тасалбарынхаа үнэнд хөнгөлөлт үзүүлэх олон хэлбэрийг ашиглах, ашиг орлого олохын тулд зар сурталчилгааны хэлбэрүүдийг өргөн ашиглах, соёл урлагийн арга хэмжээг багцлах зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, цуврал тоглолтуудыг чадамгай зохион байгуулж сурах нь чухал байна.

Манай оронд соёлын эдийн засаг хэмээх тусгай шинжлэх ухааныг эрчимтэй хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Зах зээлийн нөхцөлд соёл урлагийн тоглолтыг нийт хүн амд, ялангуяа хөдөөгийн хүн амд хүргэх зорилтыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэсэн асуудал тулгамдсан зүйл болоод байна.

Социологийн судалгаанд хамрагдсан таван хүний нэг нь миний оршин суугаа газар урлагийн үйлчилгээ байдаггүй гэсэн хариулт өгчээ. Тэд ихэвчлэн аймгийн төв, том хотод хааяа нэг орж ирэх үедээ л үзвэр үздэг нь судалгаанаас харагдаж байна. Соёл урлагийн ололтыг олон түмэнд хүргэхийн тулд орчин үеийн техник хэрэгслийг өргөн ашиглах, технологийн хувьд шинэ арга замыг эрэлхийлэх талаар судлах, бодох, хийх зүйл их байна.

Мэргэжлийн уран бүтээлчдийн дунд явуулсан социологийн судалгааны дүнгээс үзэхэд төсвийг зөв зарцуулах, соёл урлагийн талаар цэгцтэй бодлого барьж ажиллах, санхүүжилтын асуудлыг шийдвэрлэх, менежементийн зөв бодлого явуулах, техник, тоног төхөөрөмжөөр хангах гэсэн санал давтамж ихтэй байна.

Судалгаанд хамрагдсан уран бүтээлчдийн 47.8 хувь нь мэргэжлийн театр, урлагийн байгууллага нэлээд тооны байнгын уран бүтээлчтэй байх ёстой гэж үзсэн байхад 41.0 хувь нь

Санин Драгожевич /Загребын Их Сургуулийн багш, Хорват/:

Төрөөс соёл урлагийн бодлогыг хэрэгжүүлэхэд хариуцлагын тогтолцоог хэрхэн бүрдүүлдэг талаар авч үзье.

1. Төрд туслах заавар. Энэ нь соёлын бүтээгдэхүүнийг чухалчлан авч үздэг. Үүнтэй уялдаад соёлын зах зээл гэдэг ойлголт гарч ирнэ. Энд соёлын менежемент чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь хэрэгцээний чиглэлтэй загвар юм. Энэ загвар АНУ, Англид хэрэглэдэг. Үүний онцлог нь тогтвортой соёлын байгууллага байдаггүй. Давуу тал нь үр ашигтай менежементийг хэрэгжүүлэх боломжтой. Соёл урлагийн санхүүжилт бүүраад байгаагийн гол шалтгааныг төр өөрийн хариуцлагыг бусдад шилжүүлэх сонирхлын илэрхийлэл хэмээн үзэж болно. Бүхий л оронд байгаа түгээмэл асуудал бол санхүүжилт, хүний нөөцийн асуудал байдаг.

2. Хөхиүлэн дэмжих төрийн бодлогын загвар. Энэ нь цэвэр Европ загвар. Европын олонхи оронд тархсан. Англид түгээмэл хэрэглэж байгаа. Соёл урлагийг улс төрөөс тусгаарлах онцлогтой загвар юм. Соёл урлагийн асуудлаарх бүх үйл ажиллагааг урлагийн мэргэжлийн хүмүүс удирдаж авч явдаг. Нэг талаас мэргэжлийн урлагийн байгууллагад анхаарлаа хандуулж, нөгөө талаас олон нийтийн санаа бодолд анхаардаг онцлогтой. Энд урлагийн бүтээл гол үүрэг гүйцэтгэдэг учир эхний загвартай их төстэй.

3. Иргэний сектор /мэргэжлийн олон нийтийн холбоо Civil sectors/ төрөөс тусдаа бие даан ажилладаг олон нийтийн байгууллага. Төрөөс санхүүждэг боловч төрөөс тусгаар үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр байгууллагууд төрийн бус байгууллагын бүртгэлтэйгээр ажилладаг онцлог нь ашгийн бус үйл ажиллагаа явуулах бололцоог олж авдагт оршино. Холбоо, ассоциаци байгуулах явдал сүүлийн үед олширч байна.

4. Arcitect загвар. Францад баримталдаг. Онцлог нь захиргааны чиглэлтэй, цац хэлбэртэй. Үүрэг хариуцлагыг гол болгодог. Бодлого нь зохицуулахад амар байдгаараа онцлогтой. Сул тал нь хэт захиргааны шинжтэй.

Privitization буюу хувьчлалын асуудал Соёл урлагийн байгууллагын чухал хэсэг мөн үү? Биш үү? гэдгийг бодох ёстой. Хорватад олон соёлын төвийг хувьчлах оролдлого хийсэн. Хувьчлагдсан соёлын төвүүд жилийн дараа чиглэл нь бүр мөсөн өөрчлөгдсөн. Нэг театрыг хувьчилсан.

Камерны театр болж өөрчлөгдсөн. Хувьчлалд эрх зүйн үндэс маш чухал. **Чиглэлийг нь өөрчлөхгүй байх хууль эрхийн үндсийг маш сайн бүрдүүлсэн байх ёстой.**

Соёл урлагийн байгууллагын тодорхой хэсгийг хувьд худалдах арга байна. Төрийн ачааг хувийн секторт өгөх нь зөв боловч чухам яаж өгөх вэ? гэдэг асуудлыг зөв шийдэх! Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих нь чухал!

Яаж Соёл урлагийн салбарт юуг урьдал болгох вэ? Яаж зөвшилцөөнд хүрэх вэ?

-Задлан шинжлэх /бодлогын/ хийх замаар байгаа туршлагаадаас юу нь таарах, юу нь таарахгүй вэ? гэдгийг бодож сонголт хийх

- Олон нийтийн хэлэлцүүлэг хийхгүйгээр соёл урлагийн талаарх бодлого тодорхойлох боломжгүй юм. **Их хурлаас эхлээд хувь хүн хүртэл өргөн хүрээнд олон нийтийн хэлэлцүүлгийг хийсэн байх шаардлагатай.**

- Стратеги тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах. **Урьдал болгох урлагийн төрлийг салбар салбараар тодорхойлох.** Хорватад киноны асуудлыг эн тэргүүнд тодорхойлж байсан.

Танай оронд дээрхи олон загваруудаас 2-р загвар буюу Соёл урлагийг хөхиүлэн дэмжих төрийн бодлогын загвар чухал болов уу гэж бодогдоно. Энэ нь дараах 3 түвшинд боловсрогдсон байдаг. Үүнд:

- I. Улсын хэмжээ /төрийн, үндэстний/- ний соёл урлагийн бодлого
- II. Орон нутгийн түвшинд баримталж хэрэгжүүлэх соёл урлагийн бодлого
- III. Local. Локаль соёлын бодлого.

Эдгээрээс орон нутгийн түвшинд баримталж хэрэгжүүлэх соёлын бодлого хамгийн чухал болж байна. Энэ нь орон нутгийн нөөцийг дайчилж чадах боломжтойгоор давуу талтай.

Тухайлбал: Испани үүнийг маш сайн хэрэгжүүлсэн орон.

Тэргүүн зэргийн асуудлыг тодорхойлох холимог хэлбэр байж болно. Монголын нийгмийн салбар хоорондын уялдаа /яам хооронд/ зохицуулалтыг хүчтэй болгож байж хөгжил явна.

- Бодлого ил тод байх ёстой. Мэргэжлийн хүмүүсээр шинэчлэгдэн баяжиж байх ёстой. Бодлого каталист шинж чанартай, өөрөөр хэлбэл шинэ юмыг гаргаж ирэх чадвартай байх. Соёл урлагийн салбарын үйл ажиллагааг нийгмийн бүх салбартай уялдуулан хөгжүүлэх. Тухайлбал,

- Боловсрол
- Аялал жуулчлал
- Шинжлэх ухаан
- Музей
- Номын сан
- Архив
- Мэдээлэл гэх мэт академик болон бусад үйл ажиллагааны

чиглэлүүдийн хүрээнд маш нягт уялдуулан зохицуулах чадвар хэрэгтэй байдаг.

Салбар хоорондын комиссыг /хороо/ Засгийн газраас тогтоож өгдөг. Орон нутгийн хамгийн сонирхолтой, оновчтой саналыг авч үзэж уралдаан зохион байгуулж хэрэгжүүлдэг арга бий. Орчин үед буурай хөгжилтэй орнуудад Соёл урлагийн салбарыг салбар хоорондын уян хатан зохицуулалтын механизмаа л удирдах замаар амжилт олж байна. Дангаар нь соёл урлагийг хөгжүүлнэ гэж зүтгэх нь харалган зүйл болно. Салбар хоорондын үйл ажиллагааг доороос зохицуулаад байх биш, гол нь дээрээс үйл ажиллагааг авч явуулах шаардлагатай гэдгийг анхаарах ёстой.

Бид боловсрол, эрүүл мэндийн салбартай өрсөлдөнө гэж байхгүй. Соёл урлаг төрийн бодлогын хамгийн сүүлд тавигддаг нь нууц биш билээ. Бид дангаараа соёл урлагийг хөгжүүлнэ гэж зүтгэж болохгүй гэх мэт олон зүйлийг энд анхааруулмаар байна.

Л.Дашням, Монгол мэдлэгийн их сургуулийн ректор, доктор, профессор:

Төр оюуныг зөвхөн чөлөөлөөд орхих биш, чөлөөлөгдсөн оюуныг яаж хөгжүүлэх вэ гэдгийг төрийн бодлогоор зохицуулах ёстой.

Төрд баримтлах үндсэн 6-7 чиг байдаг боловч тэдгээрийн дундаас голчлон гуравхан элементийг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж миний бие үзэж байна.

1. Боловсон хүчин, хүний нөөцийн асуудал. Соёл урлагийн бүтээгдэхүүний чанарыг, бүтээгч эх үүсвэр нь хүн өөрөө учир, төр маань энэ тал дээр тогтож бодлогоо боловсруулан хөгжүүлэх учиртай
2. Одоогийн байдлаас үзэхэд энэхүү соёл урлагийн эрх зүйн таатай орчин гээд байгаа зүйлийг бүрдүүлэн өгч чадаагүй байна.
3. Эдийн засгийн механизм, санхүүжилтын асуудал. Соёл урлагийн салбарын төсөв нь ч бага, хажуугаар нь түүнд зориулан хааяа нэгтээ хуваарилагддаг хөрөнгө нь ч бүрэн гүйцэд зориулалтаараа зарцуулагдахгүй байгаа нь ажиглагддаг.

Санин Драгожевич, Хорват:

Art menegment – урлагийн менежментийн дараах загваруудыг та бүхэнд толилуулъя.

1. Захиргааны загвар
2. Олон нийтийн байгууллагын загвар
3. Хөхиүлэн дэмжих загвар
4. Оролцооны загвар

Санхүүжилтын үндэсний хэлбэрүүд

1. Байгууллагыг санхүүжүүлэх
2. Хөтөлбөрийн санхүүжилт хийх
3. Өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг загвар. Энэ нь соёл урлагийн үйлдвэрлэл, үйлчилгээ, мэдээллийн технологитой холбоотой үйл ажиллагаанд чиглэгддэг
4. Холимог загвар. Энэ нь дээрхи бүх загварыг нэгтгэдэг үйл ажиллагаа юм.

Гадаадын орнуудад урлагийн бүтээлийг дэмжих, уран бүтээлчдийг нь дэмжих зэрэг олон чиглэлийн аргууд байдаг. Энэ нь нэг талаас уран бүтээлчдийн хувьд маш сайн зүйл юм. Англид бол эсрэгээр байдаг. Уран бүтээлч орон нутагтаа тодорхой үр нөлөө бүхий үйл ажиллагаа явуулах гэж байгаа бол тэтгэлэг олгодог. Энэ нь илүү прагматик хандлага юм. Соёл урлагийн чиглэлийн олон улсын хурал зөвлөлгөөнийг тэтгэх тэтгэлэгүүд байна. Олон Улсын сүлжээнд ажиллах, урлагийн тодорхой салбараар бүтээл тууривах, Төр буюу сангуудын сүлжээний хэмжээнд өөрийн бүтээлээ үзүүлж, үнэлгээ авдаг янз бүрийн арга байна. Сургалтын тэтгэлэг гэдэг бас нэгэн чухал хэсэг бий.

Шууд бус санхүүжилт гэдэг нь ихэвчлэн нийгэм дотроо зарим салбарыг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа юм. Соёлын үйл ажиллагаа гэдэг нь арилжааны бус үйл ажиллагаанууд байдаг. Иймээс түүнийг шууд бус хөрөнгө оруулалтын хэлбэрт тооцдог бөгөөд энэ нь нийгмийн гишүүдээ эргээд ихээхэн үр дүнгээ өгдөг зүйл. Олон оронд тухайлбал, Чехэд өөрийн үндэсний телевизээр гаргасан ямар ч гадаадын киноноос татвар авдаг байсан. Энэ татварын мөнгөө соёл урлагийн сан, телевизийн хөгжлийн сан руугаа хийж зарцуулдаг.

Юрий Волковский:

Лобби яаж хийх вэ?

Үндэсний парк хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлснээ ярья.

Үүнд:

- Улс төр
- Урлагийнхан
- Бизнесийнхэн
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- Олон нийт
- Бага ястнууд
- Эрдэм шинжилгээнийхэн их өргөн хүрээтэй оролцсон.

Юрий Вулковски, Софи хотын соёлын бодлогын Соросын Төвийн зохицуулагч:

Орчин үеийн нийгмийн хөгжлийн явцад соёлын үүргийг дахин тодорхойлох шаардлага гарч ирсэн юм. Соёл урлаг нь нийгэм, улс төр, эдийн засаг, нийгмийн дэвшил, хүний хөгжилд яаж нөлөөлдгийг судлан тодруулсны үндсэн дээр соёл урлагийн нийгэмд эзлэх байр суурийг дахин тодорхойлох болсон байна. Соёл урлагийн салбар бусад салбартай адилгүй, нийгмийн хөгжилд онцгой нөлөөтэйг гаргах нь чухал болов.

Соёл урлагийн салбарын хөгжлийг эдийн засаг болон бусад салбарын хөгжилтэй нягт уялдуулан зохицуулвал нийгэм хөгжихийн эх сурвалж болно. Манайд орон нутгийн соёлын сангууд байгуулсан. Орон нутгийн татварын тодорхой хувийг соёл урлагт зарцуулах болсон. Орон нутгийн соёл урлагийн байгууллагын тулгамдсан асуудлыг сайн мэдээлдэг болсон нь том бизнесменүүд соёл урлагийг ойлгож туслах нөхцлийг буй болгосон юм.

Соёл урлагийн тулгамдсан асуудал нь төрийн бүтэц тогтолцоо, улс төрийн байдал, нийгэм эдийн засаг, хууль зүй, бизнесийн байгууллагууд, иргэд хэрэглэгчид болон соёл урлагийн байгууллагууд, уран бүтээлчид зэрэг олон талт хүчин зүйлсээс хамаарч гарч ирдэг учраас түүнийг шийдвэрлэх арга замыг мөн л дээрхи олон талаас нь эрж хайх, судалж тогтоох ёстой.

Орон нутгийн бизнес, засаг захиргааг хэрхэн холбож байгааг хэвлэл мэдээллээр мэдээлж, соёл урлагийн тулгамдсан асуудлыг хөндсөний дараагаар бизнесменүүд дэмжиж, хотын хэмжээнд соёлын сангууд зохион байгуулагдсан. Иргэд маш ухамсартайгаар соёлоо хөгжүүлэх хэрэгтэй гэдгийг ойлгосон.

Шаталсан хэлбэрээр гарсан хууль хэрэгжих нь маш сайн байдаг. Энэ нь цаашлаад үндэсний хэмжээний хөгжлийг авч ирдэг ач холбогдолтой.

Лидия Варбанова, ННХ-ийн Соёл урлагийн сүлжээний хөтөлбөрийн захирал. Унгар / Болгар.

Одоо бид соёл урлагийг ивээн тэтгэж дэмждэг арга замуудыг авч үзье. Үүнд:

- Ивээн тэтгэлэг
- Хандив гэсэн үндсэн 2 арга зам байдаг.

Ивээн тэтгэлгийн асуудал дээр татварын бодлого маш чухал үүргийг гүйцэтгэдэг. Латвид нийт татвар төлж байгаа орлогын 20-иос илүүгүй хувийг соёл, урлагт зарцуулж болно гээд хуулиндаа заачихсан байдаг. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, буяны үйл ажиллагаа, спортод энэхүү 20%-г өгч болно. Латвийн хууль тогтоомж нь энэ 3 ашгийн бус байгууллага:

- Соёлын сан
- Олимпын хороо
- Хүүхдийн сан гэсэн энэ 3 ашгийн бус байгууллагад хандиваа өгөхийг дэмждэг.

Тэгвэл Македоны хууль арай өөр байдаг. Энд тухайн байгууллага өөрийн жилийн эргэлтийн хөрөнгийн 3-аас илүүгүй хувийг өгч болдог. Байгууллага: Улаан Загалмай, Төрийн Бус, ашгийн бус байгууллагад өгч болно. Нийт орлогын 15%-иас илүүгүй хувийг боловсрол, эрүүл мэнд, соёл, шинжлэх ухааны байгууллагад хандивлаж болдог. Чех улсад ийм төрлийн хандив 5%-иас дээшгүй байдаг. Тэгэхдээ Чех, Унгарт хувь хүнээс хандив өгч болдог. Дээр ярьсан зүйлс байгууллагад хамаарагдана. Чех улсад хувь хүний татварын 10-аас дээшгүй хувийг зарцуулахаар заасан байдаг. Унгарт улсын төсөвт төлж байгаа татварын 1-ээс дээшгүй хувийг зарцуулах эрхтэй. Зарим оронд нийт орлогынхоо тэдэн хувийг гэж тодорхой заасан байхад зарим байгууллагад татварт ноогдох мөнгөний дүнгийн тэдэн хувь гэж заасан байдаг.

Милена Драгевич Шешич, Белградын СУИС-ийн ректор, ННХ-ийн СУСХ-ийн УЗ-ийн дарга.

Киноны хуулинд телевизийн киноны 40-өөс доошгүй хувь нь үндэсний кино байх ёстой гэж заасан учир гадны олон муу хямд кино телевизийг эзлэхээс сэргийлж чадсан. Кино гарах болгонд зохиогчид нь зохиогчийн урамшил төлж байх зарчимтай.

Санин Драгожевич, Загребын Их сургуулийн багш, Хорват.

Урлагийн байгууллагаа хувьчилсан орнуудад зөвхөн ашигтай байх зарчмаа баримталдаг. Иймд жинхэнэ урлагийн бүтээлийг тэд тавьдаггүй. Театр, үзэсгэлэнг хувьчлахад ашгаа л хөөдөг. Иймд тэд урлагийг жинхэнэ утгаар нь хийх боломжгүй байдаг. Соёл урлагийн байгууллагыг хувьчилж авсан хүнд зөвхөн байр нь хэрэгтэй байдаг нь барууны хэвлэх үйлдвэрийн олон хувьчлалаас харагддаг. Номын дэлгүүрүүд мөн энэ замаар орсон.

Хорватад Соёл урлагийн байгууллагын хувьчлал үндсэндээ зогссон. Таатай сэтгэгдэл үлдээгээгүй. Гэхдээ нааштай үр дүнгүүд бий. 1990 онд соёл урлагийн байгууллагыг шинээр буй болгох эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн. Үүний үндсэн дээр Хорватад анхны хувийн музей үүссэн.

Лидия Варбанова

“Хувьчлал” гэдэг нэр томъёо **их хоосон, олон талтай ойлголт** юм. Энэ нь:

- Автономыг буй болгодог
- Арилжаалах боломжийг бүрдүүлдэг

Яагаад, юуг хувьчлах вэ? гэдгийг эхлээд сайн бодож тогтоох ёстой. Гурван төрлийн хувьчлал бий.

Үүнд:

1. Санхүүжилтын хувьчлал
2. Менежментийн /ашгийн бус, менежментийг үр ашигтай болгох хувьчлал юм/ Энэ төрлийн хувьчлалыг автономжуулах гэж ойлговол зохино.
3. бодит хөдөлшгүй хөрөнгийг худалдаж авснаар үр ашиг буй болгох явдал. Эдгээрээс сүүлчийнх нь жинхэнэ хувьчлал юм

Весна Чопик:

Соёл урлагийн салбарт удирдлагын буюу менежментийн хувьчлал хамгийн оновчтой гэсэн дүгнэлтэнд бид хүрсэн. Санхүүжүүлэгч нь төр хэвээр байгаад авсан мөнгөө үян хатан зарцуулах эрхийг олгодгоороо хувьчлалын энэ хэлбэр давуу талтай. Дан хувьчлалаар асуудлыг шийдэх биш, төрийн санхүүжилт, менежментийн хувьчлалын зохист харьцаагаар асуудлыг шийдвэрлэх нь илүү ач холбогдолтой юм

Д.Цэрэнсамбуу, ДУАТ-ын дарга.

Манай Монголд орлого сайн олох тусам улсын төсвийг хасаж өгдөг, ажил хийх тусам төр нь тэр байгууллагаа торгодог бодлогоо болих!

С.Идшинноров, Үндэсний түүхийн музейн захирал.

Төсвийн хөрөнгө нь музейн дулаан, гэрэл зэрэгт төлөгдөөд дуусдаг. Цаана нь соёл урлагийн байгууллага өөрийн чиг үүргээ биелүүлэх үйл ажиллагааг төр дэмжихгүй байна. Үндэсний түүхийн музей жилд гуравхан сая төгрөгөөр үзмэр худалдаж авах төсөвтэй. Энэ үнэхээр гунигтай. Ийм байдлаасаа болж манай соёл урлагийн байгууллагууд үндсэн үүргээ бүрэн биелүүлж чадахгүй байна.

Г.Мэнд-Ооёо:

Хэрэг дээрээ соёлын жуулчлал хөгжиж байна. Харин энэ үйл ажиллагааны орлогоос олсон хөрөнгийг соёл урлагт яаж оруулах вэ гэдэгт Засгийн газарт санал тавьж шийдүүлэх шаардлагатай байна. Төр идэвхитэй чадварлаг байж төрийн бус байгууллага, хүмүүст эрх үүрэг шилжүүлэх замаар соёл урлагийг дэмжих бодлого явуулах хэрэгтэй байна. Харин төр нь бодлогоо барьж, хуулиа боловсруулдаг байх чиг хандлага баримтлах нь илүү оновчтой бус уу?

Д.Энхцэцэг, Галерейн захирал.

Соёлын хуулийн заалтууд нь удирдлага санхүүжилтийн хуулийн заалтуудтай нийцэхгүй зөрчилдөж байна. Үзэсгэлэн зохион байгуулж буй 100 төгрөг тутмын 98 төгрөг эргээд улсад байр, дулаан, цалинд явчихдаг. Үлдсэн 2 төгрөгөөр л үзэсгэлэнгийн болон бусад үйл ажиллагааг зохион байгуулж байгаа нь инээдэмтэй юм

Манай орны улс төр, нийгэм соёлын зүтгэлтэн, бизнес эрхлэгчид, соёл урлагийн ажилтнууд, иргэдэд илгээх захидал

1. Соёл урлагийн хөгжилд онцгой нөлөө бүхий соёлын жуулчлалыг хөгжүүлэх, төлөвлөх, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий яам дундын хороог БСШУЯам, Дэд Бүтэц, Хөдөө Аж Ахуй, Үйлдвэрлэл, Байгаль Орчны Яамдын төлөөллийг оролцуулан байгуулж тодорхой төсөл хэрэгжүүлэх, зайлшгүй шаардлагатай санхүүжилтыг улсын төсөвт тусгах
2. Засгийн Газраас гаргасан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу орон нутгийн соёл урлагийн байгууллагын хөгжлийг дэмжих, бүтэц зохион байгуулалт, санхүүжилтыг боловсронгуй болгох, хүний нөөцийг нэмэгдүүлэх асуудлаар БСШУЯам тодорхой асуудал боловсруулан төсөл хэрэгжүүлэх, зайлшгүй шаардлагатай төсвийг төлөвлөн, хуваарилах
3. Аливаа соёл урлагийн байгууллагын санхүүжилтэд Соёлын хуулийг чандлан мөрдөх, тухайн салбарыг өөрийн орлогоороо бие даан үйл ажиллагаа явуулах таатай орчинг бүрдүүлэх
4. Олон нийтийн соёл урлагийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн урлаг, гоо зүйн сургалтыг шинэчлэн өргөжүүлэх, багшлах боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоог сайжруулах талаар онцгой анхаарах.

Дээрх харьцуулсан шинжилгээ, соёл, урлаг судлаачид, соёл, урлагийн байгууллагын ажилтнууд, судлаачдын санаа бодолд үндэслэн Монголын соёл, урлагийн эрх зүйн орчинг дараах байдлаар үнэлж болох юм. Үүнд:

1. *Дэлхий нийтийн жишиг, олон улсын хөгжлийн хандлага, даяаршил хийгээд үндэсний өвөрмөц онцлогийн аль алийг харгалзан боловсруулсан хууль эрх зүйн тогтолцоог сүүлийн 10 шахам жилд бүрдүүлжээ. Үүний үндсэн шинж нь соёл, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийг тодорхойлж, түүний талаар төрөөс ямар бодлогыг баримтлах, түүний үндсэн зарчим нь ямар байх, төр засаг, иргэд ба соёлын байгууллагын эрх үүрэг ямар байх, соёлыг хэрхэн дэмжин хөгжүүлэх, түүнийг зах зээлийн тогтолцоонд амьдрах чадвартай, уян хатан байх ерөнхий нөхцлийг бүрдүүлсэн явдал юм.*
2. *Гэвч хэрэгжих механизм тодорхой бус, бусад хууль тогтоомжид хэрэгжилт, хяналтын зохих заалтуудыг суулган өгөөгүй, ерөнхийдөө тунхаглалын шинжтэй болжээ. Хэдийгээр соёлын талаар гүйцэтгэх засаглал, иргэд, байгууллагын хүлээх эрх үүргийг тогтоосон боловч мөн л тунхаг шинжтэй, хяналтын систем хэрхэн ажиллах, хяналтын үр дүнг юунд хэзээ хэрхэн ашиглах нь тодорхойгүй байгаа нь түүний амьдрах чадварыг бууруулжээ. Иймд соёл, урлагийн эрх зүйн ерөнхий орчинг сайн бүрдүүлсэн хууль эрх зүйн тогтолцоо бий болсон боловч түүний хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих систем бүрдэж чадаагүй гэж үзэж болохоор байна.*
3. *Соёл, соёлын үйл ажиллагаа, түүний өөрчлөлт, шинэчлэлт, хувьчлалын холбогдолтой эрх зүйн актуудыг олон нийтийн хэлэлцүүлэг, талуудын зөвшилцөлгүйгээр баталж байгаагаас салбар, яамд, агентлаг хоорондын уян хатан зохицуулалтын механизм байхгүй, иймд хэрэгжих, амьдрах чадвар муутай эрх зүйн орчин бий болжээ.*
4. *Соёл, урлагийн салбарын хөгжлийн стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоогүйгээс, тиймээс ямар арга хэлбэрийг хэзээ, хаана, яаж хэрэглэх нь тодорхойгүй, “төрөөс тогтвортой баримтлах бодлого” зөрчигдөхөд хүрч болзошгүй эрх зүйн орчин бүрджээ.*
5. *Соёл, урлагийн байгууллагуудыг өөрчлөх, шинэчлэх, хувьчлах ерөнхий зорилго, зарчим тодорхой томёологдож тусгагдсан хууль, үндсэн чиглэл батлагдсан ч төсвийн ачааллыг буруулахыг л чухалчлах явдал түгээмэл байна. Соёл урлагийн байгууллагуудыг санхүүгийн хувьд бэхжүүлэх хөшүүргүүдийг холбогдох бусад хуулинд өнөө хир тусгаж уялдуулаагүйгээс*

- соёл урлагийн олонхи байгууллагад, нэн ялангуяа хөдөө орон нутгийн байгууллага хүндрэл бэрхшээлтэй байнга учирсаар байна.*
6. *Соёл урлагийн байгууллагуудыг өөрчлөх, шинэчлэх, хувьчлах стратеги тодорхойгүй, яам агентлаг бүхэн өөр өөрийн байр сууринаас хандах, зөрчилдөх, соёл урлагийн байгууллагуудыг дэмжих хөшүүргүүдийг бий болгохоос илүүтэй төсвийн хэмнэлт л чухал зүйл гэсэн байр сууринаас хандах явдал газар авахад хүргэсэн эрх зүйн орчин үндсэндээ үйлчилж байна.*
 7. *Соёл урлагийн байгууллагуудын чадамжийг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн дээшлүүлэх системтэй бодлого түүнийг хэрэгжүүлэх зохицуулалтын механизм бий болоогүй байна.*

Монгол улсын соёл, урлагийн эрх зүйн орчин ямар байгаа талаар судлаачдын судалгааны үр дүнгээс харвал:

“Улаанбаатар хотын 4 дүүрэг, Увс, Баян - Өлгий аймгийн төв, тэдгээрийн 10-аад сумын 6000 гаруй хүн хамрагдсан судалгаа /2003.4-р сар/ -нд оролцогчид “Нийгмийн шинэ нөхцөлд соёл, урлаг хөгжих эрх зүйн орчин хэр зэрэг бүрдсэн бэ?” гэсэн асуултад 34,1% нь эрх зүйн үндсүүд байгаа ч түүнийг хэрэгжүүлэх механизм нь бүрдээгүй гэж, 31,2 хувь нь соёл, урлагийн мэргэжлийн байгууллага, уран бүтээлчид өөрсдөө ажиллаж чадвал, эрх зүйн орчин байгаа гэж, 25,9% нь соёлын тухай ерөнхий хуулиуд батлагдсанаас цаашгүй гэж, 8,8% нь эрх зүйн орчин үндсэндээ алга гэж тус тус хариулсан байна.

“Соёлын тухай хууль”- д Монгол улсын иргэн ямар үүрэгтэй байдгийг заасан байдаг. Та энэ заалтыг мэдэх үү? гэсэн асуултад 36,3% нь мэднэ, 63,7% нь мэдэхгүй гэж хариулжээ.

Монголын соёл урлагийн хөгжлийн өнөөгитн түвшинг уран бүтээлчид үнэлэхдээ 26,5% “дэгжиж хөгжиж байна”, 47,9% нь “боломж байгаа ч хөгжиж чадахгүй байна, ... 8,4% нь “хөгжих найдвар одоогоор алга”, ... 17,2% нь “асуултанд хариулахад төвөгтэй байна” гэжээ.

... урлагийн хөгжилд хамгийн гол нөлөө үзүүлэх хүчин зүйлийг ... хөрөнгө санхүүгийн чадамжтай 59,6% нь, тухайн байгууллагын менежменттэй 31,7% нь, төрийн бодлого хууль эрхийн орчинтой 29,8 % нь тус тус холбон үзсэн..

Соёлын бодлого, соёл, урлагийн байгууллагийн санхүүжилт, Улаанбаатар 2003, 46, 48 дахь тал.

Соёл, урлагийн бодлого ба хуулийн хэрэгжилт хөдөө орон нутагт.

Соёл, урлагийн байгууллагууд хөдөө орон нутагт яаж ажиллаж байгаа, энэ талаар орон нутгийн төр засгийн байгууллагууд хэрхэн ажилладаг, тэр нь ямар үр дүнтэй байдаг талаар, олон нийт болон иргэд ямар санаа бодолтой байдгийг тус судалгааны явцад тандсан юм. Сэлэнгэ, Төв, Дархан – Уул, Дорнод аймаг, нийслэлийн хамгийн алслагдсан дүүрэг болох Багануурыг тус тус сонгон авлаа. Ерөнхий жишиг болгох үүднээс Сэлэнгэ аймгийн ИХТ, Засаг даргын захирамж, тогтоол шийдвэр яаж гарч, түүний хэрэгжилт ямар байгаа тухай сурвалжлага, санал асуулгын дүнг нэгтгэв.

	Монгол Улс Сэлэнгэ Аймгийн Засаг Даргын Захирамж	
1997.03.31	Дугаар. 138	Сүхбаатар хот.
	Аймгийн Боловсрол соёлын төвийн бүтэц үйл ажиллагааны тухай.	
	... Захирамжлах нь:	
	...	
	4. Төрөөс боловсрол соёлын талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, ... соёл урлагийн байгууллагууд тэдгээрийн багш ажилтнуудад мэргэжлийн болон арга зүйн туслалцаа үзүүлэх, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалт явуулах, мэдээллээр хангах арга хэмжээ авахыг боловсрол соёлын төв /Р.Нямсүрэн/-д даалгасугай.	
	Засаг дарга Аймгийн Засаг даргын 138 тоот захирамжийн хавсралт.	
	Аймгийн боловсрол соёлын төвийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын схем.	
	Аймгийн боловсрол соёлын төв.	Сумын тамгын газар
	<ul style="list-style-type: none">• Сумын соёлын төв, клуб, номын сан• Сэлэнгийн долгио чуулга• Орон нутгийн судлах музей• Алтанбулагийн хувьсгалийн музей• Алтанбулаг кинотеатр	

	Монгол Улс Сэлэнгэ Аймгийн Засаг Даргын Захирамж	
2000.12.18	Дугаар. 75	Сүхбаатар хот.
	Аймгийн засаг даргын дэргэдэх агентлагуудын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай.	
	... Захирамжлах нь:	
	1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах, хэлтэс, агентлагуудын бүтцийг 1-р хавсралтаар баталсугай.	
	Засаг дарга	1-р хавсралт.
	... Долоо. Боловсрол соёлын төв.	
	<ul style="list-style-type: none">• Төвийн захирал• Арга зүйч• Ня-бо• Үйлчилгээний ажилтан	<ul style="list-style-type: none">1511
	Бүгд	9

	Монгол Улс Сэлэнгэ Аймгийн Засаг Даргын Захирамж	
2001.01.25	Дугаар. 29	Сүхбаатар хот.
	Аймгийн соёл мэдээллийн төв байгуулах тухай.	
... Захирамжлах нь:		
нэг. Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулгын байрыг түшиглэн урлаг, соёл, хэвлэл мэдээллийн төвийг “Сэлэнгийн долгио” чуулга, соёл, хүүхдийн урлан бүтээх цогцолбор, хэвлэл мэдээллийн алба гэсэн бүтэцтэйгээр 2001 оны 01-р сарын 24-ний өдрөөс эхлэн зохион байгуулж ажиллуулсугай.		
...		
дөрөв. Аймгийн соёл мэдээллийн төвийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлага-тай байгаа “Сэлэнгэ” телевизийг тус төвд шилжүүлж, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор УАЗ – 469 маркийн автомашин нэгийг аймгийн Засаг даргын тамгын газраас балансаас балансад шилжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга ..., ардын хувьсгалын 80, аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн өмнө аймгийн соёл мэдээллийн төвийн байрт их засвар хийж тохижуулахад шаардагдах хөрөнгийн төсөв, төлөвлөгөө хийлгэж, холбогдох мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэхийг ... үүрэг болгосугай.		
...		
1. Аймгийн соёл, мэдээллийн төвийн ажиллах журам, үүрэг зорилтыг тодорхойлж, дотоод журам боловсруулж, ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах,		
2. “Сэлэнгийн долгио” чуулгын уран сайханчдаас түвшин тогтоох шалгалт авч шаардлага хангасан жүжигчид, уран бүтээлчдийг ажиллуулах,		
3. Сумдын соёлын төвүүдийг сумдын Засаг даргатай зөвшилцөн мэргэжлийн удирдлагаар ханган, соёл урлаг, мэдээллийн ажлыг сайжруулах ажил зохион байгуулах		
4. Хүн амын соёл, урлагийн хэрэгцээг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүргийг өндөржүүлж, нэвтрүүлэг, нийтлэл, уран бүтээл, соёлын арга хэмжээнд ажлын шинэ арга барил, санаа нэвтрүүлэн ажиллахаас гадна хүүхэд залуучуудад зориулсан дугуйлан, курс тогтмол хичээллүүлж чанарыг сайжруулах,		
...		
Нийт орон тоо 48.		

Аймгийн засаг Даргын 2001 оны 364 дугаар
Захирамжийн хоёрдугаар хавсралт.

Сэлэнгэ аймгаас баримтлах соёлын бодлого.

Нэг. Өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

- ✓ Аймгийн соёл урлагийн байгууллагууд зах зээлийн харилцаанд нийцсэн хэтийн бодлого чиглэлгүй байгаа нь эдгээрийн хөгжилтийг удаашруулж, үйл ажиллагааны дэвшил нь хүн амын соёлын эрэлт хэрэгцээний түвшингээс хоцрох хандлагатай болж байна.
- ✓ Соёлын байгууллагуудын байрыг зориулалтын бусаар ашиглах, улмаар соёлын үндсэн үйл ажиллагааг алдагдуулан тухайн байгууллагыг татан буулгах шалтаг болж нэгэнт бий болсон материаллаг нөхцлийг үрэн таран хийхэд хүргэж байна.
- ✓ Соёлын байгууллагуудад хөрөнгө оруулалт хийгдэхгүй болсноос орчин үеийн шаардлагад нийцсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ихээр дутагдаж, мүүзейн үзмэр, номын сангийн фонд баяжилт ядмаг хэвээр байна.
- ✓ Аймгийн орон нутаг судлах болон Алтанбулаг дахь хувьсгалын мүүзейн барилга он удаан жилийн ашиглалтаас шалтгаалан үзмэр хадгалах, үйлчилгээ явуулах өнөөгийн шаардлага хангахгүй болов.
- ✓ Киноны талаарх нэгдсэн бодлого алдагдсанаас кино театрын үзвэр, үйлчилгээ урсгалаар явах болж гол төлөв дүрс бичлэгийн кино үзүүлэх хэлбэрт шилжив.
- ✓ Сум, баг, хороо, төр захиргааны байгууллагын зүгээс иргэдийн уран сайхны соёл, оюуны хөгжлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ул суурьтай авч үзэн далайцтай шийдвэр гарган хэрэгжүүлэх асуудал хангалтгүй байна.
- ✓ Соёлын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах системгүй болсноос соёлын салбарын ажил мэрэгжлийн хүмүүс илт цөөрөв. Тэдний цалин, ахуй хангамж амьжиргааных нь хэрэгцээнээс хоцорч тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэхгүй байна.
- ✓ Хөрөнгө мөнгөний хомсдолоос шалтгаалан аймгийн хамгаалалтад байдаг түүх соёлын дурсгалт хөшөө барималд сэргээн засварлах ажил хийгдэхгүй байгаагийн улмаас тэдгээрийн үнэ цэнэ буурч байна.

Хоёр. Соёлын бодлогын зорилго.

- ✓ Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого, ... бусад хуулийг үндэс болгон ... иргэний соёлыг төлөвшүүлэх үйлсийг аймгийн бүх шатны төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор хэрэгжүүлэх зорилгод аймгийн соёлын бодлого чиглэнэ.

Гурав. Соёлын бодлогын зарчим.

- ✓ ... Монгол улсын төрөөс соёлын талаар баримтлах үндсэн зарчимд нийцсэн байна.
- ✓ ...
- ✓ Соёлын байгууллагуудын үйл ажиллагааг цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.

Дөрөв. Хамрах хүрээ.

- ✓ Соёлын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд аймаг, сумын төр захиргааны бүх шатны байгууллага, нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн соёл урлагийн байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн ахуй амьдрал, ажил үйлчилгээний орчин хамаарна.

Тав. Соёлын байгууллагын удирдлага зохион байгуулалтын талаар.

- ✓ Соёлын бодлого нь аймгийн төр захиргааны бүх шатны байгууллагын ойрын болон хэтийн төлөвлөгөөнд тусгагдаж, санхүү зохион байгуулалтын хэрэгжих үндэслэлээр хангагдсан байна.
- ✓ Соёлын салбарт цаг үеийн шаардлагад нийцсэн захиргааны болон мэргэжлийн удирдлагын арга барилыг хослуулж аймаг, сумын соёлын хөгжлийн иргэдийн оюуны эрэлт хэрэгцээтэй нягт уялдуулан тодорхойлно.
- ✓ Аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг соёл урлагийн байгууллагуудыг өмчийн хэлбэрийг үл харгалзан аймаг, сумын Засаг даргын тамгын газар, багаас зохиож буй соёл олон түмний ажилд татан оролцуулж, үр дүнг жилийн эцэст тооцож байна.

<ul style="list-style-type: none"> ✓ Соёлын салбарт хувийн хэвшлийн байгууллага зээлийн шудрага өрсөлдөөний зарчмаар үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж, тэдгээрт нийгмийн оюун санааны амьдралд эерэг нөлөө үзүүлэх мэргэжлийн шаардлага тавина. ✓ ... төрийн болон ТББ-ын хамтын бүтээлч идэвхитэй ажиллагааг тогтмолжуулна. ... <p><u>Зургаа. Соёлын байгууллагуудын үйл ажиллагааг идэвхижүүлэх талаар.</u></p> <ul style="list-style-type: none"> ✓ ... ✓ Номын сангуудын үйлчилгээний чанарыг дээшлүүлж улмаар автоматжуулалтыг нэвтрүүлж, мэдлэг ухааны эх сурвалж болсон номтой нөхөрлөх хөдөлгөөнийг хүүхэд залуучууд ард түмний дунд өрнүүлж, ном хэвлэлийг нийтэд түгээх, худалдан авах асуудлыг хөдөлмөрчдийн эрх ашгийн үүднээс шийдвэрлэж байна. ✓ Аймгийн музейн барилгад урсгал засвар, өргөтгөл хийж ... ✓ Сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааны чиглэлийг оновчтой тогтоож, бүтэц зохион байгуулалт, орон тоо, төсөв хөрөнгийн хэвийн үйл ажиллагааны орчинг бүрдүүлнэ. <p><u>Долоо. Соёлын байгууллагын эдийн засаг, материаллаг бааз, боловсон хүчний талаар.</u></p> <ul style="list-style-type: none"> ✓ /Бүх чиглэлээр ерөнхий тунхаг шинжтэй заалтууд байна./ <p><u>Найм. Бусад зүйл.</u></p> <ul style="list-style-type: none"> ✓ Сумдууд соёлын талаар баримтлах хөтөлбөр чиглэл боловсруулахдаа энэхүү бодлогыг үндэс болгоно. ✓ Аймгаас баримтлах соёлын бодлогыг аймгийн төр захиргааны байгууллага болон аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн чиг үүрэг, эрхлэх асуудалд хамааруулан тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлнэ. ✓ Соёлын бодлогын хэрэгжилтэнд аймгийн ЗДТГ болон нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс хяналт тавьж ажиллана.

Судалгаанд оролцсон 50 гаруй хүмүүсийн санаа бодлыг нэгтгэвэл дорхи байдалтай байна.

Сэлэнгэ аймаг / сумын соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх санал асуулгын дүн /%-иар/

Соёл урлагийн байгууллага	Сайн ажилладаг	Тааруухан	Алдаг оног	Ажилладаггүй	Байхгүй
Театр/хөгжимт жүжгийн чуулга	33.3%	33.3%	11.1%	11.1%	22.2%
Кино театр	20%	10%	10%	50%	10%
Музей	40%	30%	10%	0	20%
Соёлын төв	40%	60%	0	0	0
Спортын төв	90%	10%	0	0	0
Номын сан	33.3%	55.5%	11.1%	0	0

Үнэлгээнийхээ үндэслэл, шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- *Кино театр хувьд очсоноос хойш огт ажиллаагүй*
- *Соёлын төв нь халаалт байдаггүйгээс зөвхөн зуны цагт ажилладаг*
- *Соёлын төв гэхээсээ баар цэнгээний газар шиг байдаг*
- *Олонхи айлд гэртээ кабель тавиулсан болохоор кино театрт очих шаардлага гардаггүй*
- *Номын сангийн ном нэлээд хуучирсан байдаг*
- *Соёл, урлагийн мэргэжилтэн, ажилчид цөөн байдаг*
- *Номын сонголт муу, сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи хөгжөөгүй. Иргэдийн ном сонин унших сонирхол буурсан*

Сэлэнгэ аймгийн сумдад 2004 оны 1-р сарын байдлаар /хавсралтаас үзнэ үү/ нийт 3632 суудал бүхий соёлын төвд 909 удаагийн арга хэмжээ зохиож давхардсан тоогоор 128 498 хүнийг хамруулж, нийт 5 сая 520 мянган төгрөгийн орлого олсоноос 3 сая төгрөгийг Сайхан сумын соёлын төв /бие даасан статустай/, 1 сая төгрөгийг Мандал сумын /бие даасан/ соёлийн төв, 500 мянган төгрөгийг Шаамар сумын /бие даасан/ соёлын төвүүд оруулсан гэсэн ЗДТГ-ийн нэгтгэсэн дүн гарчээ. Номын сангуудын үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг нэгтгэх боломжгүй байсан бөгөөд энэ нь сумдын тайлангийн нэгтгэлээс авсан тоо бөгөөд үүнийг баримт муутай тоо гэдгийг холбогдох хүмүүс нь анхааруулж байсныг тэмдэглэе.

Сурвалжлагын аргаар авсан санаа бодлын ерөнхий тоймыг харвал:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН СУДАЛГАА 2004.02.15

Байгуул-лагын нэр	Байгуу-лагдсан он	Байгуулагдсан тухай эрх зүйн акт, огноо, дугаар	Үйл ажиллагааг нь зохицуулж буй эрх зүйн акт	Орон тоо	Үйл ажиллагаанд гарч буй эерэг ба сөрөг өөрчлөлт
Соёл мэдээллийн төв	1982 оны 02-р сарын 20-ны өдөр	МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний тогтоол	Аймгийн засаг даргын 2001 оны 01-р сарын 25-ны өдрийн 29 тоот захирамж	48	5 албатай, соёл урлагаас гадна мэдээллээр үйлчлэх төв болсон. Байр ашиглалтыг сайжруулах үүднээс “Сэлэнгийн мэдээ” сонины редакц, Иргэний бүртгэл мэдээллийн алба, Хүүхдийн төлөө төв, Төрийн албан хаагчдын сургалтын төв, ХАА-н нэвтрүүлэх төвийг тэнд ажиллуулж байна. Мэргэжлийн боловсон хүчин дутмаг, явуулын тоглолт, кино үзвэрээр үйлчлэх, тэмдэглэлт ой, баяр ёслолоор концерт бэлтгэж тоглохоос өөрөөр үйл ажиллагаа бараг явуулаагүй.
Нийтийн номын сан	1948 оны 9-р сарын 20-ны өдөр /Алтанбулаг хотод/	Аймгийн АДХГЗ-ны 1961 оны 9-р сарын 20-ны өдрийн 139 тоот тушаал	Аймгийн Засаг даргын 1997 оны 138 тоот захирамж	6	Иргэд, хүүхдүүдэд ном хэвлэлээр үйлчлэхээс гадна ЕБС, албан байууллагуудтай хамтран номын өдөрлөг, хэлэлцүүлэг, шинэ номын баяр хийдэг. 1998 онд Соросын сангийн төсөлд хамрагдан Интернетийн үйлчилгээ үзүүлж байсан боловч холбооны зардал өндөр гардгаас энэ үйлчилгээ зогссон. Байр ашиглалтаа сайжруулж АНУ-ын Энх тайвны корпус, “Мэргэжлийн тусалцаа” ХХК-ийн хамтарсан англи хэлний сургалтад 1 өрөөг түрээслүүлдэг.
Орон нутгийг судлах музей	1967 оны 10 сарын 14	АДХГЗ-ны 1967 оны 10-р сарын 14-ний өдрийн 269 тоот тогтоол	АЗД-н 1997 оны 138 тоот захирамж	23 /түр/	ЕБС-ийн түүх, газар зүйн болон цэцэрлэгийн багш нартай хамтран олон арга хэмжээ зохион байгуулдаг

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СУМДЫН СОЁЛЫН ТӨВ, НОМЫН САНГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ СУРВАЛЖЛАГЫН ХУРААНГУЙ**

Байгууллагын нэр	Хэрэгжүүлдэг үйл ажиллагаа	Үйлчилгээний чанар, хүртээмж	Цаашид үйлчилгээг сайжруулах арга зам	Саналаа өгсөн иргэн /албан тушаалтан/	
				Нэр	Эрхэлсэн ажил, нас, хүйс
Баянгол сумын Соёлын Төв	Ардын уран сайханчдын тайлан тоглолт, корaoke, Та та тунгаа зэрэг тэмцээнийг зохион байгуулж хэвшсэн. Хүүхдүүдийн дунд дуу, хөгжим, бүжгийн дугуйлан хичээллүүлдэг. Орон нутгийн телевиз 14 хоногт 4 цагийн нэвтрүүлэг бэлтгэж цацдаг.	Үйл ажиллагаа хэвшсэн. Техник тоног төхөөрөмж сайн, иргэдийн талархлыг хүлээдэг	Албан газар, ААНэгжтэй хамтарсан үйл ажиллагааг аль болох нэмэгдүүлэх. РС тоглоом ажиллуулах /хувьчлах/	Д.Гэрэл-цэцэг /Баянгол /	Ажилгүй, 32, эм
Номын сан	Соёлын төвдөө байрлан үйл ажиллагаа явуулдаг	Үйл ажиллагаа нь хэвшсэн	Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв болгон өргөтгөх. Интернет кафе байгуулах	Т.Даваа-дорж	СЗДТГ-ын дарга, 55, эр
Хөтөл хотын Соёлын төв	Мэргэжлийн соёлын байгууллагын хэмжээнд олон үйл ажиллагаа явуулдаг	Үйл ажиллагаа нь хэвшсэн	Сумын музей, иргэдэд мэдээллээр үйлчлэх төв зэргийг нэмж байгуулах	Ц.Отгон-туяа	АЗДТГ-ын ажилтан 30 эм
Орхонтуул сумын Соёлын төв	Халаалт үгүйгээс үйл ажиллагааг сургуулийн спортын зааланд төвлөрсөн арга хэмжээ зохион байгуулдаг.	Хангалтгүй	Соёлын төвийг халаалттай болгох, тус суманд байгаа төмөр замын холбооны кабелийг ашиглан интернет үйлчилгээ явуулах	С.Эрдэнэ-баяр	СЗДТГ-ын дарга 25 эр
Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв	ИТХ, СЗДТГ хамтран ИТХ-ын нарийн бичгийн дарга хариуцан ажиллуулдаг. Иргэд хэвлэл унших, хууль зүйн зөвлөгөө авахаар ханддаг.	Хангалттай	Мөн компьютерт эх бэлтгүүлэх, хувилах үйлчилгээг бий болгох.	Ц.Оюун	СЗДТГ-ын дарга 43 эм

Эндээс харвал соёл, урлагийг хөгжүүлэх талаар авч буй төр засгийн бодлого, шийдвэр, хууль, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн захиргааны төв болон орон нутгийн төр засгийн байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилт нь нилээд зөрүүтэй байгаа нь ажиглагдаж байна.

Бусад аймгуудын төр, захиргааны байгууллагаас авсан арга хэмжээг бид түүвэрлэн авч үзэхэд бүхэлдээ ойролцоо байгаа бөгөөд аймаг тус бүрийн олон нийтийн санаа бодол дараах байдалтай байна.

Төв аймаг / сумын соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх санал асуулгын дүн /%-иар/

Соёл урлагийн байгууллага	Сайн ажилладаг	Тааруухан	Алдаг оног	Ажилладаггүй	Байхгүй
Театр/хөгжимт жүжгийн чуулга	0	37.5%	12.5%	0	50%
Кино театр	0	12.5%	12.5%	25%	50%
Музей	12.5%	25%	25%	0	37.5%
Соёлын төв	28.6%	42.8%	28.6%	0	0
Спортын төв	50%	25%	0	12.5%	12.5%
Номын сан	50%	37.5%	0	12.5%	0

Үнэлгээнийхээ үндэслэл, шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Төсөв, мөнгө нь хүрэлцдэггүй
- Театрын барилга байгууламж байдаг ч янз бүрийн хүмүүст хөлслүүлдэг
- Музейн доторх зүйлс бараг өөрчлөгдөөгүй олон жил болсон
- Орчин үед шинэ гарч байгаа ном дутагдалтай
- Урлаг, соёлын газруудын ажилладаггүй шалтгаан нь: үзэгчид цөөхөн, залуучууд хот яваад буцаж ирэх нь ховор
- Зохион байгуулагч хүмүүс нь ашиг олох гэхээс бус ард түмнээ гэх сэтгэл байдаггүй
- Номын санд ном нь хуучирч элэгдсэн, урагдсан, шинэ ном, зохиол ирдэггүй
- Мэргэжлийн хүмүүс ховор
- Хөгжим тоног төхөөрөмж муутай
- Спорт зал нь хувьчлагдаад өөр зориулалтаар ашиглагддаг

Дархан-Уул аймаг / сумын соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх санал асуулгын дүн /%-иар/

Соёл урлагийн байгууллага	Сайн ажилладаг	Тааруухан	Алдаг оног	Ажилладаггүй	Байхгүй
Театр/хөгжимт жүжгийн чуулга	21.2%	51.5%	21.2%	3%	3%
Кино театр	15.6%	40.6%	34.4%	0	9.4%
Музей	25.8%	35.5%	12.9%	19.4%	6.4%
Соёлын төв	18.5%	29.6%	14.8%	11.1%	25.9%
Спортын төв	81.8%	12.1%	3%	0	3%
Номын сан	58.8%	32.3%	2.9%	2.9%	2.9%

Үнэлгээнийхээ үндэслэл, шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Кино театр хувьд очсоноос хойш огт ажиллаагүй
- Соёлын төв нь халаалт байдаггүйгээс зөвхөн зуны цагт ажилладаг
- Соёлын төв гэхээсээ баар цэнгээний газар шиг байдаг

- Олонхи айлд гэртээ кабель тавиулсан болохоор кино театрт очих шаардлага гардаггүй
- Номын сангийн ном нэлээд хуучирсан байдаг
- Соёл, урлагийн мэргэжилтэн, ажилчид цөөн байдаг
- Номын сонголт муу, сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи хөгжөөгүй. Иргэдийн ном сонин унших сонирхол буурсан

Дорнод аймаг / сумын соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх санал асуулгын дүн /%-иар/

Соёл урлагийн байгууллага	Сайн ажилладаг	Тааруухан	Алдаг оног	Ажилладаггүй	Байхгүй
Театр/хөгжимт жүжгийн чуулга	0	66%	33%	0	0
Кино театр	66%	33%	0	0	0
Музей	0	33%	66%	0	0
Соёлын төв	16.6%	50%	33.3%	0	0
Спортын төв	83.3%	16.6%	0	0	0
Номын сан	100%	0	0	0	0

Үнэлгээнийхээ үндэслэл, шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Театр төсөв, мөнгөгүйн улмаас ямар нэгэн зүйл хийдэггүй. Бас иргэд театрт явах сонирхолгүй, учир нь театр хотын төвөөс хол байдаг.
- Номын сан нь янз бүрийн үйл ажиллагаа зохион байгуулдаг, олныг хамруулж чаддаг. Сайн тал нь “Internet center” ажиллуулдаг
- Театр нь төвөөс зайдуу, боловсон хүчин дутмаг, төсөв мөнгө бага
- Соёлын төвд олон үйлчилгээний байгууллага түрээсэлж байдаг
- Спортын төвд тэмцээн уралдаан их зохиогддог, харин цалин бага учир багш дутагдалтай, секц дугуйлан бага байдаг
- Бөхийн өргөөтэй болсон болохоор урлаг соёлын арга хэмжээ бүгд бөхийн өргөөнд явагддаг болсон

Багануур дүүрэг дэх соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх санал асуулгын дүн /%-иар/

Соёл урлагийн байгууллага	Сайн ажилладаг	Тааруухан	Алдаг оног	Ажилладаггүй	Байхгүй
Театр/хөгжимт жүжгийн чуулга	12.5%	0	12.5%	25%	50%
Кино театр	25%	62.5%	0	0	12.5%
Музей	0	25%	25%	12.5%	37.5%
Соёлын төв	37.5%	62.5%	0	0	0
Спортын төв	87.5%	12.5%	0	0	0
Номын сан	37.5%	50%	12.5%	0	0

Үнэлгээнийхээ үндэслэл, шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Хүн ам цөөтэй учраас үзвэр үйлчилгээ явуулахад үзэх хүн ховор. Тиймээс ашиг орлого нь муу байдагтай уялдан соёлын талын үйлчилгээ ховор байдаг болов уу
- Сургуулийн номын сангаас өөр нийтийн номын сан байхгүй, тэд зөвхөн өөрийн сургуулийн сурагчдад үйлчилдэг

- Хөрөнгө, мөнгө, захиргааны ажилчдын идэвхи санаачлага дутагдалтайгаас кино театр, музей гэх мэт соёлын байгууллага байхгүй

Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдийн соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх оршин суугчдын санаа бодлыг харьцуулан авч үзвэл дараах байдал ажиглагдаж байна.

Соёл урлагийн байгууллага	Судалгаанд хамрагдсан аймгууд	Театр/хөгжимт жүжгийн чуулга	Кино театр	Музей	Соёлын төв	Спортын төв	Номын сан
Сайн ажилладаг	Дорнод	0	66	0	16.6	83.3	100
	Төв	0	0	12.5	28.6	50	50
	Багануур	12.5	25	0	37.5	87.5	37.5
	Сэлэнгэ	33.3	20	40	40	90	33.3
	Дархан-уул	21.2	15.6	25.8	18.5	81.8	58.8
	Дундаж	13.3	25.3	15.6	28.2	78.5	55.9
Тааруухан	Дорнод	66	33	33	50	16.6	0
	Төв	37.5	12.5	25	42.8	25	37.5
	Багануур	0	62.5	25	62.5	12.5	50
	Сэлэнгэ	33.3	10	30	60	10	55.5
	Дархан-уул	51.5	40.6	35.5	29.6	12.1	32.3
	Дундаж	37.6	31.7	29.7	48.9	15.2	35
Алдаг оног	Дорнод	33	0	66	33	0	0
	Төв	12.5	12.5	25	28.6	0	0
	Багануур	12.5	0	50	0	0	12.5
	Сэлэнгэ	11.1	10	10	0	0	11.1
	Дархан-уул	21.2	34.4	12.9	14.8	3	2.9
	Дундаж	18	11.4	14.6	15.3	0.6	5.3
Ажилладаггүй	Дорнод	0	0	0	0	0	0
	Төв	0	25	0	0	12.5	12.5
	Багануур	25	0	12.5	0	0	0
	Сэлэнгэ	11.1	50	0	0	0	0
	Дархан-уул	3	0	19.4	11.1	0	2.9
	Дундаж	7.8	15	6.4	2.2	2.5	3
Байхгүй	Дорнод	0	0	0	0	0	0
	Төв	50	50	37.5	0	12.5	0
	Багануур	50	12.5	37.5	0	0	0
	Сэлэнгэ	22.2	10	20	0	0	0
	Дархан-уул	3	9.4	6.4	25.9	3	2.9
	Дундаж	15	16.4	20.3	5.2	3.1	0.6

Судалгаанд ихэвчлэн дэд бүтэц сайн хөгжсөн, эдийн засгийн чадамж сайтай аймгууд хамрагдсан бөгөөд соёл, урлагийн байгууллагуудыг үйл ажиллагааных нь хувьд хамгийн сайн ажилладаг байгууллагаас эхлэн жагсаавал:

1. Спортын төв
2. Номын сан
3. Соёлын төв
4. Мүзей
5. Театр/ чуулга
6. Кинотеатр

гэж гарч байна. Өөрөөр хэлбэл соёл, урлагийн байгууллагаас илүүтэй спортын байгууллага сайн ажиллаж байна гэсэн дүгнэлтийг өгсөн байна. Энэ нь олон нийтийн дунд уралдаан, тэмцээн байнга зохиогддог, секц дугуйлан хичээллэдэгээр ихэвчлэн тайлбарласан байна. Гэтэл театр/ чуулгын ажил тааруу байгаа нь мэргэжлийн уран бүтээлчдийн үйл ажиллагаанаас шууд хамаарч улмаар төсөв санхүүгийн байдал гол бэрхшээл нь болж байна. Номын сан, соёлын төвийн ажиллагаа сайн байгаа нь иргэдийн оюуны хэрэгцээ шаардлагаас урган гарсан, нөгөө талаас мэргэжлийн уран бүтээлчдээс хамаарал багатай, материаллаг баазаас голчлон хамаарч тэрчлэн энэ чиглэлээр төрөл бүрийн төсөл хэрэгжсэнтэй холбоотой байна. Олонхи кинотеатрын хувьд гэвэл аймаг кинотеатрынхаа барилгыг хувьчилсан, нөгөө талаас кино урлагийн салбарын нөхцөл байдал, түүнийг орлон гарч ирсэн видео болон кабелийн кинотой холбон авч үзэж болох юм.

Бүхэлдээ хөдөө орон нутаг дахь соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаа нь ач холбогдлоороо дараах хүчин зүйлүүдээс хамааралтай болох нь ажиглагдлаа. Үүнд:

- a. Санхүүгийн эх үүсвэр, материаллаг бааз хангалтгүй
- b. Мэргэжлийн боловсон хүчин дутмаг
- c. Менежментийн ур чадвар дутмаг
- d. Орон нутгийн төр засгийн удирдлагын идэвхи санаачлага бага

Бүхнийг хөрөнгө, хүн хүчтэй холбон тайлбарлах хандлага олонхи газар давамгайлж байгаа бөгөөд орон нутгийн түвшинд нөөцөө дайчлах арга хэлбэрийг олох чадамж соёл, урлагийн байгууллагын удирдах ажилтнууд, орон нутгийн засаг захиргааны ажилтнуудад ч үгүйлэгдэж байгаа нь харагдлаа. Ерөнхий үзүүлэлтээрээ Сэлэнгэ, Дорнод аймаг тэргүүлж байгаа бөгөөд аймгийн төр, засгийн байгууллагын идэвхи санаачлага энд голлох үүрэг гүйцэтгэж байгаа нь ажиглагдсан.

Судалгаанд хамрагдсан аймгуудын соёл, урлагийн байгууллага нь үндсэндээ Засаг даргын тамгын газрын шууд харьяалалд, төсөвт байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Энд өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын зохистой арга хэлбэрийг үр өгөөжтэйгээр туршиж нэвтрүүлсэн тохиолдол алга байв.

Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх санал асуулгын нэгтгэл

Соёл урлагийн байгууллага	Сайн ажилладаг	Тааруухан	Алдаг оног	Ажилладаггүй	Байхгүй
Театр/хөгжимт жүжгийн чуулга	13.3	37.6%	18%	7.8%	15%
Кино театр	25.3%	31.7%	11.4%	15%	16.4%
Музей	15.6%	29.7%	14.6%	6.4%	20.3%
Соёлын төв	28.2%	48.9%	15.3%	2.2%	5.2%
Спортын төв	78.5%	15.2%	0.6%	2.5%	3.1%
Номын сан	55.9%	35%	5.3%	3%	0.6%

Санал асуулгад оролцогчид өөрийн өгсөн үнэлгээнийхээ үндэслэл, шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Театр төсөв, мөнгөгүйн улмаас юм хийдэггүй. Бас иргэд театрт явах сонирхолгүй, учир нь театр хотын төвөөс хол байдаг.
- Номын сан нь янз бүрийн үйл ажиллагаа зохион байгуулдаг, олныг хамруулж чаддаг. Сайн тал нь “Internet center” ажиллуулдаг
- Театр нь төвөөс зайдуу, боловсон хүчин дутмаг, төсөв мөнгө бага
- Соёлын төвд олон үйлчилгээний байгууллага түрээсэлж байдаг
- Спортын төвд тэмцээн уралдаан их зохиогддог, харин цалин бага учир багш дутагдалтай, секц дугуйлан бага байдаг
- Бөхийн өргөөтэй болсон болохоор урлаг соёлын арга хэмжээ бүгд бөхийн өргөөнд явагддаг болсон
- Театрын барилга байгууламж нь байдаг ч янз бүрийн хүмүүст хөлслүүлдэг
- Музейн үзмэр бараг өөрчлөгдөж шинэчлэгдээгүй олон жил болсон
- Орчин үеийн шинэ гарч байгаа ном дутагдалтай
- Урлаг, соёлын газруудын ажилладаггүй шалтгаан нь: үзэгчид цөөхөн, залуучууд хот яваад буцаж ирэх нь ховор
- Зохион байгуулагч хүмүүс нь ашиг олох гэхээс бус ард түмнээ гэх сэтгэл байдаггүй
- Хөгжим, тоног төхөөрөмж муутай
- Спорт зал нь хувьчлагдаад өөр зориулалтаар ашиглагддаг
- Хүн ам цөөтэй учраас үзвэр үйлчилгээ явуулахад үзэх хүн ховор. Тиймээс ашиг орлого нь муу байдагтай уялдан соёлын талын үйлчилгээ ховор байдаг
- Сургуулийн номын сангаас өөр нийтийн номын сан байхгүй, тэд зөвхөн өөрийн сургуулийн сурагчдад үйлчилдэг
- Захиргааны ажилчдын идэвхи санаачлага дутагдалтайгаас кино театр, музей гэх мэт соёлын байгууллагууд дутуу
- Соёл, урлагийн мэргэжилтэн, ажилчид цөөн байдаг
- Номын сонголт муу, сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи хөгжөөгүй. Иргэдийн ном сонин унших сонирхол буурсан
- Кино театр хувьд очсоноос хойш огт ажиллаагүй
- Соёлын төв нь халаалт байдаггүйгээс зөвхөн зуны цагт ажилладаг
- Соёлын төв гэхээсээ баар цэнгээний газар шиг байдаг
- Олонхи айлд гэртээ кабель тавиулсан болохоор кино театрт очих шаардлага гардаггүй

ҮНЭЛГЭЭ БА ХУРИМТЛАГДСАН АСУУДЛУУД

Соёл гэдэг нь зөвхөн төрөл бүрийн урлагийг төдийгүй, аж төрөх ёс, хүмүүний оршин амьдрахуйн үндсэн ёс журам, үнэт зүйлс, уламжлал, итгэл бишрэлийн тогтолцоог өөртөө багтаадаг ажээ.

Монголын нийгмийн тогтолцоо дэвшилт чиглэлээр огцом өөрчлөгдөж эхэлсэн 1990-ээд оноос өнөөг хүртэл соёл нь нэгэнт тогтсон хэв маяг, арга барил, тогтолцоондоо хэт баригдан шинэчлэл, өөрчлөлтийг огоорч, өнгөрсөн хугацаанд нийгмийн хөгжил дэвшлийн хүчин зүйл байх үүргээ гүйцэд биелүүлж чадаагүй байжээ.

Тийм ч учраас улс орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг эрхэмд үзэж, Монголын соёл нь тус улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын нэгэн баталгаа, монголчуудын үндэсний бахархал, эв нэгдлийн уг сурвалж, хөгжил дэвшлийн чухал хөшүүрэг мөн болохыг онцлон анхаарч, хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээг өргөтгөх, урлагийн бүх төрлийг хөгжүүлэх, үндэсний соёлоо үр удамдаа өвлүүлэх, соёлыг өргөн утгаар ойлгож, түүнийг нийгэм, эдийн засгийн бусад салбартай нягт холбох зорилгоор **төр тогтвортой баримтлах соёлын бодлогоо** 1996 онд тодорхойлсон юм.

Төр тогтвортой баримтлах соёлын бодлогоо Соёлын тухай Монгол улсын хууль болон бусад хууль тогоомж, хөтөлбөрүүдээр дамжуулан хэрэгжүүлэхийг эрмэлзэж ирсний үр дүнд дэлхий нийтийн жишиг, олон улсын хөгжлийн хандлага, даяаршил хийгээд үндэсний өвөрмөц онцлогийн аль алийг агуулсан хууль эрх зүйн дэвшилтэт тогтолцоог сүүлийн 10 шахам жилд бий болгосон байна. Гэвч хэрэгжих механизм тодорхой бус, бусад хууль тогтоомжуудад хэрэгжилт, хяналтын зохих заалтуудыг суулган өгөөгүй, ерөнхийдөө тунхаглалын шинжтэй болжээ. Хэдийгээр соёлын талаар гүйцэтгэх засаглал, иргэд, байгууллагын хүлээх эрх үүргийг тогтоосон боловч мөн л тунхаг шинжтэй, хяналтын систем хэрхэн ажиллах, хяналтын үр дүнг юунд хэзээ хэрхэн ашиглах нь тодорхойгүй байгаа нь түүний амьдрах чадварыг бууруулжээ.

Соёл урлагийн байгууллагуудыг санхүүгийн хувьд бэхжүүлэх хөшүүргүүдийг холбогдох бусад хуулинд өнөө хир тусгаж уялдуулаагүйгээс соёл урлагийн олонхи байгууллага, нэн ялангуяа хөдөө орон нутагт хүндрэл бэрхшээлтэй байнга учирсаар байна. Соёл урлагийн байгууллагуудыг өөрчлөх, шинэчлэх, хувьчлах стратеги тодорхойгүй, яам агентлаг бүхэн өөр өөрийн байр сууринаас хандах, зөрчилдөх, соёл урлагийн байгууллагуудыг дэмжих хөшүүргүүдийг бий болгохоос илүүтэй төсвийн хэмнэлт л чухал гэсэн байр сууринаас хандах явдал хүчтэй байна.

Соёл урлагийн байгууллагуудын чадамжийг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн дээшлүүлэх системтэй бодлого, түүнийг хэрэгжүүлэх зохицуулалтын механизм бий болоогүй байна.

Үүнийг авч үзэхдээ соёл, соёлын үйл ажиллагаа, түүний өөрчлөлт, шинэчлэлт, хувьчлалын холбогдолтой эрх зүйн актуудыг олон нийтийн хэлэлцүүлэг, талуудын зөвшилцөлгүйгээр баталж байгаа болон соёл, урлагийн салбарын хөгжлийн стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоогүй, тиймээс ямар арга хэлбэрийг хэзээ, хаана, яаж хэрэглэх нь ил тод бус, “төрөөс тогтвортой баримтлах бодлого” зөрчигдөхөд хүргэж болзошгүй нөхцөл байдал бүрдсэнтэй холбон авч үзэж байна.

Соёл нь Монголын нийгмийн хөгжил дэвшлийн хүчин зүйл байх үүргээ гүйцэд биелүүлж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд тус улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ? Даяаршиж буй дэлхий ертөнцөд дэндүү цөөхөн Монголчууд орших уу, эс орших уу гэдэг асуудлын хариуг бид өгөх ёстой бус уу.

Судалгааны баг эдгээр амин чухал асуудлын хариуг өгөх хэргийг өдөөх зорилгоор дараах саналуудыг тавьж байна.

1. Тунхаглалын шинжтэй хууль тогтоомж, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга зам буюу юуг, хэн, хэзээ, хэрхэн яаж хийхийг тодорхойлох, түүнийг яаж хянах, хэрэгжилтийн үр дүн нь гүйцэтгэх засаглалын бүх түвшний ажлын нэг гол үзүүлэлт байж нийтэд тайлагнадаг байхаар хуульчлах.
2. Соёл, урлагийн байгууллагуудад үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хөшүүргүүдийг татварын хуулиудад суулгах. Тухайлбал, аж ахуйн нэгж бүр нийт зардлын тодорхой хувийг соёлыг хөгжүүлэхэд ямар нэгэн хэлбэрээр зарцуулдаг байх ба түүнийг нийт зардалд оруулж тооцох. Соёлыг хөгжүүлэх санд нийт зардлын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний хандив өгөхийг зөвшөөрөх.
3. Орон нутгийн засаг захиргаа бүрэн эрхийнхээ эхний ба сүүлийн жилд нийт оршин суугч, ард иргэддээ соёл, урлагийг хүргэх зорилт ба түүний дүнг тайлагнадаг байхаар хуульчлах.
4. Соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд гол цөм нь байхаар зохион байгуулж, орон нутгийн санхүү, хүн хүчний нөөц бололцоо

чадамжийг дайчлах, түүнд орон нутгийн засаг захиргаа, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийт байгууллага, ард иргэдийн өргөн оролцоог хангахуйц тогтолцоог эрх зүйн хувьд бүрдүүлэх.

5. Үндэсний хэмжээнд төрөөс тогтвортой баримтлах соёлын бодлогыг хэрэгжүүлэх үндэсний хороог /салбар хоорондын/ байгуулж, соёл, урлагийн хөгжлийн асуудлаар өргөн олныг хамарсан хэлэлцүүлэг хийх үндсэн дээр хууль эрх зүйн орчинд иж бүрэн өөрчлөлт хийх.
6. Соёл урлагийн салбарыг төрийн санхүүгийн шууд ба шууд бус дэмжлэг, менежментийн хувьчлалтай хослуулан хөгжүүлэх стратегид суурилсан өөрчлөлт, шинэчлэлийн бодлогод шилжих.

**Нийгмийн салбарын хувьчлалын туршилт :
” Хүүхэд залуучуудын театрын менежементийн хувьчлалын сургамж,
үр дүн кейс” судалгааны талаарх танилцуулга**

Хүүхэд залуучуудын театрын товч танилцуулга

Монгол улсын хүүхэд залуучуудын театр нь анх БНМАУ – ын МАХН – ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1950 оны 12 дугаар сарын 01 – ны өдрийн 72/117 тогтоолоор Улсын хөгжимт драмын театрын дэргэд байгуулагджээ. 1993.07.04 өдрөөс эхлэн Хүүхдийн кино студитэй нийлж хүүхэд залуучуудад зориулсан уран бүтээлийг өргөтгөх зорилгоор Хүүхэд Залуучуудын Театр Киноны Хүрээлэн болон зохион байгуулагдсан.

Байгуулагдсан цагаасаа эхлэн сургуулийн өмнөх насны хүүхэд бага анги, дунд ба ахлах ангийн сурагчид, тусгай мэргэжлийн болон их, дээд сургуулийн оюутан залуучуудын гэсэн чиглэлээр үлгэрийн, хүүхэд залуучуудын сэдэвтэй жүжгүүдийг голлон тавьж ирсэн. 1951 оны 5-р сарын 14- нд анхны жүжгээ тавьж эхэлсэн тус театрын уран бүтээлийн сан нь жилээс жилд баяжан, сонгодог болон өөрийн зохиолчдын 140- өөд жүжгийг тайзнаа тавьж өөрийн орны бүх аймаг сумдад болон хилийн чанадад, тухайлбал Орос, Герман, Болгар зэрэг оронд нийт 5528 удаа тоглосон байна. Тус театр нь 1980 онд байгуулагдсаныхаа 30 жилийн ойгоор "Алтан гадас" одонгоор шагнагдаж, 1981 онд МХЗЭ-ийн 60 жилийн ойгоор МХЗЭ-ийн нэрэмжит театр болсон.

Тус театрт нийт 93 ажилтан, уран бүтээлч гэрээгээр ажилладаг. Хувьчлагдахаас өмнөх 1998 оны эхний хагас жилийн балансаар театр 29,2 сая төгрөгийн дүрмийн сантай, 14,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 526 суудалтай, суудал ашиглалт 42% гэсэн үзүүлэлтүүдтэй байсан.

Хүүхэд Залуучуудын Театр нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байрладаг. Нийт 8586,63 кв.м эзэмшил газартай, үүнээс барилга дор 1859,65 кв.м, ашигтай талбай 5106,7 кв. м, барилгын нийт талбай нь 62016 кв.м байна. 41 өрөө тасалгаатай байсан байна.

Тодруулга -1

Театр „theater,, гэдэг үг нь эртний Грекийн “theatron”үзвэр,үзвэрийн газар гэсэн утгатай үгнээс гаралтай. Театрыг тодорхойлбол „Үзэгчдийн өмнө амьдаар тоглож үзүүлэх,, буюу жүжигчид, найруулагчийн тусламжтайгаар, бодит шинж чанарыг агуулсан тусгай тайзнаа зохиолчийн бичсэн зохиол, зохиомж, утга санааг амьдаар үзэгчидэд дамжуулах урлаг ,,гүүр,, юм. Энэ ангилалд циркээс эхлээд жүжиг хүртэлх бүх төрөл орно.

Театрын нэг төрөл болох Хүүхэд залуучуудын театрын үйл ажиллагааны үндсэн чиглэлд хүүхэд залуучуудыг урлагийн сэтгэлгээтэй болгон төлөвшүүлэх зорилготойгоор тэдэнд зориулсан уран бүтээлийг туурвих нь чухал байдаг байна. Энэ зорилгийг хангах үүднээс ЕБСургууль, их дээд сургууль, коллеж бүрийн харьяанд театрын дугуйланг ажиллуулан оюутан, сурагчид өөрсдөө жүжиг найруулан тоглодог байна. Энэхүү мини-театрт тавигдах жүжгийн чиглэлийг төрийн бодлогоор сургалтын хөтөлбөрт тусган зохицуулагдан хэрэгждэг бөгөөд ихэнхдээ сонгодог урлаг болон улс үндэстэний үнэт зүйл, уламжлалт ахуйн соёлыг хадгалсан сэдэвтэй жүжгүүд байдаг байна.

Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1994 оны 9 дүгээр сарын 10–ны өдрийн 20 тоот тогтоолоор нийгмийн салбарын хувьчлалын гол зорилгыг анх тодорхойлжээ.

Тодруулга-2

Зах зээлийн нөхцөлд зохицсон соёлын тогтолцоо бүрдүүлж, эдийн засгийн үндэс суурийг тавихад үндэсний оюуны үнэт зүйлсийг хадгалан хөгжүүлэх, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг баримжаа болгосон үзэл санааг ард иргэдийн оюуны цөм болгон төлөвшүүлэхэд урлаг, уран сайхны арга хэрэгслүүдийг дээд зэргийн үр өгөөжтэй ашиглах, хувь хүн өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломж олгох зарчимд үндэслэнэ... гэж заасан байна.

1994.09.10 өдрийн 20 тоот тогтоолын хавсралтад

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийт үндэсний болон ард түмний түгээмэл эрх ашигт үйлчлэх үүрэг бүхий соёл урлагийн байгууллагыг төрийн өмчид үлдээн ажиллуулах жагсаалтанд Хүүхэд залуучуудын театар оржээ.

Соёл урлагийн байгууллагыг хувьчлахдаа дараах зарчмийг асуудлыг тусгасан гэрээг байгуулахыг Соёлын яам, орон нутгийн Засаг даргын тамгийн газар, ТӨХ анхааран ажиллах хэрэгтэйг заасан. Үүнд:

- 1. Тухайн байгууллагын үйл ажиллагааны агуулга, чиглэлийг өөрчлөхгүй байна. Үйл ажиллагааны үндсэн чиглэл давамгайлж, дагалдах бусад үйлчилгээ явуулахыг зөвшөөрнө.**
- 2. Хувьчлагдсан соёл, урлагийн багууллагуудад нийт ард түмний болон үндэсний эрх ашгийн үүднээс төрөөс зохих санхүүгийн болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу авч үзэж шийдвэрлэж байна гэж заажээ.**

Тодруулга-3

Монгол улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого

Монгол улсын төр: Улс орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхэд соёлын гүйцэтгэх үүргийг эрхэмд үзэж, монголын соёл нь тус улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын нэгэн баталгаа, монголчуудын үндэсний бахархал, эв нэгдлийн уг сурвалж, хөгжил дэвшлийн чухал хөшүүрэг мөн болохыг онцлон анхаарч хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээг өргөтгөх, урлагын бүх төрлийг хөгжүүлэх, үндэсний соёлоо үр удамдаа өвлүүлэх, соёлыг өргөн утгаар ойлгож, түүнийг нийгэм, эдийн засгийн бусад салбартай нягт холбох зорилгоор төрөөс тогтвортой баримтлах соёлын бодлогыг тодорхойсон байна.

Төрөөс соёлын бодлогыг хэрэгжүүлэх арга замын

5 дугаарт Урлагийн бүх төрөл, зүйлийг анхааран хөгжүүлж, үндэсний уламжлалт, сонгодог болон хүүхдэд зориулсан урлаг, баримтат киног төрийн ивээлд байлгах. 9 дүгээрт хүүхдэд зориулсан ном, хэвлэл, уран бүтээлийг олшруулж, чанарыг сайжруулах гэж заажээ

1996.04.11 нд батлагдсан соёлын тухай хуулийн зорилт нь Монгол улсад соёлын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэс, соёлын үйл ажиллагаанд оролцогчдын эрх үүрэг, соёлын удирдлагын тогтолцоо, соёлын ажилтны нийгмийн халамж баталгаа, соёлын байгууллагын өмч, санхүүжилтын зарчим, арга хэлбэрийг тогтоож, уг үйл ажиллагаанд оролцогчдын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино... гэж заасан байна.

- **Төрийн өмчийн хорооноос Засгийн газрын хуралдаанд оруулсан саналын утга нь : Соёлын салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шудрага өрсөлдөөн болон өмчийн зохистой харьцаа, төрийн бус соёл, урлагийн байгууллагуудыг бий болгох чиглэлээр МУ –ын Их Хурлын Нийгмийн**

бодлогын байнгын хороо, Гэгээрлийн Яам, Хүүхэд залуучуудын Театраас ирүүлсэн албан тоотуудыг үндэслэн туршилтын журмаар ХЗТ –ыг Менежментийн гэрээгээр хувьчлах саналыг дэмжин “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” –ийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, 58 дугаар зүйлд заасны дагуу “Хүүхэд залуучуудын театр” –ыг менежментийн гэрээгээр хувьчлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанд оруулсан байна.

И. Нямгаваа нь МУ – ын Засгийн газрын 1997.02.02 өдрийн Төрийн өмчийн 1997- 2000 онд хувьчлах хөтөлбөрийн дагуу өөрийн ажиллаж байгаа ХЗТ – ыг хувьчлуулах талаар Улсын Их хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Х. Хулан, БСШУЯ – ны сайд Лхагважавт, ТӨХ- ны дарга Энхболд нарт албан бичгээр хүсэлт гаргасны дагуу УИХ – ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Х.Хулан 1997.06.26 ны 5/3215 тоот албан бичгийг БСШУЯ – ны сайд Лхагважавт явуулжээ. Уг захидлын хамт “ Монголын үндэсний урлагийн академийн тэргүүлэгч гишүүд Хүүхэд залуучуудын театрыг хувьчлах талаар дэмжсэн гарын үсгийн жагсаалтын хамт хүргүүлсэн байна.

БСШУЯ – ны сайд Л.Сайханбилэг Хүүхэд залуучуудын театрыг менежментийн хувьчлалын туршилтын төслийг дэмжсэн 1А/1655 тоот албан бичгийг ТӨХ – нд явуулсан байна.

- 1998 онд ТӨХ-ны Тендер, менежментийн хувьчлалын газрын дарга Д.Төрбат нь: Манай улс орны ирээдүй болсон хүүхэд залуучуудын өв тэгш, гоо зүйн хүмүүжил, оюун санааны эрэлт хэрэгцээг хангах зорилго бүхий улсын хэмжээний ганц театр болох Хүүхэд залуучуудын театрын мэргэжлийн үйлчилгээний чиглэл, чанарын төвшинг одоогийнхоос өөрчилж бууруулахгүй байх болзолтойгоор менежментийн гэрээ байгуулан ашгийн төлөө бус байгууллагын хэлбэрээр хувьчилбал улсын төсвийн ачааллыг хөнгөлж, уран бүтээлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх юм.
- Иймд "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 9-р зүйлийн 5 дахь заалт, 58 дугаар зүйлд заасны дагуу, Монгол Улсын Засгийн Газрын 1998 оны 8-р сарын 5-ны өдрийн 140 дугаар Тогтоолыг үндэслэн Хүүхэд залуучуудын театрыг тендер зарлан төсөл сонгон шалгаруулж, менежментийн гэрээгээр хувьчлах саналыг оруулсан байна.

Тодруулга-4

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

1999-01-28

№57

Улаанбаатар хот
Төсөл сонгон шалгаруулсан
шинжээчдийн дүгнэлтийг
батлах тухай

Монгол Улсын „Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,-ийн 54-р зүйлийн 5-р заалт, Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 140-р тогтоолыг үндэслэн төсөл сонгон шалгаруулсан шинжээчдийн дүгнэлтийг хэлэлцээд Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. Хүүхэд залуучуудын театрын менежментийн багийн төслийг шалгаруулсан төсөл сонгон шалгаруулах шинжээчдийн дүгнэлтийг баталсугай.
2. Хүүхэд залуучуудын театрын менежментийн багтай 3 жилийн хугацаатай түрээсийн гэрээг байгуулж, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллахыг Тендер менежментийн хувьчлалын газар /Д.Төрбатад/-д даалгасугай.
3. Хүүхэд залуучуудын театрын менежментийн багийн шинээр байгуулах Төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлд Төрийн өмчийн хороог

Тодруулга-5

Хүүхэд залуучуудын менежментийн гэрээ

Энэхүү гэрээг доорх хоёр этгээдийн хооронд байгуулсан болно.

1. Гэгээрлийн яам /цаашид Яам гэнэ/

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Засгийн газрын 3-р байр

2. „ХЗТ”, Төрийн бус байгууллага

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж

Агуулга

1. Төрийн өмчийн хороо, Гэгээрлийн яамнаас Хүүхэд Залуучуудын театрыг /цаашид ХЗТ гэнэ/ үр ашигтай удирдах төсөл сонгон шалгаруулах тендерт **ялсан төрийн бус байгууллага нь гэрээлэгч болно.**

2. **Менежментийн гэрээний зорилго:**

- **ХЗТ-ын удирдлагын үр ашгийг сайжруулах, тус театрыг санхүүгийн хувьд бие даалгах**
- **Урлагийн зах зээлийн эрэлт хэрэгцээг шуурхай хангах, ингэснээр ХЗТ-ын уран бүтээлийн чанарыг сайжруулах, соёлын үйлчилгээний нэр төрлийг сайжруулах**

3. Гэрээлэгч нь ХЗТ-ыг энэхүү гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 2001 оны 12-р сарын 31 дуустал энэхүү гэрээнд заасан нөөхцлийн дагуу удирдана хэмээн Яам, Гэрээлэгч хоёр тохиролцов. Монгол улсын соёлын асуудал эрхэлсэн төв байгууллага нь ХЗТ-т улсын төсвөөс гэрээнд заасан хэмжээний дотаци олгох болно.

4. Гэрээлэгч нь ХЗТ-ыг харилцан тохиролцсон удирдлагын бүтэц, төлөвлөгөөний дагуу удирдана.

5. Гэрээлэгч нь улсын төсвийн шууд санхүүжилт /дотаци/, тоглолт, үйлчилгээний орлого, бусад эх үүсвэрээс орж ирэх орлогод тулгуурлан, үйл ажиллагааныхаа зардлыг хэмнэж ХЗТ-ын төсвийг захиран зарцуулна

Энэхүү гэрээг 1999 оны 2-р сарын 05-ны өдөр байгуулав.

Гэгээрлийн яамыг төлөөлж

Төрийн нарийн бичгийн дарга
Р.Бат-Эрдэнэ

„ХЗТ”, төрийн бус
байгууллагыг төлөөлж
Захирал
И.Нямгаваа

Тодруулга-6

МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999-02-05

№24

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах, гишүүн томилох тухай

Монгол улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 54-р зүйлийн 5 дахь заалт, Засгийн газрын 1998 оны 140-р тогтоол, Төрийн өмчийн хорооны 1999 оны 57-р тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд залуучуудын театрын менежментийн багтай 3 жилийн хугацаатай менежментийн гэрээг байгуулж, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллахыг засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл урлагийн газрын дарга Г.Мэнд-Ооёод даалгасугай.
2. Хүүхэд залуучуудын театрын менежментийн багийг шинээр байгуулах Удирдах зөвлөлд Гэгээрлийн яамыг төлөөлөх гишүүнээр Соёл урлагийн газрын ахлах мэргэжилтэн К.Жапахыг томилсугай.

Сайд

А.Баттөр

- Монголын хүүхэд залуучуудын театр киноны хүрээлэн нь Монгол Улсын Засгийн газрын 1997.07.02 өдрийн “Төрийн өмчийг 1997- 2000 онд хувьчлах хөтөлбөр”- ийн дагуу 1998 онд Засгийн газрын 140-р тогтоолыг үндэслэн Гэгээрлийн сайд, ТӨХ-ны даргын хамтарсан тушаалаар менежментийн хувьчлалд тендрийн шалгаруулалтаар хувьчлагджээ.

Тодруулга-7

Түрээсийн гэрээ

Энэхүү түрээсийн гэрээг доорхи хоёр этгээдийн хооронд байгуулав.

Үүнд:

1. Төрийн өмчийн хороо /цаашид ТӨХ гэнэ/
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Засгийн газрын 4-р байр
2. Монгол улсын иргэдэд урлаг, соёлоор үйлчлэх үндсэн зорилго бүхийнийгэмд үйлчилдэг, ашгийн төлөө бус байгууллаг а-Хүүхэд Залуучуудын Театр /цаашид Түрээслэгч гэнэ/
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж

Агуулга

1. Төрийн өмчийн хорооны гол үүрэг нь төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадаглалт, хамгаалалтанд хяналт тавихад оршино.
2. ТӨХ болон Гэгээрлийн яамнаас Хүүхэд залуучуудын театрыг /цаашид ХЗТ гэнэ/ үр ашигтай удирдах төсөл сонгон шалгаруулах тендерт „ХЗТ,, ТББ ялсан тул Түрээслэгч болно.
3. Түрээслэгч нь Түрээсийн гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 2001-12-31 өдрийг хүртэл уг гэрээнд заасан нөхцлийн дагуу Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт орших ХЗТ-ын үл хөдлөх болон бусад үндсэн хөрөнгийг түрээслэнэ хэмээн ТӨХ, Түрээслэгч хоёр тохиролцов.
4. Түрээслэгч нь ХЗТ-ын өмч хөрөнгийг Гэгээрлийн яам, Түрээслэгчийн хооронд 1999 –02-05 байгуулсан гэрээний дагуу хүн амын нийгэм, соёлын хэрэгцээг хангах үйлчилгээний зориулалтаар ашиглана хэмээн ТӨХ, Түрээслэгч хоёр тохиролцов.

Энэхүү гэрээг 1999 оны 02 сарын 05 өдөр байгуулав.

Монгол улсын Төрийн өмчийн
Хороог төлөөлж

Түрээслэгчийг төлөөлж

ТӨХ-ний дарга

ХЗТ-ын Гүйцэтгэх захирал

Менежментийн гэрээгээр гэрээлэгчийн хүлээх үүрэгүүд:

Менежментийн баг нь:

- ◆ Шинээр тавигдах жүжгүүдийг нэр төрөл, тооны хувьд бууруулалгүй театрыг тогтмол ажиллагаатай байлгаж, уран бүтээлийн чанарыг дээшлүүлэх, үзэгчдийн хүрээг өргөтгөх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлж эхлэх
- ◆ Уран бүтээлчдийн бие даасан бүтээлч ажиллагааг өндөржүүлэхийн тулд тэдний хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах шинэ журам боловсруулж мөрдөх
- ◆ Залуучуудын гоо зүйн соёл, мэдлэгийг дээшлүүлэх үүднээс үзвэр тойрсон уулзалт ярилцлага, шоу тоглолтуудын шинэ хэлбэрийн олон талын арга хэмжээг тогтмол явуулж эхлэх
- ◆ Найруулагч, жүжигчдийн мэргэжлийн зэргийг ахиулах, ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, сургалтад хамруулах
- ◆ Театрын дэргэд театр, киноны жүжигчид, гэрэл техникийн ажилчид, уран бүтээлчдийг бэлтгэж эхлэх

Ажиллагсдын орон тооны хувьд гэрээлэгч нь:

- ◆ ХЗТ-ын нийт ажиллагсад нь төрийн албан хаагч хэвээр байна. Гэрээлэгч нь Гэрээний үйлчлэх хугацаанд тэдэнд Төрийн албан хаагчийн хувьд эдлэх эрхийг нь бүрэн олгоно.
- ◆ Гэрээлэгч нь Гэрээний үйлчлэх хугацаанд шинээр ажилд хүн авах эрхтэй ба тэдгээр хүмүүс мөн Төрийн албан хаагчийн бүх эрхийг эдлэнэ.
- ◆ Гэрээлэгч нь Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгохтой холбоотой Монгол Улсын аливаа хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөх үүрэгтэй.

ХЗТ-ын удирдлага гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 3 сарын дотор гэрээлэгч нь:

- ◆ Шинээр тавих жүжгүүдийг нэр төрөл, тооны хувьд бууруулалгүй театрыг тогтмол ажиллагаатай байлгаж, уран бүтээлийн чанарыг дээшлүүлэх, үзэгчдийн хүрээг өргөтгөх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлж эхлэх
- ◆ Уран бүтээлчдийн бие даасан бүтээлч ажиллагааг өндөржүүлэхийн тулд тэдний хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах шинэ журам боловсруулж мөрдөх
- ◆ Залуучуудын гоо зүйн соёл, мэдлэгийг дээшлүүлэх үүднээс үзвэр тойрсон уулзалт ярилцлага, шоу тоглолтуудын шинэ хэлбэрийн олон талт арга хэмжээг тогтмол явуулж эхлэх
- ◆ Найруулагч, жүжигчдийн мэргэжлийн зэргийг ахиулах, ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, сургалтад хамруулах
- ◆ Театрын дэргэд театр, киноны жүжигчид, гэрэл техникийн ажилчид, уран бүтээлчдийг бэлтгэж эхлэх

Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 6 сарын дотор гэрээлэгч нь:

- ◆ Хөрөнгө хуримтлуулах, орлогоо өсгөх, арвижуулахад чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулан мөрдөх, цаашид боловсронгуй хэлбэрт шилжүүлэх
- ◆ Зардал хэмнэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлснээр ХЗТ-ын үргүй зардлыг багасгах, хөрөнгө мөнгө хэмнэх
- ◆ Театр, киноны тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэх асуудлаар гадаад орны холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулах
- ◆ Театрын барилгад их засвар хийж өрөө, тасалгаануудын байршлыг өөрчлөн үзвэр, үйлчилгээ явуулахад тохиромжтой болгох , орчныг тохижуулах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх
- ◆ Үзэгч, үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт хүлээж авах , уран бүтээл, үйлчилгээний чанарт үнэлгээ өгдөг тогтолцоо бий болгох

Дэнчин

- ◆ Гэрээлэгч нь Түрээсийн гэрээний баталгаат хадгаламжаас гадна Менежментийн гэрээний баталгаат хадгаламжийг банкинд нээх шаардлагатай. Менежментийн гэрээний баталгаат хадгаламжийн хэмжээ нь 5 сая /5000 000/ төгрөг байна.
- ◆ Менежментийн гэрээний хугацаанд уг баталгаат хадгаламжийг банкинд хадгалуулна.Энэ хугацаанд хуримтлагдсан хадгаламжийн хүүг гэрээний хугацааны эцэст Гэрээлэгчид бүрэн олгоно. Гэрээлэгч нь Менежментийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд баталгаат хадгаламжийн хэсгийг, эсвэл бүхэлд нь хуримтлагдсан хүүгийн хамт улсын орлого болгон хураана. Энэ тохиолдолд Гэрээлэгчид ногдуулах торгууль нь баталгаат хадгаламж, хуримтлагдсан хүүгийн нийлбэрээс илүүгүй байна.

Гэгээрлийн Яамнаас зөвшөөрөл авах шаардлага

- ◆ Гэрээлэгч нь дараах тохиолдолд Яамнаас албан ёсны зөвшөөрөл авах шаардлагатай:
- ◆ **А. Ажиллагсадын орон тоог гэрээ байгуулах үеийнхээс 10-с дээш хувиар цомхотгох,**
- ◆ Б. Уран бүтээлийн зориулалттай байр, тоног төхөөрөмжийг үзвэр үйлчилгээнээс өөр зориулалтаар ашиглуулахаар түрээслүүлэхэд /гуанз г.м туслах үйлчилгээнй зориулалтаар өрөө тасалгааг бусдад түрээслүүлэхэд Яамны зөвшөөрөл шаардагдахгүй/
- ◆ Дээрх асуудлаар тавьсан өргөдлийн хариуг Яам нь нэг сарын дотор өгнө. Хэрэв дээрх өөрчлөлт нь ажиллагсадын болон театрын ашиг сонирхолд нийцэж байвал Яам нь тодорхой үндэслэлгүйгээр уг зөвшөөрлийг өгөхөөс татгалзах ёсгүй. Хэрэв нэг сарын дотор Яамнаас албан ёсны хариу өгөөгүй бол Яамны зүгээс татгалзах зүйлгүй гэж Гэрээлэгч ойлгож болно.

Баримт мэдээлэл нээлттэй байх

- ◆ ХЗТ-ын удирдлага, аж ахуй, санхүү, үндсэн хөрөнгөтэй холбогдсон төрөл бүрийн мэдээ, мэдээллийг Яаманд байнга нээлттэй байлгана.

Нөхөн олговор ба даатгал

- ◆ Гэрээний хугацаанд дараах төрлийн хохирол, эвдрэл, алдагдал, торгууль, зардал, шүүхийн чирэгдэл зэргийг Гэрээлэгч өөрөө хариуцна:

- ◆ А.театрын байранд байгаа төрийн мэдлийн өмчид учирсан эвдрэл,алдагдал,
- ◆ Б.үйл ажиллагаа гэрээний дагуу явж байх явцад гарсан аливаа хувийн хохирол, бэртэл буюу нас баралтаас үүдсэн нэхэмжлэлийн зардал.
- ◆ Мөн Гэрээлэгч нь Монгол улсын соёл, урлагийн салбарт түгээмэл хэрэглэгдэж буй даатгалд хамрагдсан байна.

Тайлагнах журам

- ◆ Гэрээлэгч нь ХЗТ-ыг удирдаж байгаагийн хувьд холбогдох мэдээ, тайланг тогтоосон журмаар ТӨХ, Гэгээрлийн яам, бусад төрийн байгууллагуудад гаргаж өгч байна. Үүнээс гадна, энэхүү баримт бичгийн Хавсралт 1-д
- ◆ заасны дагуу нэмэгдэл мэдээллийг тогтмол гаргаж байх шаардлагатай.

Удирдлагын цалин ба Удирдах зөвлөлийн нөхөн олговор

- ◆ *Удирдах албан тушаалтнууд*
- ◆ Удирдах зөвлөл нь тус театрын удирдах албан тушаалтнуудын цалинг ХЗТ-ын орлогоос тогтоох ба харин:
- ◆ А. ХЗТ-ын удирдах албан тушаалтны цалин нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын адилтгах албан тушаалтны цалингийн дундаж хэмжээнээс 30 хувиас илүүгүй байна.
- ◆ Б. ХЗТ-ын удирдах албан тушаалтны цалин нь мөн театрын уран бүтээлчдийн дундаж цалингийн хэмжээнээс 150 хувиас илүүгүй байна.

Удирдах зөвлөлийн гишүүд

- ◆ Удирдах зөвлөлийн гишүүд нь уг зөвлөлд ажилласны цалин хөлс, шагнал урамшил авахгүй. Харин ХЗТ-ын нэрийн өмнөөс зохион байгуулсан арга хэмжээнд уг гишүүн хөрөнгө мөнгө зарцуулсан бол түүнийг нөхөж олгоно.

Гэгээрлийн яамны хүлээх үүрэг

- ◆ **Улсын төсвөөс олгох шууд санхүүжилт**
- ◆ Гэрээнд гарын үсэг зурснаас хойшхи хугацаанд ноогдох дотаци төгрөгийг зохих журмын дагуу Гэрээлэгчид олгоно.
- ◆ Яам нь Гэрээлэгчид улсын төсвөөс олгох санхүүжилтийг дараах байдлаар хийнэ:

1999 он	Гэрээний хоёрдахь жил	Гэрээний гурав дахь жил	Гэрээний эцсийн жил
.. төгрөг	.. төгрөг/Эхний жилд олгосноос бага	.. төгрөг /өмнөх жилд олгосноос бага/	0 төгрөг

Улсын төсвөөс олгох шууд бус санхүүжилт

- ◆ Гэрээний хүчинтэй байх хугацаанд ХЗТ нь Соёл, урлагийг дэмжих тусгай сангаас тус театрын төсөл шалгарсан нөхцөлд санхүүгийн дэмжлэг авах эрхтэй.

Улс төрийн үйлдэл

- ◆ Төр, засгаас соёл, урлагийн талаар гаргасан тогтоол, шийдвэрээс шалтгаалан Гэрээлэгчээс тус гэрээг биелүүлэх явцад гарсан нэмэлт зардлыг Яам хариуцна.

Хуульд өөрчлөлт орох

- ◆ Соёл, урлагийн салбартай холбогдолтой хуульд нэмэлт өөрчлөлт орсноос шалтгаалан Гэрээлэгчээс тус гэрээг биелүүлэх явцад гарсан нэмэлт зардлыг Яам хариуцна.

Хөндлөнгийн хяналт, шалгалт

- ◆ Энэ гэрээний хугацаанд Гэгээрлийн яамны ажилтнууд өөрсдийн зардлаар ХЗТ-ын үйл ажиллагаа, Гэрээлэгчийн удирдлагын ба аж ахуйн бүртгэл, санхүүгийн тооцоо болон бусад мэдээ, материалыг шалгах эрхтэй.

Яамны эрх

- ◆ Гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд Яамнаас Гэрээлэгчид доорхи арга хэмжээг авах эрхтэй:

а/ Сануулга өгөх

б/ Улсын төсвийн шууд санхүүжилтийг /дотацийг/ бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн зогсоох,

в/ Гэрээлэгчийн баталгаат хадгаламжийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн хураах,

г/ Гэрээг цуцлах,

д/ шүүхэд нэхэмжлэл гаргах

е/ дээрхи арга хэмжээнүүдийг хослуулан шийтгэл ногдуулах.

Өмчийг шилжүүлэх

- ◆ Гэрээлэгчийн үйл ажиллагааг энэхүү баримт бичгийн 2.2.2-т заасны дагуу гэрээний үйлчлэх хугацаанд жилд хоёроос доошгүй удаа Аудитын комисс шалгах болно. Уг шалгалтаар Гэрээлэгчийн үйл ажиллагаа нь Хавсралт 2-т заасан шалгууруудад хүрч байгаа эсэхийг хянах болно. Аудитын комиссын эцсийн шалгалтыг гэрээний хугацаа дуусахаас 3 сарын өмнө явуулна.
- ◆ Аудитын комиссын үзэж байгаагаар, Гэрээлэгч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн биелүүлсэн, үйл ажиллагааны үзүүлэлтүүд нь энэхүү баримт бичгийн Хавсралт 2-т заасан түвшинд хүрсэн бол ХЗТ-ын үл хөдлөх болон бусад үндсэн хөрөнгө өмчийг Гэрээлэгчид шилжүүлж болох тухай Аудитын комисс зөвлөмж гаргаж ТӨХ-д танилцуулна. ТӨХ-ны шийдвэрээр ХЗТ-ын үндсэн хөрөнгө болох газар, барилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр Гэрээлэгчийн байнгын эзэмшилд шилжүүлэх болно. Гэхдээ Гэрээлэгч нь Өмч шилжүүлэх тухай баримт бичигт заасан хязгаарлалтыг мөрдөх үүрэгтэй.
- ◆ Аудитын комиссын үзэж байгаагаар, Гэрээлэгчийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд нь энэхүү баримт бичгийн Хавсралт 2-т заасан үнэлгээний системийн дагуу ..-с дээш боловч ..-с доош оноогоор үнэлэгдсэн бол Менежментийн болон Түрээсийн гэрээний хугацааг ижил төстэй болзлоор сунгах тухай Аудитын комиссын зөвлөмжийг ТӨХ-д танилцуулна.
- ◆ Аудитын комиссын үзэж байгаагаар, Гэрээлэгч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол шинээр Тендер зарлаж ХЗТ-ын удирдлагыг сонгох тухай Аудитын комиссын зөвлөмж гарна.

➤ **ᠣᠵᠡᠳᠦᠶ᠋᠎ᠠ ᠴᠠᠰᠡ᠐᠐-᠐᠖ᠠᠶᠢᠨ ᠳᠠᠭᠠᠳᠳᠣᠢ 2000 ᠠᠨ ᠶᠣᠵᠡᠡ ᠳᠠᠭᠠᠨ ᠰᠡᠶ᠋ᠠ ᠳᠡᠡᠨᠦᠶᠢ ᠠᠵᠡᠳᠢ ᠳᠠᠶᠡᠠᠢ**

/ 2000 оны 1.1-нээс 7.1 /

	Хийх ажлууд	Хийсэн ажлын гүйцэтгэл.
1.	1999 оны театрын жилийн тайланг хэлэлцэж, 2000 оны төсөв төлөвлөгөөг батлах.	2000 оны 4 сарын 27-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар өнгөрсөн оны ажлын тайланг хэлэлцэж, 2000 оны төсвийг батлав.
2.	Шинээр уран бүтээл хийж хотод болон хөдөө орон нутагт тоглолт хийхийн зэрэгцээ уран бүтээлийн чанарыг дээшлүүлэх.	Хүүхдийн жүжгийн теле-театр байгуулах зорилгоор Монгол телевизийн ЭВ ЭЕ студитэй хамтран шинээр бүтээгдсэн жүжгүүдийн бичлэг хийлгэж нийтэд үзүүлж архивт хадгалж эхэллээ. Ж нь: "Бага нас минь баяртай", "Хүүхдийн шоу" тоглолтуудын бичлэгийг хийлгэв. 4-р сард "Элдэв зураг 2000" хөтөлбөрийг тоглон, жүжигчдийн хэсэгчилсэн групп 5 сард Хэнтий, Дорноговь, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын төв суурингаар явж тоглов. Мөн "Азтай бадарчин" тоглолтонд амжилттай оролцлоо.
3.	Театрын өргөтгөлийн зургийг хийлгэж батлуулах	Театрын өргөтгөлийн барилгын зураг төслийг архитекторч Сүхбаатартай гэрээ хийн, УБ, Дархан хотуудын театруудтай танилцуулан хийлгүүлээ. Барилгын эхний эскиз, архитекторын зургийг 500.0 мян. төгрөгөөр хийлгүүлж, УБ хотын ерөнхий архитекторч Нямсүрэнгээр батлуулан зөвшөөрөл байв. Одоо архитекторч Ганбаатараар барилгын хийцийн зураг төслүүдийг хийлгэж байна.
4.	Театрын барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх барилгын техник нөхцлийн зөвшөөрөл авах.	Театрын барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх техникийн нөхцлийг 9 байгууллагаар танилцуулан зөвшөөрлийг 5 сард авлаа.
5.	Театрын эзэмшлийн газрын хэмжээг тогтоож , зөвшөөрөл 6 сард багтааж авах	Театрын эзэмшил газрын хэмжээг тогтоож УБ хотын Газрын албаны захирамж гаргуулан баталгаажуулахад бэлэн болоод байна.
6.	Театрын өргөтгөлийн засварын ажлыг 5 сард эхлүүлэх	Театрын өргөтгөлтэй холбогдуулан гал түймэр, хулгай зэргээс сэрэмжлэх арга хэмжээнүүдийг авлаа. ТУЗ-ийн дарга М.Энхтайван уг өргөтгөл засварт 500.0 орчим сая төг шаардлагатай байгаа бөгөөд эхний ээлжинд газар шорооны ажил хийх, барилгын үндсэн каркас босгоход 270.0 сая төг яаралтай гарган шийдвэр өгсөн боловч одоо түр 8 сарын 15 хүртэл хугацаагаар ТУЗ-ийн даргын шийдвэрээр хойшлогдоод байна. Өргөтгөл засварын ажлыг 2001 оны 5 сард дуусгаж ашиглалтанд оруулах юм.
7.	Америкийн Нью-Йорк, Сиэтл, Вашингтон хотууд, Австралид болох кино наадамд оролцох	5,6 сард АНУ-ын Нью-иорк, Сиэтл, 8 сард Вашингтонд, 7 сард Австралид болох кино фестивальд бидний бүтээсэн "Догшин хутагтын сахиус" уран сайхны кино шалгаран оролцож, азийн 100 гаруй киноноос шалгаран Японы Фукуока, Токио хотуудад гарах эрх авлаа.

Гүйцэтгэл гаргасан:

ХЗТКХүрээлэнгийн дэд захирал
Нягтлан бодогч

С.Тунгалаг
Д.Эрдэнэчимэг

➤ **Хүүхэд Залуучуудын Театрын гүйцэтгэх захирал И.Нямгаваагийн 2000 оны эхний улирлын ажлын тайлан**

2000 оны 2-р улиралд тус театрын уран бүтээлчид "Элдэв зураг -2000" хөтөлбөрийг бэлдэн радио телевизээр сурталчлан инээдмийн баярын өдрүүдээр тоглолоо. Мөн жүжигчдийн хэсэгчилсэн группууд хөдөө аймаг сумдаар явж тоглосноос гадна "Азтай бадарчин" тоглолтод амжилттай оролцлоо.

Театрын өргөтгөлийн барилгын зураг төслийг архитекторч Сүхбаатартай ярилцан , Улаанбаатар, Дархан хотуудын театрын барилгатай танилцуулан хийлгүүлээ. Барилгын эхний эскиз , архитекторын зургийг 500.0 мянган төгрөгөөр хийлгүүлсэн бөгөөд УБ хотын ерөнхий архитектор Нямсүрэнгээр батлуулж зөвшөөрөл авлаа. Одоо архитекторч Ганбаатараар барилгын хийцийн зураг төслүүдийг хийлгэж байна.

Мөн барилга ашиглалтанд орсны дараах театрын үйл ажиллагааны эдийн засаг санхүүгийн тооцоог ойролцоо байдлаар хийлгүүлээ.

Хүүхэд Залуучуудын Театрын барилгын өргөтгөлийн газрыг баталгаажуулан УБ хотын Газрын албаны захирамж гаргууллаа.

5-р сарын эхний 10 хоногт багтаан өргөтгөлийн шан татах, газар ухах ажлын бэлтгэл үндсэндээ хангагдсан гэж үзэж байна.

Барилгын өргөтгөлтэй холбогдуулан гал түймэр, хулгай зэргээс сэрэмжлэх үүднээс харуул манааг сайжруулан хашаа босгон манаач буулгах зэрэг ажлыг эхлэх шаардлагатай байна.

Одоогоор М. Энхтайваны тусламжтайгаар 500.0 орчим сая төгрөгний өртөгтэй киноны техникийн асуудлын өр төлбөрийг ХОТШ банкны эрх хүлээн авагч нартай тохиролцон барагдуулахаар боллоо.

Үүнээс гадна албан газруудын захиалгат баримтат киноны болон Оюунтүлхүүр сан мөн Японы уран бүтээлчдийн захиалгат киноны бэлтгэлд ороод байна.

2000 оны 5,6-р сард Америкийн Нью-Йорк, Сиэтл , 8-р сард Вашингтон, 7-р сард Австралид болох олон улсын кино фестивалд бидний бүтээсэн "Догшин хутагтын сахиус" уран сайхны кино уригдаад байна. Энэ кино нь Азийн 100 гаруй киноноос шалгаран японы Фукуока ,Токио хотуудад гарах боллоо.

➤ **Хүүхэд залуучуудын Театрын 2000 оны эхний хагас жилийн тайлан балансын илтгэх хуудас**

Тус театр нь 2000 оны эхний хагас жилийн байдлаар 16305.6 мянган төгрөгний санхүүжилт авч, 23.686.8 мян.төгрөгний орлого олохоос 18305.6 мян төгрөгний санхүүжилт авч 1648.1 мян төгрөгний орлого олоод байна.

Орлогын төлөвлөгөө тасалдсан шалтгаан нь :

Тус театрын байр, үзвэрийн танхим хүйтэн, суудал цөөн, өнгө үзэмж, тохь тух муугаас тоглолт хийсэн ч уран бүтээлийн чанараас үл хамааран үзэгчид цөөхөн, мөн заалаа түрээслүүлэх боломжгүй байсных юм. Ийм учир юуны өмнө байрандаа өргөтгөл засварын ажил хийхээр төлөвлөж, өргөтгөлийн зураг төсөл хийлгэж, төсөв гаргаж, газрын зөвшөөрөл, өргөтгөл хийх зөвшөөрөлийг энэ хугацаанд авч бэлэн болгосон юм.

Орлогын төлөвлөгөөг нөхөн санхүүжүүлэхээр захирал И.Нямгаваа нь 15.000.0 мян төгрөгийг театртаа оруулан , шинэ уран бүтээл хийхээр өгч, одоо тайзны сургууль хийж байна.

Цаашид (2001 оны 4 сар хүртэл) өргөтгөл засварын ажил эхлэх хүртэл өөрийн байранд тоглолт хийж, хот орчмоор, сургууль, цэцэрлэгүүдээр тоглолт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Засварын ажил 2001 оны 9 сард дуусахад их, бага заалуудад тоглолт хийх, уран бүтээлтэй холбоотой үзэсгэлэн гаргах, бүх жүжигчид уран бүтээлчдэд зориулан саун, гоо сайхны үйлчилгээ явуулах зэргээр орлогын тасалдлыг нөхөж, улмаар орлогоороо зарлагаа нөхөх боломжийн эхлэл тавигдах юм.

➤ Менежментийн багийн гаргасан дүгнэлт

1. ХЗТеатрын материаллаг баазын хувьд гаргасан дүгнэлт

Тус театрын зүгээс менежментийн гэрээнд заасны дагуу театрын барилга, техник, тоног төхөөрөмжийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тодорхой үе шаттайгаар шинэчлэх төсөл боловсруулан хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах шаардлага зайлшгүй урган гарсан байна. Энэ зорилгоор гэрээний хугацаанд Германы IGK компани, Японы Tohten enterprise ксмпани, Агротехимпекс, Монгол газар, Нарантуул, Симба компаниуд, Кёкүшюзан хөгжил сан зэрэг гадаад дотоодын хөрөнгө оруулагчидтай давхардсан тоогоор нийт 30 гаруй уулзалт ярилцлагыг зохион байгуулж, гадаад дотоодын эдгээр арга хэмжээнд 8765,1 мянган төгрөг зарцуулсан байна. Гэсэн хэдий боловч:

Хүүхэд Залуучуудын Театр Киноны Хүрээлэн нь хэдийгээр Менежментийн гэрээгээр хувьчлагдсан боловч нөгөө талаас зохих хэмжээгээр төсвийн санхүүжилт авдгийн хувьд хагас төсвийн байгууллагын заримдаг статустай явж ирсэн учраас эрх зүйн хувьд бүрэн чадамжтай хуулийн этгээд болж чаддаггүй онцлогтой.

- Театрын барилга нь нэгэнт төрийн өмч учраас Менежментийн багийн зүгээс хөрөнгө оруулагчдад шаардлагатай хөрөнгийн баталгааг нь гаргаж өгөх боломжгүй байдаг.
- Гэрээнүүдэд хууль эрх зүйн орчны эрсдлийн асуудал (тухайлбал, нийгмийн салбарын хувьчлалын хууль батлагдаагүй) тодорхой тусгагдаагүй зэрэг үндсэн шалтгаануудаас үүдэн хөрөнгө оруулагчидтай хийсэн дээрх уулзалт, хэлэлцээрүүд тодорхой үр дүнд хүрээгүй бөгөөд цаашид ч хууль зүйн хувьд хүрэх үндэсгүй гэдэг нь нэгэнт тодорхой болжээ.

Харин Менежментийн багийн эрх хэмжээнд багтсан театр, киноны техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх хөтөлбөр, төсөл амжилттай хэрэгжиж, ХБНГУ-ын FGV SCHMIDLE GMBH, MOVIE TECH фирмүүдээс нийт 342,98 сая төгрөгийн өртөг бүхий кино зураг авах хамгийн орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмжийг оруулж ирсэн нь баримтат болон дэлгэцийн уран сайхны киноны хөгжилд маш чухал түлхэц өгөх арга хэмжээ болжээ.

Ийнхүү эрх зүйн шаардлагатай орчин бүрдээгүй хэдий боловч тус хүрээлэнгийн Менежментийн баг нь уг театрыг түшиглэн орчин үеийн хэрэгцээ, шаардлага, Олон улсын жишигт нийцсэн театр, үйлчилгээний төвийг байгуулах зорилгоор театрын барилгад иж бүрэн засвар, өргөтгөл хийж, театр, шоу, концертын "Тэмүүжин Арт театр, үйлчилгээний цогцолбор" байгуулах төслийг "Монгол төсөл" ХХК-тай хамтран боловсруулсан байна. Энэ барилгын архитекторч Сүхбаатартай гэрээ хийн, Берлин, Дрезден, Дархан, Улаанбаатар хотуудын том том театруудын барилгатай танилцуулан зураг төслөө захиалж, хийлгүүлжээ. Барилгын эхний эскиз, архитектурын зургийг Улаанбаатар хотын Ерөнхий архитекторчоор батлуулан зөвшөөрөл авч, барилгын өргөтгөлийг эхлүүлэх техникийн нөхцлийг холбогдох байгууллагад танилцуулан зөвшөөрөл авсан. Театрын эзэмшил газрын хэмжээг тогтоолгох Нийслэлийн Засаг даргын 2000 оны 07 дугаар сарын 28-ний өдрийн А/244 тоот захирамжаар эзэмшил газраа баталгаажуулсан байна. Эдгээр арга хэмжээнд 2,986 сая төгрөгийн зардал гаргажээ.

Монгол улсын "Барилгын тухай хууль" батлагдаж, барилга бүрийг паспортжуулах болсонтой уялдан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Барилга техникийн хяналтын улсын байцаагчийн 2001.05.14-ний өдрийн 56 дугаар техникийн дүгнэлтийг" ноцтой зөрчиж байгааг үндэслэн барилга, инженерийн геологийн нарийвчилсан шинжилгээ болон хийц бүтээцийн төлөв байдалд нарийвчилсан судалгаа хэмжилт, инженерийн иж бүрэн тооцоог хийсний үндсэн дээр барилгыг бат бэх, тогтвортой, найдвартай ажиллуулах хүчитгэл бэхлэлгээний зураг төсөл боловсруулж, бэхлэх арга хэмжээг авах шаардлагатай. Иймд "Барилгын тухай хууль"-ийн 8,1,1 заалтын "Барилга байгууламжид хүний ажиллах, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлж, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байх" шаардлагыг болон "даацын хийцийн бат бэх, тогтворыг хангасны дараа барилгыг ашиглах нь зүйтэй" гэсэн дүгнэлтүүд тус тус гарсан байна.

Барилгын техникийн эдгээр актуудын дагуу театрын барилга, инженерийн шугам сүлжээнд иж бүрэн их засвар хийхэд холбогдох мэргэжлийн байгууллагын үнэлгээгээр даруй 1,15 тэрбум төгрөгийн зардал шаардагдах тооцоо гарч байна. Хэрэв "Нийгмийн салбарыг хувьчлах тухай хууль" батлагдан гарахыг хүлээж, хувьчлалыг удаашруулахад хүрвэл төрийн өмчийн барилга, байгууламжийг хөлдөөж, дахин сэхэл авахгүй болтол нь дордуулахгүй байх үүднээс улсын төсвөөс энэхүү их засварын ажилд хөрөнгө төсөвлөхийг хүртэл тодорхой бус хугацаагаар хааж битүүмжлэх шаардлагатай болж ч болох юм.

Хэрэв иймэрхүү нөхцөл байдал бодитойгоор бүрдвэл Гэрээлэгчийн зүгээс менежментийн болон түрээсийн гэрээг дангаараа цуцлах саналыг БСШУЯ-д болон ТӨХ-нд тавьж, эдгээр гэрээний үргэлжилсэн хугацаанд Менежментийн багаас гаргасан зардал (нийт 516,17 сая төгрөг)-аа Иргэний хууль болон дээрх гэрээнүүдэд заасны дагуу нэхэмжлэх ноцтой нөхцөл байдал үүсч тун болзошгүй юм.

Дээр нь нэмээд уг театрыг эргүүлж төсөвт байгууллага болгоход хүрвэл жил бүр 100-110 сая төгрөгийн төсвийн нэмэлт ачаалал улсын нуруун дээр ирэх болно.

Чухам ийм бодитой нөхцөл байдал, шалтгааны улмаас нэгэнт барилгын ажлын технологийг зөрчин чанар муутай баригдсан, 23-25 жил ашиглагдаж, элэгдэж хуучирсан, их засвар хийж эргэж хэвийн байдалд нь оруулахад улсаас ихээхэн хөрөнгө мөнгө /1,15 тэрбум орчим төгрөг/ шаардагдах энэ барилгыг Менежментийн гэрээнд заагдсан үүргээ биелүүлж, өмчийг шилжүүлэн авах болзол (нэгдсэн үнэлгээ 2,149)-ыг хангасан Хүүхэд Залуучуудын Театртын Менежментийн баг (И. Нямгаваа)-г зохих үнэ төлбөртэйгөөр, театрын барилгад их засвар хийж, цаашдаа театр, урлагийн үйлчилгээний үндсэн чиглэлийг хадгалах болзлоор урт хугацааны зээлээр худалдах явдал нь асуудлыг зүй зохистойгоор шийдвэрлэх үндсэн арга зам гэж Ажлын хэсэг үзэж байгаа юм.

Хүүхэд Залуучуудын Театр Киноны Хүрээлэнгийн хүсэлтээр барилгын өнөөгийн зах зээлийн үнийг тодорхойлох зорилгоор "Хөрөнгийн үнэлгээний төв" ХХК-иар үнэлгээ хийлгэхэд 2001 оны 08-р сарын 08-ны байдлаар тус барилгын үнэ 204 656 400 (хоёр зуун дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга дөрвөн зуу) төгрөг болохыг тогтоосон байна.

Гэрээний хугацаанд тус театрын 1999 оны 2-р сарын 5-наас 2001 оны 7-р сарын 1 хүртэлх үеийн үйл ажиллагаанд Монгол Улсын Гэгээрлийн Яам, Төрийн өмчийн хорооны Аудитын комиссын, 1998 оны сүүлийн хагас, 1999, 2000, 2001 оны 1-р улиралын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Санхүүгийн улсын хяналт шалгалтын албанаас тус тус шалгалт хийж, "хангалттай", "сайн" үнэлэлтүүдийг өгч, цаашид өмч хувьчлалын асуудлыг яаралтай шийдвэрлүүлж, өмчлөгч этгээдийн эрх зүйн статусыг тодорхой болгох үндсэн дээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг театрын их засвар, өргөтгөл шинэчлэлд татан оролцуулах эрх зүйн үндсийг бүрдүүлснээр олон улсын жишигт дүйцсэн театр, киноны цогцолбор болгон ажиллуулах, арга хэмжээ авах хэрэгтэй гэсэн гол дүгнэлтүүдийг гаргасан байна.

2. ХЗТеатрын уран бүтээлийн хувьд

Найруулагч И. Нямгаваагийн найруулсан "Догшин хутагтын сахиус" уран сайхны кино нь дараах Олон Улсын кино наадмуудад уригдаж буюу шалгарч шагнагдаж байсан ба Монгол Улсын гадаад сурталчилгаа, нэр хүндэд зохих хувь нэмрээ оруулсан байна. Үүнд:

1. 1999 оны 5-р сарын 4-18-нд Австралийн Сидней хотод жил бүр зохиогддог кино наадам
2. 1999 оны 11-р сарын 21-28-нд Швейцарийн Фрибург хотноо зохиогдсон кино наадам,
3. 2000 оны 1-р сарын 13-24-ний өдрүүдэд АНУ-ын Калифорни мужийн Палм Спрингс хотноо зохиогдсон их наадам,

4. 2000 оны 5-р сард 27-28-нд АНУ-ын Нью-Йорк хотод зохиогдсон кино наадам, мөн Монголын кино өдрүүд,
5. 2000 оны 5-р сарын 18-наас 6-р сарын 11-ний өдрүүдэд АНУ-ын Сиэтл хотод зохиогддог Олон Улсын кино үзлэг,
6. 2000 оны 7-р сарын 21-28-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотод зохиогддог Олон Улсын кино наадам,
7. 2000 оны 8-р сарын 13-20-ны өдрүүдэд АНУ-ын Чикаго хотод зохиогддог Олон Улсын кино үзлэгт тус тус оролцсон.
8. 20 дугаар зууны сүүлийн 10 жилд Азид бүтээгдсэн 500 орчим киноноос шилдэг 10 киноны тоонд багтан шалгарч 2000 оны 12 сарын 8-14-ний өдрүүдэд Японы Токио хотод зохиогдсон "Азийн шилдэг кино"-ны үзлэгт найруулагч И. Нямгаваа киноны хамт уригдсан нь монголын кино урлагийн хүрээнд томоохон үйл явдал болжээ.

Мөн найруулагч И. Нямгаваа нь "Догшин хутагтын сахиус", "Газар шороо мину зэ" уран сайхны кинонуудаараа 1999 оны "Гоо марал" тэмцээний Шилдэг найруулагчийн шагнал хүртсэн байна.

Театрын уран бүтээлийн хувьд найруулагч И. Нямгаваа нь гэрээний хугацаанд Хүүхдийн "Инээдмийн шоу", "Элдэв зураг-1999, 2000, 2001" хөтөлбөрүүд, Д. Гармаагийн "Эрх гүнж", Д. Батбаярын "Бага нас минь баяртай", С. Михалковын "Үнэтэй хүүхэд", Ф. Достоевскийн "Цагаан шөнө" зэрэг жүжгүүдийг шинээр найруулан тавьж хүүхэд залуучуудын хүртээл болгосон байна.

Зохиолч С. Жаргалсайханы "Диваажинд хүрэх зам" жүжгийг шинээр найруулан тавьсан нь үзэгч олноос ихээхэн талархал хүлээсэн бөгөөд удахгүй Улаанбаатар хотноо зохиогдох Монгол туургатны Театрын наадамд энэ жүжгээрээ оролцох гэж байна.

Тодруулга -8

"Догшин хутагтын сахиус" кино нь найруулагчийн өөрийн бүтээл байсан тул театрын уран бүтээлийн санд ямар ч хувь нэмэр оруулаагүй төдийгүй санхүүгийн хувьд ч дэмжлэг болсон зүйл огт байхгүй.

С. Жаргалсайханы "Диваажинд хүрэх зам" жүжгийг гэрээний хугацаанд ХЗТеатрт найруулан тавьсан. Энэ жүжиг нийтдээ 4 удаа тоглогдсон бөгөөд үзэгчидгүйн улмаас хаагдсан. Мөн Элдэв зураг-1999, 2000 хошин шоу хөтөлбөрүүд ХЗТеатрийн тайзнаа тавигдсан бөгөөд бас л 3-4 удаа тоглогдоод хаагдаж байжээ. Эдгээрээс өөр жүжиг менежментийн хувьчлал хийгдсэнээс хойш шинээр тавигдаагүй байна. *Эх сурвалж: Жүжигчин Б-гийн ярилцлага*

3. Орлого, санхүүжилтийн талаар

Тус театр нь Менежментийн гэрээнд заасны дагуу улсаас авах санхүүжилтийг жил тутам 20-80%-иар бууруулан авснаар гэрээний хугацаанд нийт санхүүжилт 68,4 сая төгрөгөөр багасч бодитойгоор хэмнэгдсэн бөгөөд үүнийг хүснэгт №1-д үзүүлэв.

Хүснэгт №1.

Он	Авбал зохих санхүүжилт	Авсан санхүүжилт	Хэмнэлт / +, - /
1999	56 452 500	50 452 500	+ 6 000 000
2000	57 900 000	28 155 600	+ 29 744 400
2001	60 600 000	27 976 900	+ 32 623 100
Дүн	174 952 500	106 585 000	+ 68 367 500

Менежментийн гэрээнд эдийн засгийн макро орчны нөлөөллийг тооцох талаар тодорхой заалтууд тусгагдаагүйгээс дулаан, цахилгаан, усны үнийн өөрчлөлт зэрэг нь театрын үйл ажиллагаанд зохих хэмжээний бэрхшээл учруулсан байна. Гэрээний хугацаан дахь үнийн өсөлтийг хүснэгт №2-т үзүүлэв.

№	Үзүүлэлт	1999 он	2000 он	2001 он	Өсөлт		
					1999/2000	2000/2001	2001/1999
1	Дулаан	6 778,1	10426,2	12145,7	53,8%	16,5%	79,2%
2	Цахилгаан	3 517,2	3605,8	3672,5	2,5%	1,8%	4,42%
3	Ус	3 640,8	4092,0	4272,0	12%	4,3%	17,3%

Тус театрыг 2001 оны 4-р сараас эхлэн он дуустал, 2002 оны улсын нэгдсэн төсвөөс санхүүжилт авахгүй байхаар төсөвт төлөвлөжээ.

➤ **ХЗТ-ийн менежментийн гэрээ болон дүгнэлт, саналын тухай**

Гэгээрлийн яам, Хүүхэд залуучуудын театрын хооронд 1999 оны 2 дугаар 5-ны өдөр байгуулсан “Менежментийн гэрээ”-г Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд, төрийн өмчийн хорооны хамтарсан тушаалаар томилогдсон ажлын хэсэг шалгаад театрын менежментийн баг нь өмчийг шилжүүлэн авах болзолыг хангасан байна гэж үзэн барилгын үнийг иргэний хуулийн 217 дугаар зүйлд заасны дагуу 2008 он хүртэл төлөх, театрын барилгад их засвар хийж үндсэн үйл ажиллагааны чиглэлийг цаашид хадгалах болзлоор өмчлөлд нь шилжүүлэх саналыг боловсруулжээ.

Дээрх санал нь хууль зүйн талаасаа боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг авсны дагуу Гэгээрлийн яам, Хүүхэд залуучуудын театрын хооронд байгуулсан Менежментийн гэрээ, Төрийн өмчийн хороо – Хүүхэд залуучуудын театрын хооронд байгуулсан түрээсийн гэрээ болон эдгээр гэрээний биелэлтийг шалгасан үр дүнгийн тухай танилцуулга түүнд хийсэн дүгнэлт менежментийн гэрээний үзүүлэлтүүдийн биелэлт зэрэг материалыг судлан үзээд дараах дүгнэлтийг хийлээ.

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11-р зүйлийн 4 дэхь хэсэгт зааснаар Төрийн өмчийн хороо нь Засгийн газраас баталсан жагсаалтын дагуу эд хөрөнгийг хувьчлах ажлыг эрхлэн зохион байгуулдаг. Хүүхэд залуучуудын театрын хувьчлалаас харахад гэгээрлийн яам менежментийн гэрээг байгуулжээ.

Иймд яам дээрх хуулийн заалтыг зөрчин яам өөрийн чиг үүрэгт хамаарахгүй асуудалд оролцсон байна.

Менежментийн гэрээ өөрөө хувьчлалын нэг арга буюу хувьчлалын гэрээ учир гэрээг хуульд заасны дагуу төрийн өмчийн хороо байгуулах ёстой байжээ.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58-р зүйлийн 1 дэхь хэсэгт “Төрийн өмчит хуулийн этгээдийг удирдах үйл ажиллагааг Хувийн өмчит хуулийн этгээд , хувь хүнээр, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно” гэж заасан байдаг .

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 6-р зүйлд зааснаар төрийн бус байгууллага нь үүсгэн байгуулагчаас байгуулах тухай шийдвэр гаргаж улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ . Мөн 15-р зүйлд төрийн бус байгууллагыг хуульд заасан журмын дагуу хууль зүйн яам бүртгэнэ гэж заасан байна.

Гэтэл “Хүүхэд залуучуудын театр” төрийн бус байгууллага нь хууль зүйн яаманд бүртгүүлээгүй . Өөрөөр хэлбэл ийм нэртэй хуулийн этгээд байгуулагдаагүй байна. Үүнээс үзэхэд гэрээг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу “хуулийн этгээд”-тэй ч биш “хувь хүн”-тэй ч биш, өөрөөр хэлбэл гэрээ байгуулах эрхгүй этгээдтэй байгуулсан байна. Нэгэнт гэрээг байгуулах эрхгүй этгээдүүд хоорондоо байгуулсан уг гэрээ нь хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцогдох бөгөөд энэ тохиолдолд хэлцлээр авсан бүх зүйлийг харилцан буцааж өгөх боломжгүй нөхцөлд үнийг төлөх ёстой байдаг .

3. Гэрээг байгуулахдаа хуульд заавал заахаар тусгагдсан нөхцлүүдийг тодорхой тусгаагүй байна. Тухайн гэрээнд заасан үүргээ биелүүлсэн нөхцөлд төрийн өмчийн эд хөрөнгөөс хувьчлан өгөх хэмжээ, хэлбэр, үнэ, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйд хүлээлгэх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх хэлбэр, хэмжээ г.м

Зүй нь менежментийн гэрээнд дээрхи нөхцөлүүдийг тодорхой тусгаад , барилга түрээслэх тухай гэрээг бол байгуулах ёсгүй байсан байна. Төрийн өмчийн хорооны байгуулсан барилга түрээслэх гэрээнд менежментийн гэрээний зарим нөхцлийн хэрэгжих боломжийг хаасан байна. Менежментийн

гэрээ байгуулагч нь тодорхой хугацаанд тодорхой хязгаарлалт хяналтын доор өмчлөх эрхээ хэрэгжүүлж байгаад тухайн хугацаа дуусмагц эд хөрөнгийг өөрийн өмчлөлд шилжүүлэн авах ёстой . Гэтэл түрээсийн гэрээгээр түрээслэгч нь зөвхөн эд хөрөнгийг эзэмших ашиглах эрхийг л олж авдаг . Эндээс үзэхэд түрээсийн гэрээ байгуулснаар хувьчлалын утга зарим талаар алдагдаж байна.

4. Менежментийн гэрээг байгуулахдаа хуульд заасан гэрээнд заавал тусгах ёстой гол нөхцөлүүдийг, тухайлбал гэрээлэгч үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд хувьчлан өгөх хэмжээ, үнэ, хэлбэр зэргийг тодорхой тусгаагүй учир өмчийг шилжүүлэх тухай гэрээг ахин хийх шаардлага гарсан байна. Менежментийн гэрээнд дээрхи нөхцөлүүд бүрэн тусгагдсан бол зөвхөн гэрээг дүгнэсний үндсэн дээр гэрээлэгч өмчийг шилжүүлэн авах шаардлага хангасан эсэхийг тогтоох учиртай байжээ.

Гэхдээ энэ нөхцөлд өмч шилжүүлэх тухай гэрээг иргэний хууль болон төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль эд зүйлийн ердийн худалдах, худалдан авах гэрээ болон зээлээр худалдах, худалдан авах гэрээний алинаар ч хийж болох юм.

5. Нийгмийн салбарын хувьчлалын тухай хууль батлагдан гараагүй боловч төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд засгийн газар тус театрыг туршилтын журмаар хувьчлах тухай шийдвэрийг гаргасны үндсэн дээр хувьчлал явсан тул төрийн өмчийн хороо хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд гэрээний үр дүнг харгалзан өмчийг шилжүүлэн өгөх нь хуульд харшлах зүйлгүй.

Түүнчлэн Улсын их хурлын 2001 оны 10-р тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай" тогтоолд нийгмийн салбарын өөрчлөн байгуулалт, хувьчлалын хүрээнд хийх арга хэмжээний эцэст эд хөрөнгө, хөрөнгийн эрх хувийн өмчид шилжихгүй гэж тусгасан боловч энэ тогтоол нь буцаж үйлчлэхгүй.

Хууль зүйн албаны
мэргэжилтэн.....С.Энхтуул

Тодруулга-9

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭДИЙН ЗАСАГ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА П.ГАНСҮХ ТАНАА

2001-08-06

Улаанбаатар хот

Гэгээрлийн сайдын 1999-оны 06-р сары 08 өдрийн 117-р тоот тушаалаар батлагдсан „Менежментийн гэрээний биелэлтэнд тавьж, гэрээний эцэст Улсын Хүүхэд Залуучуудын Театр, Киноны Хүрээлэнгийн өмч хөрөнгийг хэрхэх талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий аудитын комисс,-ын шалгалтын дүнг Танд хүргүүлж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Төрийн өмчийн хорооны 2001 оны 07-р сарын 19 өдрийн 234/163 тоот хамтарсан тушаалаар батлагдсан ажлын хэсэгт Хүүхэд Залуучуудын Театрын Менежментийн болон Түрээсийн гэрээний биелэлтэнд үнэлгээ өглөө.

Ажлын хэсэг, аудитын комисс 2001 оны 07-р сарын 19-23 өдрүүдэд тус театр дээр ажиллаж гэрээний биелэлтэнд үнэлгээ өглөө.

Аудитын үнэлгээг үзүүлбэл:

- Эхний үнэлгээ 2,328 оноо
- Дунд шатны үнэлгээ 2,185 оноо
- Төгсгөлийн шатны үнэлгээ 2,078 оноо
- Эцсийн нэгдсэн үнэлгээ 2,149 оноо

$/2,328*0,2+2,185*0,2+2,078*0,6=2,149/$

Дээрх үнэлгээнээс үзэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай байгуулсан гэрээний биелэлт сайн байна гэж үзэх үндэслэл байгаа тул Гэрээний 7-р зүйл заасны дагуу асуудлыг шийдэхийг аудитын комиссоос зөвлөж байна.

А.Э.

Б.Д.

Тодруулга-10

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ ХХК

2001-08-10

№29

Улаанбаатар хот

Хүүхэд залуучуудын театр, киноны хүрээлэнгийн захирал И.Нямгаваа танаа

Хөрөнгө үнэлсэн тухай

Таны тавьсан хүсэлтийн дагуу театр, киноны хүрээлэнгийн барилгын үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

2001-08-09 өдрийн байдлаар энэхүү барилгын үнэ 204,656,4 мянган /хоёр зуун дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөг болохыг тодорхойлов.

Захирал

Ж.Чулуунбат

- Хүүхэд залуучуудын театрт туршсан менежментийн болон түрээсийн гэрээний биелэлт, түүнд хийсэн дүгнэлт

Менежментийн гэрээ хэрэгжиж эхэлсний дараагаар батлагдан гарах ёстой "Нийгмийн салбарыг хувьчлах тухай хууль" эвслийн засгийн газар удаа дараа солигдож байсны улмаас батлагдаагүй билээ. Ингэж нэг талаас театрыг хувьчилж

авсан субъект болох менежментийн багийн эрх зүйн статус нь тодорхойгүй, үүнээс үүдэн тус баг нь улс хооронд болон дотооддоо хөрөнгө оруулалт, бизнес, аж ахуйн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцож, санхүүгийн хариуцлага хүлээх эрх зүйн бүрэн хэмжээний чадамжгүй байсан, нөгөө талаас хөрөнгө оруулагчдын зүгээс театрт оруулсан хөрөнгөө буцааж авах тухай хууль зүйн баталгаа байхгүй байсан зэрэг бодитой хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг уг театрт татан оруулах боломж хэрэг дээрээ үгүй болж, менежментийн энэхүү гэрээ нь бүрэн хэмжээгээр хэрэгжиж хараахан чадаагүй байна.

Менежментийн болон түрээсийн гэрээнүүд нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн хүрээнд хэрэгжих тал дээрээ нэлээд эрсдэлтэй хийгдсэн гэрээ юм. Өөрөөр хэлбэл, эдгээр гэрээгээр өмчлөгчийн эрхийг хэт нэг тал руу барьж, гэрээлэгчийн зүгээс бүрэн бие даасан үйл ажиллагаа явуулах хууль зүйн баталгаа болсон өмчлөх эрхийг нь өгөөгүйгээр барахгүй, олон тооны нэмэлт нөхцөл, болзлуудаар хязгаарлалт тавин, эдгээр гэрээг хийжээ.

Нөгөө талаас эдгээр гэрээнд эдийн засгийн макро орчны нөлөөллийг хэрхэн тооцох талаар тодорхой заалтууд тусгагдаагүй учраас энэ хугацаанд гарсан үнийн өсөлт, дулаан, цахилгааны үнийн чөлөөлөлт зэрэг нь Гэрээлэгчийн үйл ажиллагаанд нэмэлт ачаалал үүсгэж, санхүүгийн багагүй бэрхшээл учруулсан байна.

Менежментийн болон түрээсийн эдгээр гэрээний хүрээнд "төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэр, аж ахуйн газруудад гадаад, дотоодын хөрөнгө оруулалт хийгддэггүй бөгөөд улсын төсвийн ачааллыг дорвитой бууруулах боломжгүй..." гэсэн бодит баримт, гол дүгнэлтийг нийгмийн салбарын хувьчлалын цаашдын практикт сайтар бодолцож, тооцож байх шаардлага амьдралаас урган гарч байна.

Дэлхийн нийтлэг жишгээр зах зээлийн хөгжингүй орнуудад ч соёл урлагийн салбар нь өөрөө нэлээд эрсдэлтэй салбарт багтдаг болохыг бодолцон, нөгөө талаар манай орны нөхцөлд арилжааны маш хязгаарлагдмал боломж бүхий соёл урлагийн салбарыг зохих урьдач нөхцөл, эрх зүйн зохицуулалтын орчин нь бүрдээгүй байхад төсвийн татааснаас салгаж, театрын гадаад, дотоод орчны бүх эрсдлийг Менежментийн багт бүхэлд нь үүрүүлсэн нь нэлээдгүй аз туршсан алхам болсон бөгөөд цаашид энэ туршилтыг өргөн цар хүрээтэй хэрэглэх боломжгүй гэж үзэж байна.

Өнөөгийн байдлаар 2001 оны 4 дүгээр сараас он дуустал, 2002 оны улсын нэгдсэн төсөвт тус театрт зориулан ямарч зардал төсөөлөөгүй байна. Иймд, хэрэв өмчлөлийн асуудал цааш шийдвэрлэгдэхгүй удах юм уу, эсвэл уг асуудал театрын их засвар, хөрөнгө оруулалтад бодитой ахиц гарахгүй байдлаар шийдэгдэхэд хүрвэл театрын барилгын халаалт, дулаан болон ашиглалтын бусад нөхцлүүд ххагдан бүрэн зогсоход хүрч, энэ утгаараа барилгын үнэ цэнэ улам унаж, төр хувьчлалаас олох орлогоо бүрэн алдах эрсдэл учирч болзошгүй юм.

Хэрэв улс өөрийн залуу үеийнхээ оюун санааны хөгжил, төлөвшил хүмүүжилд нь анхаарал тавьж ажиллая л гэж бодож байгаа юм бол засаг төсөөсөө мөнгө хөрөнгө гаргах л хэрэгтэй болно. Хэрэв энэ нь боломжгүй бол төр өөрийнхөө эд хөрөнгө, хөрөнгийн эрхээ хувийн хэвшилд зоригтой шилжүүлж, бизнесийн бусад төрлүүдийг хөгжүүлэх замаар соёл урлагийн үндсэн салбараа авч явах тэр боломжийг нь уг гэрээлэгчид олгох нь зүйтэй юм. Гэхдээ энд анхаарах нэг чухал зүйл бол төр өөрийн өмч хөрөнгөө менежментийн баг, төрийн бус байгууллага зэрэг эрх зүйн статус нь бүрэн тодорхой бус, соёл урлагийн тухайн салбар байгууллагын үйл ажиллагааны төлөө санхүү эд хөрөнгийн хариуцлага хүлээх чадваргүй тийм субъектүүдэд шилжүүлэх биш, харин хууль эрхийн хувьд нэгэнт хэвшиж тогтсон статустай, эдийн засаг санхүүгийн хувьд хангалттай чадамжтай тийм аж ахуйн нэгжүүдэд уг эрхийг шилжүүлэн өгөх нь зүйтэй юм. Энэ бол уг хувьчлал амжилттай хэрэгжиж, монголын нийгэмд ашиг тусаа өгөхийн зохих баталгаа юм.

Хүүхэд залуучуудын театрын хувьчлалын, улмаар цаашдын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг цаг алдалгүй, зүй зохистойгоор эцэслэн шийдвэрлээгүй тохиолдолд уг гэрээнүүд нь дангаар цуцлагдахад хүрч, эдгээр хэрэгжүүлэх зорилгоор өнгөрсөн хугацаанд менежментийн багаас гарсан зардлуудыг төрийн зүгээс нөхөн төлөх эрсдэл учирч болзошгүй байдалд хүрээд байна.

Ажлын хэсгээс үүсэн бүрэлдсэн энэ бүх нөхцөл байдлыг сайтар бодолцож, тооцох үндсэн дээр БСШУЯ, ТӨХ-ноос Хүүхэд Залуучуудын Театрын Менежментийн багтай байгуулсан менежментийн болон түрээсийн гэрээний биелэлтийн явц үр дүнг үнэлж,

тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар дараах санал дүгнэлтийг Төрийн өмчийн хорооны хуралд оруулан шийдвэрлүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

1. Менежментийн гэрээний үүргүүдийн нэгдсэн үнэлгээг 81,4% буюу „сайн,, гэж дүгнэв.
2. Иймд менежментийн гэрээний хавсралт №2-т зааснаар Гэрээлэгч нь үйл ажиллагааны үзүүлэлтийн матрицын дагуу 2,149 оноо авсан тул өмчийг шилжүүлэн авах болзол (1,0-2,5 байх ёстой)-ыг хангасан байна гэж үзэв.
3. Монголын хүүхэд, залуу үеийн оюуны хөгжил, төлөвшлийг хангах зорилгод нийцүүлэн, ХЗТКХүрээлэнгийн барилгыг 204.646.400 /хоёр зуун дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөгөөр Монгол Улсын Иргэний хуулийн 217-р зүйлд заасны дагуу 2008 он хүртэл цуеуулж төлөх, театрын барилгад их засвар хийж, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг цаашид хадгалах болзлоор түүнийг Хүүхэд Залуучуудын Театрын менежментийн баг /И.Нямгаваа/-ийн өмчлөлд шилжүүлэх
4. Тус театр киноны хүрээлэнгийн одоо ашиглаж байгаа барилгын талаархи Дэд бүтцийн улсын хяналтын албаны болон Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн техникийн акт, дүгнэлтүүд нь уг барилгыг цаашид нийтийн зориулалтаар ашиглаж болохгүйгээр гарсан учир барилгыг урлаг соёлын өндөр түвшинд бүтээлээ туурвин, хүүхэд залуучуудын өнөөгийн оюун санаанд дорвитой хувь нэмэр оруулсан, ур чадварын хувьд орчин үеийн шаардлага, үзэгчдийн эрэлт хэрэгцээг хангаж, театр, киноны шинэ чиглэлийг тодорхойлсон мэргэжлийн уран бүтээл, техникийн төв болгох зорилгоор их засвар хийж өргөтгөн шинэчлэх, түүнд шаардагдах хөрөнгийн асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх
5. Театрын их засвар хөрөнгө оруулалтын төсвийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн зохих баталгааг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын маркетинг, зуучлалд мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор ТӨХ-ноос төрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж ажиллуулах нь зүйтэй гэж үзэв.
6. „Тэмүүжин Арт театр, үйлчилгээний цогцолбор байгуулах* төслийг нарийвчлан боловсруулж, 2001-2003 онд хэрэгжүүлэн, үр дүнг БСШУ-ны сайдын зөвлөл болон Төрийн өмчийн хорооны хуралд 2004 оны 1-р улиралд багтаан танилцуулахыг ТӨХ-ноос томилогдсон төрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, ХЗТ /И.Нямгаваа/ нарт даалгах болно.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Баярсайхан

Төрийн өмчийн хорооны ӨХГ-ын
Банк, санхүү, нийгмийн салбарын
Хувьчлалын албаны дарга

Гишүүд:

Ц.Энхбат

БСШУЯ-ны Соёл урлагийн бодлого

Зохицуулалтын газрын орлогч дарга

К.Жапах

БСШУЯ-ны Эдийн засаг, хяналт

Шинжилгээ, үнэлгээний газрын

Ахлах мэргэжилтэн

З.Оюунбилэг

БСШУЯ-ны Соёл урлагийн бодлого

Зохицуулалтын газрын мэргэжилтэн

Б.Рэнцэнбазар

ТӨХ-ны Төрийн өмчийн бүртгэл,

Хяналтын газрын мэргэжилтэн

Ц.Отгонбаяр

ТӨХ-ны Өмч хувьчлалын газрын

мэргэжилтэн

➤ **2001.08.30 Монгол улсын БСШУЯ-наас ТӨХ –нд ирүүлсэн албан бичиг дугаар № 1а/3964**

Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж танаа

Хүүхэд залуучуудын театр, киноны
хүрээлэнгийн хувьчлалын тухай

БСШУ-ны сайд, ТӨХ-ны даргын 2001 оны хамтарсан 234/163 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Улсын хүүхэд залуучуудын театр, киноны хүрээлэнгийн менежментийн багаас Гэгээрлийн яам, ТӨХ-той 1999 онд 3 жилийн хугацаатай байгуулсан менежментийн болон түрээсийн гэрээний биелэлтийг шалгаж, менежментийн гэрээнд тусгагдсан үзүүлэлтүүдийн 81,4%-ийг биелүүлсэн гэсэн дүгнэлт гаргажээ.

Театрын менежментийн баг гэрээнд заасны дагуу үзэгчдийн таашаалд нийцсэн шинэ уран бүтээл туурвиж, урын сангаа баяжуулах, бүтээлийн уран сайхны түвшинг дээшлүүлэх, гадаад орнуудад сурталчлах, театрын дэргэд уран бүтээлчдийг бэлтгэх, туршилтын студи нээх, уран бүтээлчдийн хөдөлмөрийн хөлсийг бүтээсэн дүр, тоглолтын тоо, чанартай холбохын тулд гэрээтэй ажилладаг журамд шилжих зэрэг нилээд ажил зохиожээ. Ингэснээр ажиллагсадын орон тоо, зардал хэмнэх зарим боломжийг бүрдүүлсэн боловч тоглолтын тоо эрс багассан байна.

Хүүхэд Залуучуудын Театрын барилга нь 1970-1980аад онд 20 гаруй жилийн хугацаанд барилгын үйлдвэрлэлийн технологи зөрчигдөж баригдсан бөгөөд ашиглалтанд орсноос хойших 25 жилийн турш их засвар хийгдээгүйгээс хувьчлалд хамрагдах үед барилга, тохижилтын хувьд үр ашигтай менежмент явуулахад тохиромжгүй байсан учраас гадаад дотоодын хувийн компаниудын хөрөнгө оруулалтаар өргөтгөл, их засвар хийлгэхээр менежментийн гэрээнд тусгасан юм. Гэвч хувийн компаниудаас төрийн өмчийн байгууллагад хөрөнгө оруулалт хийх эдийн засаг, эрх зүйн тааламжтай орчин бүрдээгүйгээс урлагийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн үйлчилгээний үр ашигтай шинэ хэлбэрүүдийг нээж, орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар ажиллах материаллаг нөхцлийг бүрдүүлэх талаар гэрээнд заасан үүрэг бүрэн биелэгдээгүй байна.

Тус театрын барилгыг нийтийн зориулалтаар цаашид ашиглах боломжгүй, иж бүрэн засвар хийх шаардлагатай гэсэн Дэд бүтцийн улсын хяналтын албаны 171-р техникийн дүгнэлт 2001.08.01 өдөр гарсан байна. Тус театрын барилгад их засвар хийхэд мэргэжлийн байгууллагын үнэлгээгээр даруй 1,15 тэрбум төгрөг шаардагдах тооцоо гарч байгаа бөгөөд уг хөрөнгийг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх боломжгүй юм.

Тус театр нь менежментийн хувьчлалд хамрагдсан 1999 оноос эхлэн улсаас авах санхүүжилтийг жил бүр 20-80% хүртэл бууруулсаар ирсэн ба менежментийн гэрээний хугацаанд улсад 68,4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, 2001 оны 4-р сараас эхлэн улсын төвлөрсөн төсвөөс авалгүй ажиллаж байгаа боловч шинэ уран бүтээлийг хүүхэд залуучуудын нийтийн хүртээл болгох, үйл ажиллагаагаа хэвийн явуулах санхүүгийн боломж хязгаарлагдмал хэвээр байна. Гэвч тус яамны 2002 оны төсвийн төсөлд ХЗТ-т улсын төсвөөс санхүүжилт олгохоор төсвөлөгдөөгүй юм. Тус театрыг төсөвт байгууллага болгоход хүрвэл 2002 оноос эхлэн жил бүр 100-110 сая төгрөгийн нэмэлт ачаа улсын нуруун дээр ирэх болно.

Иймд тус театрын үйл ажиллагааг цаашид зах зээлийн харилцааны шаардлагын дагуу үр ашигтай явуулахын тулд барилга бусад эд хөрөнгийг хувьчлах асуудлыг одоо мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн салбарын өмч хувьчлалын нийтлэг жишгийн дагуу оновчтой шийдвэрлэх нь зүйтэй гэж үзнэ.

Тус яам Улсын хүүхэд залуучуудын театр, киноны хүрээлэнгийн барилга, эд хөрөнгөд эрх бүхий байгууллагаар дахин үнэлгээ тогтоолгож, түүнийг Монгол улсын Иргэний хуулийн 217 дугаар зүйлд заасны дагуу тодорхой хугацаанд цувуулж төлөх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг хэвээр хадгалан, хүүхэд залуучуудын оюун санааны өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, уран сайхны түвшин өндөр бүтээл туурвих чадвартай урлагийн орчин үеийн театр үйлчилгээний төв болгон өөрчлөн байгуулах үндсэн болзолтойгоор хувийн өмчлөлд шилжүүлэх бодлогыг баримталж байна.

Улсын хүүхэд залуучуудын театр, киноны хүрээлэнгийн барилга, өмч хөрөнгийг оновчтой арга хэлбэрээр хувьчлах талаар холбогдох шийдвэр гаргана гэдэгт найдаж байна.

Сайд А.Цанжид

➤ 2001.09.13 Монгол улсын төрийн өмчийн хорооны хурлын тэмдэглэлээс

Төрийн өмчийн хорооны 2001 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэл № 142

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хүүхэд залуучуудын театрын Менежментийн болон Түрээсийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. "...Гэрээлэгч /түрээслэгч/-тэй урьдчилан тохиролцох үндсэн дээр Хүүхэд залуучуудын театрын Менежментийн болон Түрээсийн гэрээнд Хүүхэд залуучуудын театр, киноны хүрээлэнгийн хөрөнгийг Гэрээлэгч /түрээслэгч/-ийн өмчлөлд үнэ төлбөртэйгөөр шилжүүлэхтэй холбогдуулан Гэрээний 2.5.1-д заасны дагуу зохих өөрчлөлт оруулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б. МИШИГЖАВ, Төрийн өмчийн хорооны Өмч хувьчлалын газрын дарга Б. ЦЭЦЭГ-ОЧИР нарт даалгах.
2. Гэрээнд заасны дагуу Хүүхэд залуучуудын театр киноны хүрээлэнгийн барилгад хөрөнгө оруулалт хийхийг Гэрээлэгч /түрээслэгч/-д зөвшөөрөх
3. Улсын Хүүхэд залуучуудын театр киноны хүрээлэнгийн эд хөрөнгийн цогцолборыг Гэрээлэгч /түрээслэгч/-ийн өмчлөлд шилжүүлэх асуудлыг зохих журмын дагуу нарийвчлан боловсруулж, Төрийн Өмчийн хорооны хуралд 2001 оны 9 дүгээр сарын 20-ны дотор оруулж шийдвэрлүүлэхийг Өмч хувьчлалын газар /Б. ЦЭЦЭГ-ОЧИР/, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Төрийн өмчийн хорооны хамтарсан ажлын хэсэг /Д. БАЯРСАЙХАН/-т даалгав....." гэжээ.

Тамгын газрын дарга

Г. ЦЭНДСУГАР

➤ 2001.09.17 өдөр И. Нямгаваагийн ТӨХ - нд албан ёсоор гаргасан барилга, эд хөрөнгийн үнийн талаар гаргасан хүсэлт:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Дэд Бүтцийн Улсын Хяналтын Албаны 2001 оны 08 сарын 01-ний өдрийн 171 дүгээр техникийн дүгнэлтээр "Уг барилгын буурь хөрсөнд инженер геологийн нарийвчилсан шинжилгээ болон хийц бүтээцийн төлөв байдалд нарийвчилсан судалгаа хэмжилт, инженерийн иж бүрэн тооцоог хийсний үндсэн дээр барилгыг бат бэх тогтвортой найдвартай ажиллуулах хүчитгэл бэхэлгээний зураг төсөл боловсруулж бэхлэх арга хэмжээг авах шаардлагатай. Иймд барилгын ашиглалтыг зогсоож, бүх бэхлэгээ хүчитгэлийг хийж Монгол улсын Барилгын тухай хуулийн 8.1.1 заалтын " Барилга байгууламжид хүний ажиллах, амьдрах таатай нөхцөл бүрдүүлж, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байх" шаардлагыг болон даацын хийцийн бат бэх, тогтворыг хангасны дараа барилгыг ашиглах нь зүйтэй" гэсэн дүгнэлт гарсан юм.

Барилгын ашиглалтын талаар гарсан дээрх дүгнэлтийг үндэслэн Хүүхэд залуучуудын театр Киноны Хүрээлэнгийн хүсэлтээр барилгын өнөөгийн зах зээлийн үнийг тодорхойлох зорилгоор "Хөрөнгийн үнэлгээний төв" ХХК-иар үнэлгээ хийлгэхэд 2001 оны Наймдугаар сарын 08-ны байдлаар тус барилгын үнэ 204 656 400 /хоёр зуун дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөг болохыг тогтоосон юм.

Иргэн Ичинхорлоогийн Нямгаваа би Хүүхэд залуучуудын театр Киноны Хүрээлэнгийн барилга, эд хөрөнгийг 204 656 400 /хоёр зуун дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөгөөр 3 жилийн хугацаанд төлөх нөхцлөөр худалдаж авах боломжтой гэж үзэж байгаа бөгөөд үүнээс үүдэн гарах үүрэг, хариуцлагыг бүрэн хариуцах болно.

Та бүхнийг хүндэтгэн ёсолсон: И. НЯМГАВАА

- 2001.09.17 Хүүхэд залуучуудын театрын түрээсийн гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт

Төрийн өмчийн хорооны дарга, Хүүхэд залуучуудын театрын гүйцэтгэх захиралтай байгуулсан Түрээсийн гэрээ /цаашид Гэрээ гэх/-нд уг гэрээний 2.6.1-д заасныг үндэслэж, Төрийн өмчийн хорооны 2001 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 142 тоот тэмдэглэлийн дагуу дараах нэмэлт өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

Нэг.

- 1.1 Гэрээнд <<Хүүхэд залуучуудын театр "....төрийн бус байгууллага...." гэснийг ".....И. Нямгаваа....." >> гэж өөрчлөв.
- 1.2 Гэрээний 1 дүгээр зүйлийн 5 дахь догол мөрөнд <<"Төрийн бус, ашгийн төлөө бус байгууллага" гэж Монгол Улсын "Төрийн бус байгууллагын тухай хууль"-ийн 6-р зүйлийн дагуу байгуулагдсан, үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг, гишүүддээ ногдол ашиг хуваарилдаггүй байгууллагыг хэлнэ>> гэснийг хасав.
- 1.3 Гэрээний 2.3.1. дүгээр зүйлийн 2 дахь догол мөрний 3 дахь өгүүлбэрийг хасав.
- 1.4 Гэрээний 2.5.-ын "в" заалтыг хасав.
- 1.5 Гэрээний 2.6.3-ын "а" заалтыг хасав.
- 1.6 Гэрээний 7.1-ийн эхний догол мөрний 3 дахь өгүүлбэр дэх <<.....7.2-т заасан хязгаарлалттайгаар>> гэснийг хасав.
- 1.7 Гэрээний 7.1-ийн эхний догол мөрний 4 дахь өгүүлбэр дэх <<".....эзэмшилд үнэ төлбөргүй....." гэснийг ".....өмчлөлд зохих үнэ төлбөртэйгөөр " >> гэж өөрчлөв.
- 1.8 Гэрээний 7.2-ын эхний догол мөрний 2 дахь өгүүлбэр дэх <<"....эзэмшилд...." гэснийг ".....өмчлөлд.....">> гэж өөрчлөв.
- 1.9 Гэрээний 7.2-ын эхний догол мөрний 2 дахь өгүүлбэр дэх <<".....үнэ төлөхгүй шилжүүлэн авах....." гэснийг ".....зохих үнэ төлбөртэйгөөр шилжүүлж авна.....">> гэж өөрчлөв.
- 1.10 Гэрээний 7.2-ын эхний догол мөрний 2 дахь өгүүлбэр дэх <<".....боловч.....">> гэснээс хойшхи өгүүлбэр дуусталх хэсгийг хасав.
- 1.11 Гэрээний 7.2-ын эхний догол мөрний үргэлжлэл 2,3,5 дугаар өгүүлбэрүүдийг тус тус хасав.

Гэрээ байгуулсан:

Төрийн өмчийн хорооны дарга

Иргэн

Ё. ГЭҮҮҮҮҮ

Ё. ЫҮҮҮҮҮҮ

- 2001.09.18 Төрийн өмчийн хорооны хурлаар хэлэлцүүлэх санал

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 61 дүгээр зүйл, Гэгээрлийн яам, Хүүхэд Залуучуудын театрын хооронд байгуулсан Менежментийн гэрээний биелэлтийг шалгасан Аудитын комиссын дүгнэлт, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд, Төрийн өмчийн хорооны даргын 2001 оны 234/163 тоот хамтарсан тушаалаар томилогдсон ажлын хэсгийн дүгнэлт болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 1а/3964 тоотыг үндэслэн Улсын Хүүхэд Залуучуудын театр киноны хүрээлэнгийн эд хөрөнгийн цогцолборын хөрөнгийг хувийн өмчлөлд шилжүүлэх шаардлагатай болсон юм.

Менежментийн гэрээнд зааснаар бол уг эд хөрөнгийн цогцолборыг ашгийн төлөө бус этгээд "Хүүхэд залуучуудын театр" төрийн бус байгууллагад үнэ төлбөргүйгээр зохих хязгаарлалттайгаар шилжүүлэх ёстой байсан. Гэтэл эрх зүйн зохих

нөхцөл бүрдээгүй гэсэн үндэслэлээр Хууль зүйн яам энэхүү төрийн бус байгууллагыг Улсын бүртгэлд бүртгэгдээгүй болно.

Иймд Монгол улсын хууль болон бүрэлдэн бий болсон бодит нөхцөл байдалд нийцүүлэн Хүүхэд залуучуудын театр киноны хүрээлэнгийн эд хөрөнгө цогцолборын хөрөнгийг иргэн И. Нямгаваагийн өмчлөлд зохих үнэ төлбөртэйгөөр шилжүүлэх шаардлага гарч ирсэн байна.

Тодруулга-11

Монгол улсын засгийн газрын тохируулагч агентлаг
ДЭД БҮТЦИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН АЛБА

2001-09-18

Дугаар 1/618

улаанбаатар-46

факс: 323867

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНД

Хүүхэд залуучуудын театр киноны хүрээлэнгийн барилга байгууламжийн үнэлгээтэй таны хүсэлтийн дагуу анхааралтай танилцлаа.

Дээрх үнэлгээнд барилга байгууламжийн чанарын түвшинг тусгай зөвшөөрөлтэй байгууллага, хүмүүсээр хийлгүүлж тогтоолгоогүй байна.

Иймд уг үнэлгээг шаардлага хангахгүй гэж үзэж байна.

Дарга

Н.Лхагваа

Төрийн өмчийн хорооны 2001 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 142 дугаар тэмдэглэлийн дагуу 1999 оны 02 дугаар сарын 05-нд байгуулагдсан Хүүхэд залуучуудын театрын Менежментийн болон Түрээсийн гэрээнд зохих өөрчлөлтийг оруулж, хууль зүйд нийцүүлэх арга хэмжээ авсан болно.

Иргэн И. Нямгаваагаас Улсын Хүүхэд залуучуудын театр киноны хүрээлэнгийн барилга, эд хөрөнгийн үнэ төлөх нөхцлийн талаар Төрийн өмчийн хороонд 2001 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн бичгээр тус хүрээлэнгийн эд хөрөнгийн цогцолборын хөрөнгийн үнийг "Хөрөнгийн үнэлгээний төв" ХХКомпаниас 2001 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар үнэлсэн үнэ болох 204 656 400 /хоёр зуун дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөгийг 3 жилийн хугацаанд төлөх нөхцөлөөр хүлээн зөвшөөрч, үүнээс үүдэн гарах үүрэг хариуцлагыг бүрэн хариуцахаа мэдэгдсэн болно.

Ингэж Гэрээлэгч талууд болох нэг талаас Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Төрийн өмчийн хороо, нөгөө талаас иргэн И.Нямгаваа нар Улсын Хүүхэд залуучуудын театр киноны хүрээлэнгийн өмч хөрөнгийг зохих үнэ төлбөртэйгөөр иргэн И.Нямгаваагийн өмчлөлд шилжүүлэх талаар нэгдсэн тохиролцоонд хүрсэн тул уг асуудлыг Төрийн өмчийн хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр оруулж байна.

Төрийн өмчийн хорооноос гарах тогтоолын төслийг хавсаргав.

Танилцсан:

Өмч хувьчлалын газрын дарга

Б. Цэцэг-Очир

Танилцуулга бичсэн:

ӨХГ-ын мэргэжилтэн

Д. Баярсайхан

➤ **Менежментийн гэрээний үр дүнг харгалзан өмчлөгчийн эрх олгох тухай**

"Иргэний хууль"-ийн 217 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 61 дүгээр зүйл, Гэгээрлийн яам, Хүүхэд залуучуудын театрын хооронд байгуулсан менежментийн гэрээний биелэлтийг шалгасан Аудитын комиссын дүгнэлт, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд, Төрийн өмчийн хорооны даргын 2001 оны 324/163 тоот хамтарсан тушаалаар томилогдсон ажлын хэсгийн дүгнэлт, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2001 оны 1а/3964 тоот, иргэн И. Нямгаваагаас Хүүхэд

залуучуудын театр, киноны хүрээлэнгийн барилга, эд хөрөнгийн үнийн тухай Төрийн өмчийн хороонд ирүүлсэн бичиг, Төрийн өмчийн хорооны 2001 оны 142 дугаар тэмдэглэлийн дагуу Хүүхэд залуучуудын театрын Менежментийн болон Түрээсийн гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

- 1. Улсын Хүүхэд залуучуудын театр, киноны хүрээлэнгийн эд хөрөнгийн цогцолборыг 204 656 400 /хоёр зуун дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөгөөр үнэлж, И.Нямгаваагийн эзэмшилд шилжүүлсүгэй.**
- 2. Театрын барилгад их засвар хийж, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг цаашид хадгалах ба хөрөнгийн үнийг 3 жилийн хугацаанд төлөх болзолтойгоор "Монгол Улсын Иргэний хууль"-ийн 217 дугаар зүйл, ТОНӨТХ-ийн 61 дүгээр зүйлд заасны дагуу И. Нямгаваатай " Улсын Хүүхэд залуучуудын театр, киноны хүрээлэнгийн эд хөрөнгийг зээлээр худалдах, худалдан авах гэрээ" байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Өмч хувьчлалын газар /Б. Цэцэг-Очир/-т даалгасугай.**
- 3. Гэрээний биелэлтийн талаар хагас жил тутамд мэдээлж ажиллахыг Өмч хувьчлалын газар /Б. Цэцэг-Очир/-т даалгасугай.**

Дарга

Л. ПҮРЭВДОРЖ

Тамгын газрын дарга

Г. ЦЭНДСУГАР

ХЗТ-ийн хувьчлалын зорилго, үе шатуудыг дүгнэн үзэхэд:

Нийгмийн салбарын хувьчлалын хүрээнд Хүүхэд залуучуудын театрыг менежментийн хувьчлалд хамруулахдаа уг нийгмийн салбарын хувьчлалын асуудал анхнаасаа бэлтгэл ажил буюу судалгаа муу хийгдсэн, ямар бодлого баримтлах нь тодорхой бус, засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудын ажлын уялдаа холбоо муу, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын хариуцлагагүй хандсан зэрэг шалтгаануудаас болон хувь хүний хүсэл санаачлагаар шудрага бус өрсөлдөөний дунд хувьчлалын тендерийг явуулсан нь хувьчлалын үндсэн зорилгыг алдагдуулсан байна.

Энэ нь тухайлбал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн үзэл баримтлалаас хазайж, менежментийн багийг ТББ, төсвийн байгууллага мэт ойлгосон буюу хольж хутгасан байдал нь тендерийг зарлахаас өмнө асуудлыг сайн бодож боловсруулаагүй буюу тухайн салбарын хувьчлал бусад хувьчлалаас ялгагдах онцлог зэргийг бодолцож үзээгүй байна.

ТТБ-ын Удирдах зөвлөлд Гэгээрлийн яам болон ТӨХ-ны төлөөлөгчдийг оруулсан байдал нь сонирхлын зөрчлийг бий болгосон байна. Менежментийн гэрээ, санхүүжилтийн асуудал хоёрыг сайтар ялгаж зааглаагүйн улмаас улсын төсвийн мөнгө гэрээлэгчийн хувийн мөнгө хольж хутгалдсан гэрээнээс гадуур хувиасаа санхүүжилт гаргасан, түүнийгээ явцын дунд Гэгээрлийн яам ТӨХ-ноос нэхэмжилсэн зэрэг асуудлуудаас харахад хувьчлал нь ямар ч хяналт шалгалт, бодлогогүй байгаа нь харагдаж байна.

Менежментийн гэрээний биелэлтэнд өгсөн үнэлгээнүүд хоорондоо зөрчилдөж, хувьчлалын үндсэн зорилгоо биелүүлээгүй нөхцөлд тухайлбал тоглолтын тоо эрс буурсан, шинээр хийсэн ур бүтээл байхгүй, орлогоороо зарлагаа нөхөх зарчим алдагдсан, түүнчлэн жүжигчидгүй театар болсон байхад үнэлгээ нь 81 хувь байгаа байдал хэн нэгний эрх ашгийн төлөө үйлчилж байгаа мэт сэтгэгдэл төрж байлаа.

Зарим тодорхой санал дүгнэлтийг дэвшүүлбэл

- Нийгмийн салбарын хувьчлалын бодлого, үзэл баримтлал, дараалал, туршилт, төлөвлөгөөг тодорхойлсны үндсэн дээр хувьчлалыг явуулж байх
- Менежментийн гэрээгээр талуудын зорилго, эрх, үүрэг хариуцлага, хийх ажлын цар хүрээ, дараалал, зааг ялгааг анхнаас нь маш зөв, тодорхой гаргаж өгч байх.

- "Менежментийн баг" хэмээх ойлголтыг зөв, нэг мөр тодорхойлох. Хууль зүйн агуулгаар "менежментийн гэрээ" нь онцгой авъяас, чадвар, мэдлэг бүхий хувь хүнээр /хүмүүсээр/, ийм хүнээр удирдуулсан байгууллагаар тодорхой оюуны ажил гүйцэтгэх гэрээ юм. Гүйцэтгэгч нь барилгын засвар, газар шорооны ажлаас гадна байгууллагын менежмент, бүтэц, зохион байгуулалт, маркетинг, боловсон хүчний бодлого зэргийг шинэчлэх, сайжруулахад илүү төвлөрч ажиллах учиртайг анхаарах. Иймд менежментийн гэрээг байгуулах, гэрээлэгчийг сонгох, гэрээний биелэлтийг хянах, хэмжиж дүгнэхдээ гэрээний дээрх онцлогийг ямагт харгалзан тусгаж байх нь зүйтэй. Тухайлбал, менеж / багийг хөрөнгө санхүүгийн чадамж, баталгаа, хуулийн этгээдийн статус, ТТБ байх талаас нь бус, мэдлэг чадвар, туршлага талаас нь илүү шаардлага тавих нь зүйтэй.
- Бас менежментийн гэрээ, санхүүжилтийн асуудал хоёрыг сайтар ялгаж зааглах
- ТӨХ, асуудал хариуцсан яам нь менежментийн багтай сонирхолын зөрчилд орохуйц аливаа холбоо харилцаанаас урьдчилан сэргийлэх, багийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаанд оролцохгүйгээр, менежментийн гэрээнд заасны дагуу хөндлөнгөөс хяналт тавьдаг тогтолцоонд шилжих. Хувьчлалын явц, хэрэгжилтийг шалгах, дүгнэх, санал зөвлөмж гаргах зэрэг аудит, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо дээрх шаардлагыг мөн анхаарч, ур чадвар, туршлагатай хүмүүсээр бүрдүүлэхэд анхаарч байх.
- Менежментийн гэрээний зайлшгүй авч үзэж тусгах бас нэг онцлог нь гэрээний хэрэгжилтийн доголдол саатал, алдаа дутагдалыг цаг тухайд нь илрүүлж тогтоох, улмаар шуурхай арга хэмжээ авдаг явдлыг хангах үүднээс чанар, үйл ажиллагааны байнгын мониторингийн механизмыг шаарддаг (тухайлбал, менежментийн / багийн 2000 оны эхний хагас жилийн ажлын тайлангаас менежментийн / баг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон нь харагдаж байна) Түүнчлэн менежментийн багийг өөрчлөх, солих, гэрээнд өөрчлөлт оруулах зэргээр гэрээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн станкцийн шинжтэй эрх мэдлийг төрийн төлөөлөгчид олгох.
- Гэрээний хэрэгжилтийг дүгнэх явцыг гэрээний дагуу хийх ажил, гарах үр дүн тус бүрээр, илүү нээлттэй, гэрээлэгч талууд, хувьчлагдаж буй байгууллагын хамт олны болон олон нийтийн төлөөлөгчдийн хяналт, оролцоотойгоор хийдэг болох.
- Гэгээрлийн яам, нийслэлийн соёлын газар, ТӨХ зэрэг нь менеж / багт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь зохион байгуулалт, мэдээлэл, шаардлагатай үед арга зүйн туслалцааг үзүүлдэг байх (жишээ нь, соёл урлагийн үйл ажиллагааны маркетинг, сурталчилгаа явуулах, гадаад, дотоодын байгууллагатай холбоо тогтооход зэрэгт туслах)
- Дэнчингийн тогтолцоог цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна. 5,0 сая төгрөгийн дэнчин нь ХЗТ-ын хувьчлалд аливаа үр дүн өгөөгүй, хамгаалалтын арга хэрэгсэл болж чадаагүй, өөрөөр хэлбэл, өөрийн үндсэн үүргээ биелүүлж чадаагүй нь тодорхой байна. Харин менежментийн гэрээний зорилго, онцлогтой холбоотойгоор хариуцлагын даатгалын тогтолцоог нэвтрүүлэхээр судалж үзэх нь зүйтэй.
- Менежментийн багийн цалин, урамшууллыг ажил гүйцэтгэсний төлөө төрөөс эрсдлийн үзүүлэлтүүдийг дүгнэсний үндсэн дээр, гэрээгээр тохирсон хэмжээний дагуу олгож байх.